

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ



ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

ДҮТААР 2026 №1 (14)

ᠰᠣᠩᠭᠡᠭᠡᠯᠢᠢᠨ
ᠪᠣᠯᠣᠪᠣᠰᠣᠷᠣᠯ



United Nations
Office on Drugs and Crime



Conference of the States
Parties to the United Nations
Convention against Corruption
15 - 19 December 2025, Doha, Qatar



192 Parties standing #UnitedAgainstCorruption.



www.m-election.mn



GECMongolia



Монгол Улсын Сонгуулийн
ерөнхий хороо

МОНГОЛ УЛС НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ИЛ ТОД
БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, АВЛИГААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ НҮБ-ЫН ТОГТООЛЫГ БАТЛУУЛЛАА

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ЭРХЛЭГЧ

Б.Цэцэгдэлгэр

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан референт-хэвлэлийн төлөөлөгч

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.Ариунболд

Мэдээлэл, судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн

ЗӨВЛӨХ

Ж.Амарсанаа

Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор

ГИШҮҮД

Т.Дорж

Академич, Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, профессор

Ч.Содномцэрэн

Академич, Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны доктор, профессор

Д.Дашпүрэв

Философийн шинжлэх ухааны доктор, профессор

Д.Даваа-Очир

Хууль зүйн доктор, профессор

Д.Гангабаатар

Хууль зүйн доктор, профессор

З.Сүхбаатар

Бизнесийн удирдлагын доктор, профессор

О.Хатанболд

Улс төр судлалын доктор

А.Эрдэнэцогт

Хууль зүйн доктор, профессор

Д.Бат-Эрдэнэ

Хууль зүйн магистр

С.Оюунтуяа

"Сонгогчдын боловсрол төв" ТББ-ын Гүйцэтгэх захирал

Ч.Сайнсанаа

"Чимид сан"-ийн Тэргүүн

С.Уянга

"Сонгуулийн боловсрол" клубийн Удирдах зөвлөлийн ахлагч

АГУУЛГА

4

СОНГУУЛЬД СУРАЛЦАХУЙ

Б.Чимид “Сонгуульд суралцахуй” номоос...

- Улс төрийн нам сонгуульд оролцох

8

ХУУЛЬ ТОГТООМЖ

- Д.БАТ-ЭРДЭНЭ: Сонгогчдын саналыг авах төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэхээр хуулийн төслийн санал боловсруулсан
- Д.ТЭГШБАЯР: НҮБ-ын тогтоол санаачилж, батлуулсан нь Монгол Улсын манлайллыг олон улсад таниулсан

15

ТЭМДЭГЛЭЛТ ОЙ

- “Монгол Улсын үндсэн хуулийн үзэл баримтлал: Ардчилсан сонгууль” сэдэвт шилдэг итгэлийн уралдаан зохион байгууллаа

17

ДУГААРЫН ЗОЧИН

- Б.САРАНТУЯА: Сонгуулийн төв байгууллага хараат бус ажиллах хууль зүйн боломж бий боловч бүрэлдэхүүн, институцийн дотоод бие даасан байдлыг хангах зохицуулалт дутмаг

21

СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙ

- Сонгуулийн байгууллагын дэргэдэх сургалт, судалгааны байгууллагын олон улсын туршлага ба Монгол Улс
- Намын жагсаалт бүхий сонгуулийн тогтолцоонд улс төрийн намын дотоод ардчилал
- Нийслэл, орон нутгийн номын сангийн ажилтнуудыг сонгуулийн боловсрол олгох сургагч багшаар бэлтгэнэ
- Монгол Улсын бүх номын санд “Сонгогчийн булан” ажиллуулна

42

ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ

- “Баримтаар баталгаажуулъя” төслийг ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлнэ
- Манас Адоменас: Сонгуулийн ерөнхий хороог байгууллагын хувьд итгэлтэй, өндөр ур чадвартай, хариуцлагатай түнш гэж үздэг

45

ГАДААД ХАРИЛЦАА, МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

- Тайландын Парламентын сонгуулийг ажиглалаа
- “Ардчилал, сонгуулийн удирдлагын асуудал” сэдэвт олон улсын бага хуралд оролцлоо
- Ө.ЦЭРЭНДОРЖ: Сонгуулийн байгууллага байнга л хардлага, шүүмжлэл дунд ажилладаг

48

СОНГУУЛИЙН ДАТА

- Улс төрийн намын 2025 оны дөрөвдүгээр улирлын хандив
- Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал

51

ДЭЛХИЙН СОНГУУЛЬ

- Гадаад орнуудын Үндсэн хуулиас...
- 2026 онд дэлхийн улс орнуудад болох бүх нийтийн сонгууль



ЗУРГААДУГААР БҮЛЭГ

УЛС ТӨРИЙН НАМ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ*

Бяраагийн Чимид

Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын
Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор
“Сонгуульд суралцахуй” номоос цувралаар хүргэж байна.



6.1 НАМ, ЭВСЭЛ СОНГУУЛЬД ОРОЛЦОХЫН УЧИР

Энд нам гэж юу вэ? гэдгийг биш, харин тэр нь төрийн сонгуульд ямар хамаатай, яагаад түүнд идэвхийлэн оролцдог вэ? гэдгийг авч үзэх нь сэдвийн зорилго юм. Аливаа нам засаг төрийн эрх мэдлийн төлөө, парламентад чадвал олонх, “ядвал цөөнх”, “гацвал” ганц суудалтай болохын төлөө чармайн ажилладаг. Ингэж засгийн эрхийг хэрэгжүүлэхэд оролцох юм уу, эсвэл түүнд улс төрийн хяналт тавьж нөлөөлөх зорилготой учраас түүнийг **улс төрийн байгууллага** гэдэг.

Улс төрийн харилцааны амин сүнс нь засгийн эрх мэдлийг авах, оролцох, хэрэгжүүлэхийн төлөөх хууль ёсны оролцоо буюу тэмцэл мөн.

Иргэд үүний төлөө л үзэл бодол, ашиг сонирхлоор ижилсэн нэгдэж ажилладаг. Энэ бол тэдний улс төрийн үндсэн бөгөөд адил тэгш эрх юм.

Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлээс:

Монгол Улсын иргэн «Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно» (16.10).

Улс төрийн нам бол төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцох гол зорилго бүхий олон нийтийн нэгдэл мөн гэдэг тодорхойлолт ч бий.

Иргэд хэсэг бүлгээрээ улс, түүний нэгжийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагыг өөрсдөө байгуулж өөрсдийн төлөө ажиллуулахын тулд л намд нэгдэн хамтын хүсэл зориггоо илэрхийлэн хууль ёсоор өрсөлдөнө. Харин нам засаг төрийг бүхэлд нь булаан эзэлж, ажил үүргийг нь орлон хийж, бүрэн эрхийг төлөөлөн хэрэгжүүлдэггүй. Засаг төрийн үйл хэрэгт зөвхөн сонгуулийн замаар голлон оролцдог. Ингэхлээр нам болж нэгдэх нь **засгийн эрх, сонгуулийн ардчиллаас** үүдэлтэй юм.¹

Намын тухай хуульд зааснаар 801 ба түүнээс олон иргэн сайн дураараа нэгдэн нам байгуулах гэрээ байгуулж, хөтөлбөр дүрмээ батлан, нам байгуулснаа УДШ-д хянуулан бүртгүүлнэ. Тийнхүү бүртгүүлж гэрчилгээ авснаар намд тооцогдон үйл ажиллагаагаа явуулах эрхтэй болдог. Хууль ёсоор бүртгэгдсэн нам, дангаараа буюу өөр намтай эвсэн нэгэн этгээд болох замаар УИХ, Ерөнхийлөгчийн болон ИТХ-ын сонгуульд нэр дэвшүүлэн түүнийгээ дэмжин оролцдог.

Ургалч ёсны нөхцөл дэх нам бол улс төрийн харилцаанд буюу засгийн эрхийн төлөө өрсөлдөөнд хүн амын зохих бүлэг, хэсэг нэгдэн оролцохын тулд сайн дураараа нэгдсэн иргэдийн байгууллага юм. Иймд сонгуульд нам оролцоно гэдэг эрх тушаалд дуртай хэдэн хүний хуйвалдаан биш, угтаа улс төрийн хүсэл зориг, хууль ёсны ашиг сонирхол нэгтэй хэсэг иргэн нэгдэн оролцдог зохион байгуулалтын томоохон хэлбэр мөн.

¹ “Ардчилал” гэдэг чухамдаа ард түмний засаг (demos kratos) гэсэн утгатай эртний грек гаралтай түүх, гүн ухааны нэр томьёо билээ. Харин энэ нь “монголын ард” гэсэн түүхэн нэр томьёо энэхүү “ардчилал” ба ард түмэн гэсэнтэй яг адил утгатай биш. Үүнийг ялган ойлгох нь төөрөгдлөөс ангижрахад тун ч чухал. “Ард” гэсэн монгол үг нь феодалын нийгэм дэх хүн амын нэг хэсгийн нэршил юм. Хүн амын олонх болох эрх тушаал, тайж язгууртны угсаагүй, харин тэдний хамжлага, албат зарц нарыг бүхэлд нь “базаж” нэрлэдэг ангийн ойлголт байсан. Тэд феодалын ноёрхлын эсрэг тэмцэн хувьсгал хийж засгийн эрхийг үе угсаа залгамжилсан язгууртны ангиас булаан авсны учир “ардын хувьсгал”, “ард анги”, “ардууд” гэсэн үг хэллэг улс төрийн тэмцлийн туг, Монголын нийгэм-улс төрийн амьдралын өнгө аяс болж, олон түмний сэтгэлд хоногшин эзэнэгшсэн түүхтэй. Тэгвэл “ард түмэн” гэдэг нь Public буюу народ гэсэн англи, орос үгтэй дүйдэг, улсынхаа бүх харьяатыг бөөнтүүлэн тэмдэглэдэг хам нэр томьёо юм. Энд бүх иргэн нь анги давхрааны ялгаагүй төр улсынхаа нийгэмшлийн үндэс болдог байна. – Б.Ч.

* Б.Чимид “Сонгуульд суралцахуй”. УБ 2008 117-127 тал

Олон намт нөхцөлд иргэд сонгуульд өрсөлдөн оролцох учир өөр өөрсдийн байгуулсан, элссэн хийгээд эсвэл үзэл бодлого, үйл ажиллагааг нь дэмждэг тэр намын хөтөлбөрийн төлөө нэр дэвших буюу дэвшүүлж өрсөлдөнө. Рестораны цэсэнд нэг хоол бичсэн бол сонголтгүй, хэд хэдэн хоол байгаа бол үйлчлүүлэгч дуртай хоолоо шилж захиална. Хэрэв дуртай нь байхгүй бол орхиод гарч болно гэж нэг судлаач сонгуулийн өрсөлдөөнийг зүйрлэн бичсэнийг санаж байна. Саналаа нэг бол “төлөө”, нэг бол “эсрэг” өгнө, эсвэл хэнийг ч дэмжихгүй орхиж болно гэсэн үг. Аль нэг намыг дэмжихгүй гэвэл **бие даан нэр дэвшигчийг дэмжин оролцох**, эсвэл саналын хуудсанд бичигдсэн хэнд ч санал өгөхгүй орхих нь мөн чөлөөтэй.

Иргэн Та сонгуульд аль нэг нам, эвслийг дэмжих бол бусдынх нь эсрэг байр суурьтай оролцож таарна. Ийм учир нам, эвсэл сонгуульд оролцохын учир утга эрх зүйн үндэс журмыг судалж мэдэх нь зүйтэй. Ялангуяа тэдгээрийн хөтөлбөр, үйл ажиллагааны өнгөрсөн, одоо, ирээдүйн зэрэг сөрөг тал, ашиг тус, үр нөлөөг цэгнэн үзэж сонголтгоо хийвэл илүү оновчтой л доо.

Сонгуульд оролцоно гэдэг нь таамгаар тэмтэрч, бусдыг дагалдан дарвих, наанадаж хэдэн бор төгрөг, аар саар өглөг, аятайхан амлалтад хууртаж ээлж өнгөрөөхийн нэр биш гэдгийг ард олон мэднэ. Хэрэв сонгуульд ингэж хандвал өөрийгөө болон эх орноо хууран мэхэлж буй нүгэлт хэрэг болно. Бузарт автахгүйн тулд нам, эвслийг, түүний өмнөөс нэр дэвшигчдийн үзэл бодол, өнгөрсөн үйл ажиллагааны үр нөлөө, цаашдын хөтөлбөрийг үнэн магадтай, үнэ цэнэтэй эсэхийг судалж, “өөрийн толгойгоор” хэнийг нь дэмжихээ шийдээрэй гэж зөвлөө! Сонгууль бол эзэн хүний хариуцлагатай оролцоо, эцсийн шийдэл мөн шүү.

Таны сонгосон намаас наад зах нь 8 нэр дэвшигч ялбал, Улсын Их Хуралд нэг бүлэг болж, таны дэмжсэн хөтөлбөрийг засаг төрийн бодлогод тусгаж Засгийн газар тэргүүтэй төрийн удирдлагын бүхий л аппаратыг тэр зүгт хуулиар хөтлөн жолоодолцоно. Сонгосны үр ашиг танд өглөгөөр бус, Засгийн газрын үйл ажиллагааны үр дүнгээр дамжин хүрнэ. Нам сонгуульд оролцохын үр дагавар нь танд хэрхэн тусаж холбогдохын гол учир энэ л дээ.

Сонгуульд нам, эвслийн оролцсон байдал (1992–2004 он)

УИХ-ын сонгууль		1992	1996	2000	2004
Оролцсон	Нам	9	5	13	7
	Эвсэл	2	2	3	1

6.2. НАМ, ЭВСЭЛ СОНГУУЛЬД ОРОЛЦОХЫН ТУЛД ЯАХ ЁСТОЙ ВЭ?

Энэ бол гүн ухаан, улс төр, хууль зүй, удирдахуй ухааны нүсэр асуудал л даа. Тэгэвч **зайлшгүй шаардлага** гэж бий.

- Өнгөрсөн сонгуульд оролцсон оноо, алдаагаа шинжилж дүгнэн цэгнэнэ.
- Ирээдүйд ялахын төлөө оролцоно. Үүний тулд:
 - Хөтөлбөр, арга тактикаа боловсруулна.

- Боловсон хүчнээ (хүний нөөцөө) бэлтгэнэ (Нэр дэвшигч, ухуулагч, менежер гэх мэт).
- Эвсэх эсэхээ шийднэ.
- Зорилго, бодлогоо олон түмэнд таниулна.
- Төсөв санхүүгээ бүрдүүлнэ.
- Өөрийгөө болон нэр дэвшигчээ бүртгүүлэхэд үзүүлдэг бичиг баримтаа зэхнэ гэдэг л өөр бусад ажил бий.

Та түүнд гишүүн буюу дэмжигчийн хувиар санаа оноогоо нэмэрлэж бас биечлэн оролцож л таарна. Гэвч энэ бол сонгуульд оролцож буй нь биш, бэлтгэж байгаа нь тэр.

Сонгуульд оролцохын тулд нам яах вэ? **Юуны өмнө хууль ёсоор эрхээ олж авах хэрэгтэй.**

СТХ-ийн 24 дүгээр зүйлээс:

«24.1 Сонгууль зарлахаас өмнө улсын бүртгэлд бүртгүүлсэн нам сонгуульд оролцох эрхтэй.

24.2 Хоёр буюу хэд хэдэн нам сонгуульд эвсэл болж оролцож болох ...

24.3 Нам, эвсэл сонгуульд оролцох тухайгаа санал авах өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ЕХ-нд бичгээр илэрхийлж, албан ёсоор бүртгүүлнэ».

Хэрэв намууд сонгуульд нэгэн **эвсэл** болж оролцох бол Сонгуулийн ЕХ-нд бүртгүүлэхээс өмнө түүнийг СТХ-д зааснаар байгуулж, эвслийн гэрээ байгуулна. Энэ үндсэн дээр Сонгуулийн ЕХ-нд бүртгүүлж “батламж” авснаар эвслийн сонгуульд оролцох эрх үүснэ.

СТХ-нд намууд эвсэл байгуулах гэрээ хийж, эвслээ бүртгүүлэх, төлөөлөн удирдах байгууллагаа байгуулах, эвслийг тараах үндэслэл, журам, эрх зүйн үр дагаврыг тодорхойлсон байна (СТХ- 24, 25, 26).

Намууд эвсэлд нэр нэгдэх асуудлыг тус тусын Их Хурал буюу түүний чөлөөт цагт эрх барих “төлөөлөх² байгууллага” (Бага хурал, ҮЗХ зэрэг)-ын хуралдаанаар хэлэлцэнэ. Уг хуралдаанаар дараах асуудлыг шийдвэрлэнэ:

- эвслийн нэр, сонгуулийн мөрийн хөтөлбөр;
- нам бүрд ноогдох УИХ-ын гишүүний мандатын тоо;
- ноогдсон мандатын тоонд нэр дэвшүүлэх;
- эвсэлд намаа төлөөлөх эрх бүхий төлөөлөгчийг томилох;
- эвслийн гэрээний төсөл зэрэг асуудлыг хуульд заажээ.

2 СТХ-д “төлөөлөх байгууллага” гэсэн нэрийг хууль зүйн нэр томъёоны “яс” утгаар нь ялгаж тодорхойлсонгүй. Хуулийн олон заалтаас үзэхэд төлөөлөх байгууллага гэдэгт лав гурав, дөрвөн өөр байгууллага оржээ. 1) Намын Их Хурлыг “төлөөлөх байгууллага” гэсэн нь Их Хурлын чөлөөт цагт тухайн намын эрх барих (Бага, бүгд хурал, үндэсний зөвлөлдөх хороо г.м) байгууллагыг хэлсэн бололтой. 2) Эвсэл түүнд нэгдэх намуудыг тус тусад нь төлөөлж бусад намтай, эвслийн байгууллагатай харилцах эрх үүрэгтэй “төлөөлөх байгууллага”. 3) Эвслийг бусад этгээдийн өмнө, ялангуяа сонгуулийн хороодын өмнө “төлөөлөх байгууллага” буюу “эвслийн эрх барих байгууллага”. 4) Нам эвслийн сонгуулийн гүйцэтгэх (менежментийн) байгууллагыг нэг нэгээр нь ялгаж заагласангүй холбож хутгасан байна. – Б.Ч.

Эдгээр асуудлыг тохиролцсон бол түүнийг эвслийн гэрээгээр баталгаажуулна.

Эвслийн гэрээнд талуудын эрх, үүрэг, төлөөлөх байгууллага, түүний бүрэлдэхүүн, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүнийг төлөөлөх албан тушаалтан, харилцан тохиролцсон бусад асуудлыг тодорхойлон заана.

“Бусад асуудал” гэдэгт мандатын хуваарилалт, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, намуудын хооронд гарсан саналын зөрөөг шийдвэрлэх, гэрээг цуцлах үндэслэл журам, ажлын алба, санхүүжилт гэх зэрэг сонгуулийн өмнөх болон дараах эвслийн зохион байгуулалт үйл ажиллагаанд тулгарч болох асуудлыг бодож олох, тусгах нь зүйтэй юм. Ямар ч нөхцөлд гэрээний агуулга нь холбогдох хуульд нийцсэн байх шаардлагатай. Эвслийн хувьд:

- өөрөө болон урьд өмнө бусдын хэрэглэсэн нэр, улс, үндэстэн, хүний нэрийг хэрэглэх, бүртгүүлсэн нэрээ өөрчлөх;
- эвслийн нам дангаараа нэр дэвшүүлэх;
- нам дангаараа сонгуулийн зардлын данс нээлгэх;
- бүртгүүлснээс хойш шинээр сонгогдсон УИХ-ын бүрэн эрхийн хугацаа дуустал өөр нам, эвсэлд нэгдэн орох буюу өөр намыг эвсэлдээ элсүүлэн авах,
- бие даан өөр эвсэл байгуулах, тарсны эцэст дахин нэгдэхийг тус тус хоригложээ (СТХ-25.4; 25.9; 25.12; 26.5).

Эвслийн гэрээ нэр дэвшигч намуудын дарга нар гарын үсгээ зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно. Уг гэрээг зөвхөн сонгуулийн хугацаанд бус тухайн сонгуулиар байгуулагдсан УИХ, ИТХ-ын бүрэн эрхийн хугацаа дуустал хүчин төгөлдөр дагаж мөрдөнө. Иймд гэрээ нь эвслийн намуудын хамтран ажиллах урт хугацааны баримт бичиг бөгөөд энэ нь түүний үр дагаврыг илэрхийлнэ.

ШИГТГЭЭ:

Эвсэгч намууд сонгуульд нэг субъект болж оролцох төдийгүй, сонгуулийн дараа УИХ-ын бүрэлдэхүүн дэх өөрийн (нэр дэвшүүлж дэмжсэн) гишүүдийн үйл ажиллагааг дэмжин хэрэв 8, түүнээс дээш бол нэг бүлэг болгон нэгтгэж, түүнээр дамжуулан, хөтөлбөр, зорилго, бодлогоо хуулийн дагуу хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл УИХ-ын бүтцэд нэг субъект хэвээр байж, үйл ажиллагаанд нь нөлөөлнө.

6.3. НАМ, ЭВСЛИЙГ СОНГУУЛЬД ОРОЛЦУУЛАХААР БҮРТГЭХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ

Энэ бол нам байгуулсныг бус, сонгуульд оролцох эсэхийг шалгаж бүртгэх асуудал юм.

Нам, намуудын эвсэл сонгуульд оролцох хүсэлтээ хуульд заасан хугацаанд гаргаж, Сонгуулийн ЕХ-нд хянуулан зохих зөвшөөрөл (эрх) авна.

СТХ-ийн 24 дүгээр зүйлээс:

«24.4 Нам, эвсэл сонгуульд оролцох тухайгаа санал авах өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд бичгээр илэрхийлж, албан ёсоор бүртгүүлнэ».

СТХ-д сонгуульд оролцохыг хүссэн нам, эвслийн **бүрдүүлэх баримт, бүртгэхээс татгалзах үндэслэлийг тодорхойлжээ** (24.4, 24.5, 26.3). Сонгуулийн ЕХ тэдгээр баримт, үндэслэлийн аль алиныг нягтлан шалгаж тогтоох үүрэгтэй.

Нам, эвслийг бүртгэх, татгалзах үндэслэлийг хүснэгтлэн үзүүлбэл:

Бүртгэхэд бүрдүүлэх баримт	Татгалзах үндэслэл /шалтгаан/
1. Сонгуульд оролцох тухай шийдвэр 2. Эвссэн намуудын дүрмийн (нотариатын гэрчилгээтэй) хуулбар 3. Нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр 4. Өмнөх сонгуулиас хойш намуудад иргэд, хуулийн этгээдийн өгсөн хандивын тайлан (аудитын баталгаатай) 5. Намын буюу эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын бүрэлдэхүүн, хаяг, утас зэрэг мэдээлэл 6. Эвсэл бол: • эвслийн гэрээний хуулбар, нотариатын гэрчилгээтэй • нам бүрийн эвсэлд нэгдсэн тухай зохих байгууллагын шийдвэр, тэмдэглэл	Нам бүртгэгдээгүй • 1-6-д нэрлэсэн баримт бичиг дутуу, хүчинтэй биш («хуурамч»); • хүсэлт болон эдгээр баримт бичиг (сонгуулийн өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө)-ийг ирүүлэх хугацаа хожимдуулсан; • хуульд заасан эвсэл байгуулах журам, шаардлага зөрчсөн; • эвсэлд орсон аль нэг нам уг эвслийг бүртгэхээс өмнө түүнээс гарахаа илэрхийлсэн; • өмнөх сонгуулийн зардлын тайланг уул сонгууль дууссанаас хойш 1 сарын дотор ирүүлээгүй.
Эдгээрийг нягтлан шалгаад бүрэн, үнэн зөв бол бүртгэнэ.	Эдгээр шаардлагын аль нэг нь тогтоогдвол бүртгэхээс татгалзана.

Сонгуулийн ЕХ баримт хийсэн үндэслэлийг нягтлан шалгаж тогтоосны үндсэн дээр зохих нам, эвслийг бүртгэх, эсэхийг шийдвэрлэнэ.

СТХ-ийн 26 дугаар зүйлээс:

«26.2 СЕХ энэ хуулийн 24.4; 24.5-д заасан баримт бичгийг үндэслэн тэдгээрийг хүлээн авснаас хойш 5 хоногт багтаан сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх эсэх тухай шийдвэр гаргана».

«26.4 СЕХ нам, эвслийг бүртгэсэн тухай шийдвэр гаргасан бол батламж олгоно».

Нам, эвслийг бүртгээд Сонгуулийн ЕХ-ноос олгосон “Батламж” бол тухайн нам, эвслээс сонгуульд оролцох эрхийн нотолгоо юм.

6.4. ЭВСЭЛ ТАРАХ

Намуудын эвсэл бол сонгуулийн тогтвортой нэгдэл мөн. Гэхдээ аль ч нам, эвслээс хэдийд ч гарах эрхтэй. Энэ тухайгаа зохих намыг төлөөлөх байгууллага, эвслийн төлөөлөх байгууллагад³ албан ёсоор мэдэгдсэнээр уул намыг эвслээс гарсанд, улмаар эвслийг тарсанд тус тус тооцно. Үүнийг өнгөцхөн харвал гэрээгээ цуцалж буй ердийн үзэгдэл мэт. Гэвч тиймхэн үйлдэл бус. Харин хөтөлбөрийг дэмжиж, нэр дэвшигчдийн төлөө санал өгсөн сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн бүх сонгогчийн итгэлийг эвдэж, парламентын хэвийн үйл ажиллагааг сүрхий доголдуулдаг. Эвсэл тарвал түүний нэрийн өмнөөс УИХ-д сонгогдож томилогдсон албан тушаалаас огцрох буюу эрх үүрэг нь дуусгавар болох, эвслийн бүлэг тарах зэргийн эрх зүйн үр дагавар гарна. Хэрэв УИХ-ын олонх байсан эвсэл задарвал тэр байр сууриа алдаж, Засгийн газрын бүрэлдэхүүн, үйл ажиллагааны хөтөлбөрт өөрчлөлт оруулах ноцтой шаардлага ч тулгарч болно. Эвсэх эсэх асуудалд ихээхэн судалгаатай, хэтэч чанартай, хариуцлагатай хандах шаардлагатайг дээр дурдсан учир холбогдол харуулж байна. Юуны өмнө эвслийг намууд лавтай тохиролцон улс төрийн итгэлд үндэслэн хуулийн дагуу байгуулж, гэрээнийхээ үүргийг үндэслэлтэй томъёолж, түүндээ үнэнч байж, хуулийг дээдлэн сахиж биелүүлэх ёс зүйн болон журамт үүрэгтэй юм.

2004 оны сонгуулиар байгуулагдсан Эх орон-Ардчилал эвсэл тарсан явдал ямар үр дагавартайг харуулсан бөгөөд эвсэлд байсан 8-аас дээш суудалтай нам бүлэг байгуулах эрхтэй эсэх зэрэг маргаан бүхий нэлээд асуудал үүссэн. Энэ мэтийг хуулиар зөв шийдэж зохицуулах шаардлагатайг дашрамд тэмдэглэе.

6.5. БҮРТГҮҮЛСНИЙ ДАРАА НАМ, ЭВСЭЛ СОНГУУЛЬД

Нам, эвсэл сонгуульд оролцохоор бүртгүүлж эрх олох нь өндөр тушаал, эрх ямба үнэртсэн буяны хаалгаар оров гэсэн хэрэг огтхон ч биш. Харин ард түмний өмнө хүлээх бүх талын ачаа үүрэг нэмэгдсэний нотолгоо болно.

Өргөн утгаар үзвэл улс орны өмнө тулгарсан бэрхшээлийг даван туулж, хөгжлийн замналыг шулуутгах, иргэнийхээ сайн сайхан аж байдлыг тэтгэгч засаг, үр ашигтай удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнийг төлөвшүүлэн, төрийн үйлчилгээний хүртээмж, өгөөжийг дээшлүүлэх үйлсийг **хошуучлах** өндөр хариуцлага ойртож буйн дохио мөн.

Нам, эвслийн сонгуульд оролцохын шууд зорилт нь сонгуулийг хууль ёсоор шударгаар явуулж, улс орныг удирдан хөтлөх ихээхэн чадвартай, үнэнч шударга, ажил хэрэгч чанараараа шалгарсан хүмүүсийг олж сонгох талаар сонгогчдод дөхөм үзүүлж хүч нөөцөө дайчилж, үлгэр жишээчээр ажиллахад оршино. Сонгууль хэр зохион байгуулалттай, зөв шударга, ардчилсан ёс журмаараа

болж өнгөрөх эсэх нь нам, эвслийн төрх төлөв, ёс зүй, үйл ажиллагаанаас шууд шалтгаалдаг.

ЗӨВЛӨМЖ

Олон нам, эвсэл нийт улс, нэг тойрог, хэсэгт нэг мандатын төлөө өрсөлдөж байгаагаас үүсэн гарч болзошгүй элдэв гаж хандлага, сөрөг үзэгдлээс соргоогоор сэргийлж, дээд зэргийн соёлч, ёс зүйч, үнэнч шударга зан төлөвийг эрхэмлэн сахиж үлгэр жишээ үзүүлэх нь ард түмний хүндэтгэл хүлээх гол нөхцөл мөн. Үүнийг нам эвслийн гишүүн, идэвхтэн бүр эрхэмлэх нь чухал.

Сонгуулийн үйл явцын үе шат бүрээр эрэмбэлэн үзвэл нам, эвсэл сонгуульд оролцоно гэдэг **хэзээ, юуг, яаж хийнэ** гэсэн үг вэ?

- Мөрийн хөтөлбөрөө **Үндсэн хуулийн хүрээнд** боловсруулж олон түмэнд танилцуулах;
- сонгуулийн байгууллага (тойрог болон салбар, хэсгийн хорооны бүрэлдэхүүн)-д төлөөлөгчөө зөв шилж оруулах;
- сонгуулийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүйгээр сонгууль бэлтгэн явуулахад нь хууль ёсны дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн шаардлагыг ёслон биелүүлэх;
- нэр дэвшүүлэх, тэднийг бүртгүүлж, байгууллага байгуулж, ухуулагч туслахыг томилон ажиллуулах;
- зорилго бодлого, нэр дэвшигчдийнхээ давуу чанарыг ухуулан сурталчилж дэмжих. Энэ зорилгоор сонгогчдын хурал, цуглаан, уулзалт, ярилцлага, хэвлэл мэдээллийн сурталчилгаа зохион байгуулж, олон түмнийг татан оролцуулах;
- сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавьж, ажиглагчдыг бэлтгэн ажиллуулах, зөрчил гажуудалтай тэмцэх, илчлэн шүүмжлэх, нэр дэвшигчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- санал хураах, тоолох, сонгуулийн дүнг гаргахад ажиглан хяналт тавих зэрэг үүрэг гүйцэтгэх нь оролцогчийн эрх зүйн байдалд нийцнэ гэж үзэж болно.

Нам, эвсэл сонгуульд оролцохдоо ил тод байдал, хууль ёс, шударга ёс, эрх тэгш байдлыг чанд сахих нь ардчилсан сонгуулийн үндсэн шаардлага мөн.

Нөгөөтээгүүр сонгуулийн хуулиар хориглосон аливаа үйлдлээс болон ард түмний уламжлалт заншил, ёс зүйд харш явдлаас эрс татгалзах, ил, далд иймэрхүү үйлдлийн эсрэг шударгаар тэмцэх нь улс төрийн хүчнээс, түүний гишүүн дэмжигчдээс сонгуулийг хуулийн дагуу шударгаар явуулахад бодитой дэм болно.

Энэ талаар Үндсэн хууль, Сонгуулийн хууль, Эрүүгийн хууль, Авлигатай тэмцэх тухай болон бусад хуульд хангалттай тодорхой, олон зүйл заалт бий. Зөвхөн СТХ-ийн **«Сонгуулийн мөрийн хөтөлбөр, сурталчилгаа»** гэсэн долдугаар бүлэгт 20-иод зүйлийн хориг цээр тодорхойлжээ. Энэ тухай «Сонгуулийн сурталчилгаа» гэсэн номын 8 дугаар бүлэгт тодруулан өгүүлснийг уншихыг хичээгээрэй.

3 Намыг ер нь аль нэг байгууллага хууль ёсоор төлөөлөх эрхийг түүний дарга захирлаас эхлээд эрх олгогдсон ямар ч этгээд эдэлж болох учир "төлөөлөх байгууллага" гэдэг тун ерөнхий учир ("намын сонгуулийн товчоо" гэх мэт) тусгайлан оноосон нэр хэрэгтэй юм. – Б.Ч.

Д.БАТ-ЭРДЭНЭ:**СОНГОГЧДЫН САНАЛЫГ АВАХ ТӨРӨЛ,
ХЭЛБЭРИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭЭР ХУУЛИЙН
ТӨСЛИЙН САНАЛ БОЛОВСРУУЛСАН**

Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэтэй ярилцлаа.

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль ирэх жил болно. Сонгуулийн бэлтгэл ажлын талаар асуухад арай эрт байна уу?

-Сонгуулийг сонгуулийн жил, магадгүй санал авах өдрөөр төсөөлж ингэж асуух хүмүүс бий. Өнгөрсөн сонгуулиудын зохион байгуулалт, сонгогчдын оролцоонд судалгаа хийх, түүндээ үндэслэн хууль эрх зүй болон зохион байгуулалтын санал, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, сонгуулийн боловсрол олгох, техник хангамжийн бүрдүүлэлт, бэлэн байдлыг хангах зэргээр сонгуулийн бэлтгэл ажил байнга үргэлжилдэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2027 оны ээлжит сонгуулийн тухайд ярихад, Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар Улсын Их Хуралд санал хүргүүлэх чиг үүргийнхээ хүрээнд холбогдох судалгаа, үнэлгээ, төсөл бэлтгээд байна.

-Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай байна гэж үү. Ер нь сонгууль бүрийн өмнө хуульдаа өөрчлөлт оруулаад байх нь зөв үү?

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд оруулж байсан нэмэлт, өөрчлөлтүүд болон шинэчилсэн найруулгууд нь тухайн цаг үеийн сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн, зохион байгуулалтын шинжтэй байсныг дурдах нь зүйтэй.

Ярилцлагынхаа эхэнд хэлсэн, өнгөрсөн сонгуулиудын зохион байгуулалт, сонгогчдын оролцоонд хийсэн судалгаанд үндэслэн санал боловсруулдаг гэж. 1993 онд зохион байгуулагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн ирц 92.7 хувь, 1997 онд 85.1 хувь, 2001 онд 82.9 хувь, 2005 онд 74.98 хувь, 2009 онд 73.59 хувь, 2013 онд 66.5 хувь, 2017 онд 68.27 хувь, 2021 онд 59.29 хувь болж буурсан.

Сонгуулийн ирц оролцоо буурч байгаа гол шалтгаан нөхцөлийг тодорхойлох зорилгоор Сонгуулийн ерөнхий хорооноос 2025 онд

21 аймаг, 330 сумын нийт 11700 сонгогчийн хамруулсан "Сонгогчийн зан төлөвийн судалгаа" хийсэн. Судалгааны тайланд дурдсан үр дүнгээс үзвэл сонгуульд оролцоогүй шалтгааны 33.9 хувь нь "санал авах өдөр байнгын оршин суугаа газраасаа өөр газарт байсан", 7.7 хувь нь оюутан, орон нутагт оршин суух хаягтай", 0.5 хувь нь "гадаад улсад байсан" зэрэг шалтгаантай байсан.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны "Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны



тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 77 дугаар тогтоол гарч “хөгжлийн бэрхшээлтэй иргэн, гадаад улсад байгаа болон Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа боловч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн хаягнаас өөр газарт байгаа иргэн, оюутан, суралцагчид, сонгуулийн санал авах өдөр албан үүргээ гүйцэтгэж байгаа төрийн албан хаагч, уртын ээлжээр ажиллаж байгаа ажилтан зэрэг сонгогчдын сонгох эрхийг эдлүүлэх, санал өгөх боломжит хувилбарыг тодорхойлж, эрх зүйн орчныг бий болгох талаар санал боловсруулах”-ыг Сонгуулийн ерөнхий хороонд үүрэг болгосон.

Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, судалгааны үр дүн иргэдээс санал авах ажиллагааг хөнгөвчилж сонгогчдод ээлтэй болгох, санал авах өдөр байнгын оршин суугаа газраасаа өөр газарт тодорхой шалтгааны улмаас зорчиж байгаа сонгогч болон санал авах өдөр санал авах байранд очиж саналаа өгөх боломжгүй сонгогчдын саналыг урьдчилан авах гэх зэрэг санал авах төрөл хэлбэрийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Сонгуулийн ерөнхий хорооны хувьд иргэн сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд зохион байгуулалтын хувьд юу хийх шаардлагатай, ямар процессыг сайжруулах талаар тогтмол судалгаа хийж, түүндээ үндэслэн хууль тогтоомжийг сайжруулах чиглэлээр санал боловсруулах үүргийг Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиар хуульчилсан байдаг. Иймд бид энэ удаа сонгогчоос санал авах төрөл хэлбэрийг нэмэгдүүлэх, Улсын Их Хурлын тогтоолын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд гадаад улсад байгаа болон Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа боловч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн хаягнаас өөр газарт байгаа иргэн, оюутан, суралцагчид, сонгуулийн санал авах өдөр албан үүргээ гүйцэтгэж байгаа төрийн албан хаагч, уртын ээлжээр ажиллаж байгаа ажилтан зэрэг сонгогчдын сонгох эрхээ хэрэгжүүлэх нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, түүнд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр саналаа боловсруулж дууслаа.

Ерөнхийлөгчийн сонгуулиудаар гадаадад байгаа иргэдийнхээ саналыг авдаг. Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар мөн дипломат төлөөлөгчийн газруудаар дамжуулж санал авсан. Сонгогчдын оролцоо нь гадаадад байгаа нийт иргэд болон санал авахад гаргаж байгаа зардалтай харьцуулахад хэр үр дүнтэй байдаг вэ?

-Сонгууль нь бүх нийтийнх байх зарчимтай. Үндсэн хуульт ардчилал тухайн улс оронд бүрдэж, бэхэжсэн эсэх нь сонгуулийг хэрхэн чөлөөт, шударга, ил тод зохион байгуулж байгаагаас шууд хамаарах бөгөөд сонгууль зохион байгуулах үйл ажиллагаа нь сонгогчийн сонгох, иргэний сонгогдох эрхийг хэрхэн хангаж, эрхээ баталгаатай эдлэх нөхцөл, боломжийг бүрдүүлж байгаагаас шууд хамаардаг. Албан бус тоо баримтаар Монгол Улсаас гадаад улсад ажиллаж, амьдарч, сурч байгаа 200.000 гаруй иргэн байдаг. Харин статистик тоо баримтад дурдсанаар 120.000 орчим сонгогч гадаад улсад ажиллаж, амьдарч, сурч байгаа талаар

мэдээлэл байна. Гадаад улсад байгаа иргэдийн сонгуулийн ирц оролцооны хувьд авч үзвэл, 2013 оны сонгуульд 6233 сонгогч бүртгүүлж 4248 сонгогч буюу 68.2 хувь, 2017 оны сонгуульд 7374 сонгогч бүртгүүлж 7209 сонгогч буюу 66.8 хувь, 2021 оны сонгуульд 7398 сонгогч бүртгүүлж 5568 сонгогч буюу 75.30 хувь байна. Өөрөөр хэлбэл, гадаад улсад байгаа иргэдээс санал авсан дээрх гурван удаагийн сонгуульд гадаад улсад байгаа нийт сонгогчийн талаарх статистик тоон мэдээтэй харьцуулан үзвэл 5-6 хувь нь сонгуульд оролцохоор бүртгүүлж, бүртгүүлсэн сонгогчдоос дунджаар 65 хувь нь сонгуульд оролцож, сонгох эрхээ хэрэгжүүлсэн байдаг.

Хуульд ямар өөрчлөлт оруулбал дээрх асуудлыг шийдэх вэ?

-Ойлгомжтой товчхон тайлбарлах хэрэгтэй байх. Улсын Их Хурлын 77 дугаар тогтоолд дурдсан тодорхой бүлгийн сонгох эрхийг хангах чиглэлээр гурван төрлийн санал авах арга хэлбэрийг нэмэгдүүлье л гэж байгаа юм. Тухайлбал:

Гадаад улсад байгаа иргэдээс санал авсан гурван удаагийн сонгуульд гадаад улсад байгаа нийт сонгогчийн талаарх статистик тоон мэдээтэй харьцуулан үзвэл 5-6 хувь нь сонгуульд оролцохоор бүртгүүлж, ийнхүү бүртгүүлсэн сонгогчдоос дунджаар 65 хувь нь сонгуульд оролцож, сонгох эрхээ хэрэгжүүлсэн байна.

1. Гадаад улсад байгаа сонгогчдын сонгуулийн ирц оролцоо маш бага түвшин байгаа шалтгааныг зохион байгуулалт талаас нь авч үзвэл:
 - саналаа өгөхийн тулд хуулиар тогтоосон хугацаанд урьдчилан бүртгүүлэх,
 - Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар байрладаггүй хотод байгаа сонгогч саналаа өгөхөд хүндрэл үүсдэг,
 - санал авах ажиллагаа нь сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө эхэлж, дуусаж байгаа нь мэдээлэл, мөрийн хөтөлбөрт үндэслэн сонголтоо хийх боломжийг хязгаарладаг,
 - санал авах өдөр цөөн буюу 2 хүртэл өдөр байхаар тогтоодог. Иймд гадаад улсад байгаа иргэд санал өгөхдөө урьдчилан бүртгүүлэхгүй бөгөөд сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш санал өгөх боломжийг бүрдүүлэх эрх зүйн зохицуулалтыг тусгахаар санал боловсруулсан.
2. Санал авах өдөр саналаа өгөх боломжгүй сонгогчийн саналыг урьдчилан авах төрөл, хэлбэрийг нэвтрүүлэх, түүнд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх юм.
3. Санал авах өдөр тухайн сонгогчийн харьяа хэсгийн хороо хамаарах аймаг, нийслэлээс өөр нутаг дэвсгэрт байгаа сонгогчийн саналыг авах, түүнд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авах эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар саналаа боловсруулаад байна.



Гадаадад байгаагаас гадна оюутнууд, уул уурхай, зам тээврийн салбарынхан үндсэн хаяг дээрээ байхгүй шалтгаанаар саналаа өгч чаддаггүй талаар Хүний эрхийн үндэсний комиссын илтгэлд орсон, танай судалгааны дүн ч харуулж байна. Ийм шалтгаантайгаар сонгуульд оролцдоггүй сонгогчдын асуудлыг ямар аргаар шийдэх боломжтой гэж үзэж байна вэ?

-Улирлын шинж чанартай ажил, хөдөлмөр эрхэлдэг 56000 (уул, уурхай, ач тээвэр), оюутан 20000, сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд буюу буюу шатны сонгуулийн байгууллагад сонгуулийн үед ажилладаг 46000 төрийн албан хаагч буюу нийт 250000 орчим сонгогчийн сонгох эрхээ эдлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, түүнд шаардлагатай эрх зүйн орчныг зайлшгүй бүрдүүлэх шаардлагатай байна. Санал авах арга хэлбэрийг өөрчлөх, сонголттой болгох шаардлагатайг дээр ярьсан. Өөрөөр хэлбэл, санал авах өдөр саналаа өгөх боломжгүй сонгогчийн саналыг урьдчилан авах төрөл, хэлбэрийг нэвтрүүлэх, санал авах өдөр тухайн сонгогчийн харьяа хэсгийн хороо хамаарах аймаг, нийслэлээс өөр нутаг дэвсгэрт байгаа сонгогчийн саналыг авах, түүнд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авах эрх зүйн орчныг бүрдүүлэхээр талаар саналаа боловсруулсан байгаа юм.

Эрх зүйн орчныг бүрдүүлэхээс техникийн боломжийг хэр судалсан бэ. Одоо ашиглаж байгаа санал тоолох төхөөрөмжөөр дээрх асуудлыг шийдэх боломжтой юу?

-Мэдээж санал авах шинэ төрөл, хэлбэрийг нэмэгдүүлж байгаагаас шалтгаалан дагалдан гарах хуулийн төсөл боловсруулах шаардлагатай. Тухайлбал, санал авах төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэхдээ сонгуулийн автоматжуулсан систем, түүнд хамаарах тоног төхөөрөмжийн судлах, тодорхойлох, баталгаажуулах зэрэг чиг үүргийг Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн чиг үүрэгт нэмэлтээр тусгах зорилгоор Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг боловсруулсан.

Д.ТЭГШБАЯР:

НҮБ-ЫН ТОГТООЛ САНААЧИЛЖ, БАТЛУУЛСАН НЬ МОНГОЛ УЛСЫН МАНЛАЙЛЛЫГ ОЛОН УЛСАД ТАНИУЛСАН



Монгол Улс “Улс төрийн нам, сонгуульд нэр дэвшигчид болон сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх тухай” тогтоолыг санаачилсан нь НҮБ-ын 192 гишүүн орны дэмжлэгийг авч, оны өмнө батлагдсан. Энэ талаар санхүүгийн гэмт хэргийн шинжээч, судлаач Д.Тэгшбаяртай ярилцлаа. Тэрбээр уг тогтоолыг батлуулах Ажлын хэсгийн зөвлөхөөр ажилласан юм.

КОНВЕНЦЫН ГИШҮҮН ДЭЛХИЙН 192 ОРОНТОЙ ЗЭРЭГ ЗӨВШИЛЦӨНӨ ГЭДЭГ АМАРГҮЙ АЖИЛ

-Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын Оролцогч талуудын 11 дүгээр Бага хурал өнгөрсөн арван хоёрдугаар сард болж манай улсаас төлөөлөгчид оролцоод ирсэн. Хурлаар ямар асуудлыг хэлэлцсэн бэ?

-Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын Оролцогч талуудын хурал хоёр жил тутамд болдог. Өнгөрсөн оны арван хоёрдугаар сард Катарын нийслэл Доха болсон 11 дүгээр хурлаар улс орнуудын конвенцын хэрэгжилтийн үнэлгээний тайланг хэлэлцэж, нийтдээ 11 тогтоол баталсан. Түүнчлэн, конвенцын бүлэг тус бүрээр хамтын ажиллагаа, үр дүнгийн, эрсдэлийн, туршлага хуваалцах, гарын авлага танилцуулах гэх мэт олон жижиг арга хэмжээнүүд зохион байгуулсан.

Монгол Улс “Улс төрийн нам, сонгуульд нэр дэвшигчид болон сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх тухай” тогтоолыг санаачилж, Норвеги, Гана, Албани улстай хамтран зохиогчоор оролцсон. Энэ нь манай

улсын НҮБ-ын Авлигын эсрэг конвенцын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээрх өргөн барьсан анхны тогтоол боллоо. Уг тогтоол хурлын хамгийн чухал ач холбогдолтой асуудлын нэг байсан.

Манай улсын санаачилсан тогтоолыг хэлэлцэх явцад Европын холбооны 27, бусад 35, нийтдээ 62 улс шууд дэмжин, НҮБ-д хамтран зохиогчоор оролцох хүсэлт тавьснаар батлагдлаа. Мөн олон улсын 168 байгууллага гарын үсэг зурж, манай тогтоолыг дэмжихийг уриаллаа шүү дээ. Энэ нь Монгол Улсын хувьд ч, мөн хурлын хувьд ч онцлох үйл явдал яах аргагүй мөн.

-Тогтоол батлуулах зохиогч улс гэхээр ямар үүрэгтэй, яаж оролцдог вэ? Манай улс хэрхэн оролцов?

-Гишүүн улс орнууд конвенцын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор тогтоол санаачилж батлуулахад тухайн улс орнуудтай маш олон удаагийн уулзалт хийж, тогтоолын төсөлдөө санал авч, лоббиддог. Энэ бүх ажил аливаа орны дипломат харилцааны, хүний нөөц, зохион байгуулалтын чадвар, улс орнуудтай хэлэлцэн зөвшилцөх, дипломат



مؤتمر الدول الأطراف في اتفاقية الأمم المتحدة لمكافحة الفساد

Conference of the States Parties to the United Nations Convention against Corruption

15 - 19 December 2025, Doha, Qatar | 19 - 15 ديسمبر 2025، الدوحة، قطر

Shaping Tomorrow's Integrity



харилцааны чадавхаас ихээхэн хамаардаг. Конвенцын гишүүндэлхийн 192 оронтой зэрэг зөвшилцөнө гэдэг амаргүй ажил. Засгийн газраас Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг ажилласан. Ажлын хэсэг зохиогчийн хувиар тогтоолоо батлуулах хүртэл 33 удаагийн информал хэлэлцүүлэг, 4 удаагийн формал хэлэлцүүлэг, хэд хэдэн оронтой тусгайлсан уулзалт хийсэн нь амжилттай болсон. Тиймээс ч 62 орон шууд дэмжиж, үлдсэн орнууд санал хураахгүйгээр зөвшилцөн баталсан.

**МАНАЙ УЛС АВЛИГЫН СУУРЬ АСУУДАЛ
РУУГАА ОРЖ, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХЭД
ТУУШТАЙ ГЭДГЭЭ ДЭЛХИЙН 192 ОРНЫ ӨМНӨ
ХАРУУЛЛАА**

**-Ер нь НҮБ-аар батлуулах тогтоол батлуулах нь
улсын нэр хүндийн хувьд ч, дэмжлэг авахад ч ач
холбогдолтой байх.**

-НҮБ-ын тогтоол санаачлах нь олон давуу талтай. Олон улсын байгууллагуудын төлөвлөгөөнд батлагдсан тогтоолыг хэрэгжүүлэхэд үзүүлэх дэмжлэг, санхүүжилт, техникийн туслалцаа нэмэгдэх бол эхний үр дүн. Тогтоолыг бүх гишүүн улс хэрэгжүүлэх ба санаачлагчаар улсын нэр тэр бүрд

дурдагдаж явна гэсэн үг. Энэ бол авлигын эсрэг асуудлаарх манай улсын манлайллыг олон улсад таниулах арга хэмжээ.

**-Тогтоолыг батлуулахад өргөн хүрээтэй судалгаа
хийдэг байх. Судлахад, манай улсад болон олон
улсын түвшинд нам, нэр дэвшигчдийн санхүүжилт нь
авлигатай ямар хамааралтай байсан бол?**

-Манай улсын талаар олон улсын хэвлэлээр сайн, муу олон мэдээ гардаг ч уул уурхай, гуравдагч хөршийн бодлого болон авлига гэсэн 3 сэдэв олон улсын анхаарлыг тогтмол татдаг. Шударгаар хэлэхэд, уул уурхайн салбарт сайн гэхээсээ саар мэдээтэй, гуравдагч хөршийн бодлогод их болгоомжтой ханддаг. Авлигын хэргийн талаар ч дэлхийн анхаарлыг татсаар байна. Төрийн өндөр албан тушаалтнууд холбогдсон авлигын гэмт хэрэг ар араасаа гарч, авлигатай үндсээр нь тэмцэнэ гэж байсан улстөрчид ч саяхан авлигын хэрэгт холбогдчихлоо. Энэ нь олон улсад "сонирхолтой" мэдээ бол манай улсад "муу" мэдээ болж байдаг. Авлигын үндэс суурь нь cronyism буюу албан тушаалын шударга бус томилгооноос үүдэлтэй авлигын хэлбэр буюу төрийн, төрийн өмчит аж ахуйн нэгжийн шийдвэр гаргах эрх мэдэлд хүрэхээр улс төрийн намыг санхүүжүүлдэг гэдэгт олон улсын судлаачид, судалгаанууд санал нийлдэг. Транспаренси интернэшнл байгууллагаас Авлигын төсөөллийн индексийг зарлах бүрдээ Монгол Улсад тусгайлан үүнийг анхааруулж ирсэн. Одоо сайн мэдээ гэвэл, манай улс авлигын суурь

асуудал руугаа орж байна, авлигатай тэмцэхэд тууштай гэдгээ дэлхийн 192 орны өмнө энэ тогтоолыг санаачлан, батлуулж манлайлан харууллаа. Энэ бол төрийн бодлого. Бусад хамтран зохиогч орнууд өөр өөрийн онцлогтой.

-Энэ тогтоолын агуулгын талаар товч яриач, хэзээнээс хэрэгжиж эхлэх вэ?

-Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын улс төрийн намын санхүүжилттэй холбоотой 7.3-д заасан ганцхан заалтыг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөөг энэ тогтоолын агуулгаар баталлаа гэж ойлгож болно. Нийт 6 чиглэлээрх 22 заалтаар улс төрийн нам, нэр дэвшигч, сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийг сонгуулийн үе, сонгуулийн бус үе гэж ялгахгүйгээр ил тод болгох, улс төрийн нам, нэр дэвшигчдийг хариуцлагатай, хяналттай байлгах, мэдээллийг өгөгдөл болгоход чиглэгдсэн нарийн заалтыг тусгасан. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны цахим хуудаст тавигдсан даруйд хэрэгжиж эхэлнэ.

АВЛИГЫН АСУУДЛААР МАНЛАЙЛАЛ ҮЗҮҮЛЧХЭЭД ОЛИГТОЙ АЖИЛ ХИЙХГҮЙ БОЛ БИД ӨӨРСДӨӨ ХЭЦҮҮ БАЙДАЛД ОРНО

-НҮБ-ын тогтоолыг дагалдуулж манай улсад эрх зүйн баримт батлагдах уу?

-2023 онд Улс төрийн намын тухай хууль батлагдсанаар манай улс уг тогтоолын нэлээд олон заалтыг аль хэдийн хэрэгжүүлчихсэн байсан. Гэхдээ сонгуулийн сурталчилгаанд хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан зарцуулсан зардлыг бууруулах, санал худалдан авах гэмт хэргийг Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэгт хамааруулахад чиглэгдсэн судалгаа, Эрүүгийн хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах болон төрийн албанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай зэрэг холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах ажил бий. Тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, Засгийн газарт өргөн барьж, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны техникийн тусламжийн талаар ярилцсан нь мөн дэлхийн бусад орноос анхдагч болоод байна. Төлөвлөгөөний дагуу зарим хуульд өөрчлөлт орох шаардлага бий. Бид энэ ажлыг манлайлсны хувьд 2027 оны 12 дугаар сард зохион байгуулагдах Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын оролцогч талуудын 12 дугаар хурлаар тайлангаа тавих ёстой. Тиймээс төлөвлөгөөг хэрэгжүүлэх үндсэндээ 20-оод сарын хугацаа үлдээд байна.

-Тогтоолыг хэрэгжүүлэгч улсууд ямар үүрэг хүлээх бол?

-Ганц манай улсад биш, дэлхийн бусад улс оронд ч улс төрийн намыг дагасан авлигын асуудал нь төрийн эрх мэдэлд нөлөөлөхүйц хэмжээнд хүрсэн. Тийм учраас уг тогтоол улс орнуудад шаардлагатай арга хэмжээг, дотоодын эрх зүйн орчиндоо тохируулан хэрэгжүүлэх гарын авлага

болох юм. Зарим улс орнуудад энэ чиглэлийн зохицуулалт дутагддаг ч төр нь хөдлөхгүй тохиолдол олон байна. Тийм улс орнуудад иргэний нийгмийн байгууллагууд идэвх зүтгэл гарган, шахалт үзүүлсэн ч үр дүнд хүрдэггүй байсан бол одоо тогтоолын хүрээнд конвенцын гишүүн орон бол хөдөлж эхэлнэ гэсэн үг. Заавал хэрэгжүүлэх дарамт шахалтыг НҮБ-аас үзүүлэхгүй ч Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн үнэлгээгээр асуудал болгоод гаргаад ирнэ. Дэлхий нийтийн чиг хандлага энэ зүг рүү явна гэдгийг, яваандаа эдгээр заалт нь НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, олон улсын бусад байгууллагуудын төсөл, хөтөлбөрөөр дамжин хэрэгжүүлэх шаардлагатай болж, тусламж, дэмжлэг, санхүүжилт, хамтын ажиллагаа энэ чиглэлд чиглэнэ гэж ойлгож болно.

Олон улсын анхаарлыг ингэж их татсан авлигын асуудлаар манлайлал үзүүлчхээд олигтой юм хийхгүй, үр дүнгүй байвал бид өөрсдөө харин хэцүү байдалд орно. Гэхдээ тогтоолын төсөл дээр ажиллаж байхад манай улс бусад дийлэнх улс оронтой харьцуулахад нэлээд олон заалтыг хэрэгжүүлчихсэн байсан. Улс төрийн намын тухай хууль 2024 оноос хэрэгжиж эхэлснээс хойш олон улсын байгууллагаар үнэлгээ хийлгүүлээд зөвлөмж авчихсан, улс төрийн намын санхүүжилтийг ил болгох, судалгаа хийх, өгөгдөл гаргах, чадавх бэхжүүлэх, гомдол шийдвэрлэх сонгуулийн зардлын хяналт хэрэгжүүлэх программ бий болгохоор манай Сонгуулийн ерөнхий хороо ажиллаад эхэлчихсэн, санхүүжилт нь шийдэгдчихсэн зэрэг багагүй ажил хийчихсэн байна. Үүгээрээ манай улс олон улсад өөрсдийн туршлагаасаа хуваалцах хэмжээний жишээ болж болохоор байна гэж харсан. Хэрэгжилт үр дүнтэй байвал авлигын суурь нөхцөлийг эрүүлжүүлэхэд ч тодорхой хэмжээнд ахиц гаргана.

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ БУЙГ НОТЛОХ ҮНДСЭН ҮҮРЭГ ХҮЛЭЭЖ БАЙНА

-Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар улс төрийн намууд санхүүгийн тайлангаа Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлж, олон нийтэд ил болгож байгаа. Мөн нам, нэр дэвшигчид сонгуульд оролцохдоо Үндэсний аудитын газарт тайлангаа хүргэдэг. Энэ тогтоол батлагдсанаар эдгээр процесс ажиллагааг нарийвчилна гэсэн үг үү?

-Сонгуулийн үеэр Сонгуулийн төв байгууллага нь хариуцаад явж болохоор зарим асуудлыг хуульд өөр төрийн байгууллагад хариуцуулсан, үүнээс улбаалж иргэдэд хүргэх мэдээлэл удаашрах зэрэг асуудлууд гарахаас гадна давхардал, хийдэлтэй эсхүл зохицуулалт орхигдсон хууль тогтоомж бий. Тиймээс улс төрийн санхүүжилтийн нөхцөл байдалд суурь үнэлгээ боловсруулах, харьцуулалт хийж байж ямар нэмэлт, өөрчлөлт шаардлагатайг тодорхойлно гэж найдаж байна.

-Тогтоол батлуулахад Сонгуулийн ерөнхий хорооны оролцоо ямар байсан бэ. Мөн хэрэгжүүлэхэд ямар үүрэг хүлээх вэ?

-Тогтоолыг батлахад Сонгуулийн ерөнхий хороо ажлын хэсэгт албан ёсоор орж, саналаа өгч оролцсон. Хэдийгээр төрийн яамд, агентлагуудын идэвхтэй оролцоо, хамтын ажиллагаа чухал ч Сонгуулийн ерөнхий хороо тогтоолын хэрэгжилтийг хангаж буйг нотлох үндсэн үүрэг хүлээж байна. Ирэх хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дийлэнх ажил Сонгуулийн ерөнхий хороонд оногдож байгаа. Үүнээс гадна сонгуулийн төв байгууллагын чадавхи, бие даасан байдлыг бэхжүүлэх, түүнд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх зэргээр Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулж батлуулах шаардлага тогтоол батлагдсанаар үүссэн. Төлөвлөгөө батлагдсанаар түүний дагуу хийх ажлууд бий.

-Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гэдгийг тодруулаач?

-Сонгуулийн төв байгууллагын тухай хууль батлагдаад даруй 20 жил болсон байна. Өнгөрсөн хугацаанд тус хуульд бага сага нэмэлт, өөрчлөлт оруулж ирсэн ч эрх зүйн байдал нь ерөнхий. Зөвхөн тогтоол батлагдсан учраас ч биш, ер нь нийгэм, эдийн засаг, мэдээлэл технологи, мөн системийн холболт зэрэгт олон өөрчлөлтийг харгалзан хууль маань сайжрах шаардлагатай байсан. Хамгийн гол нь энэ байгууллагад улс төрийн болон бусад хөндлөнгийн нөлөөллийг бүр мөсөн үгүй болгох, хараат бус байдлыг нэмэгдүүлэх, сонгогчид болон улс төрийн нам, эвслийн чадавхийг бэхжүүлэх материаллаг нөөцийг нэмэгдүүлэх, хүний нөөцийг чадавхижуулах, хууль тогтоомжид байгаа чиг үүргийн давхардлыг арилгаж тодорхой болгох шаардлагатай байна. Энэ нь цаг үеийн шаардлагаар бий болсон, сонгуулийн ардчиллыг хамгаалах чухал хөшүүрэг болно.

-Монгол Улс Нээлттэй засгийн түншлэлийн Сорилтод улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах амлалаар нэгдэн ажиллаж байгаа. Энэ ажил тогтоолын хэрэгжилттэй холбогдох уу?

-Энэ тогтоолыг санаачлах санаа нь анх Транспаренси интернэшнл байгууллагын экспертүүдийн бүлгээс гарсан юм. Тухайн үед тогтоолыг НҮБ-д өргөн барих талаар улс орнууд ярилцаад эхэлчихсэн, манай улс ч дотооддоо эрчимтэй хэлэлцэж байсан. 2025 онд Нээлттэй засгийн түншлэлийн чуулга уулзалтаар Монгол Улс улс төрийн санхүүжилтээ ил тод болгох амлалт авсан нь НҮБ-ын баталсан энэ тогтоолтой яваандаа холбогдсон байдаг. Уг санаачилгыг Монгол Улс дэмжин 2025 онд 2 ч Засгийн газраас тус тусдаа тогтоол баталж тогтоолын зохиогчоор ажиллахаар шийдвэрлэсэн байдаг. Олон улсын санаачилгууд хоорондоо уялдаатай. Ялангуяа, төсөл, хөтөлбөр, санхүүжилт, дэмжлэг нь уялдаатай хэрэгждэг. Тиймээс уг тогтоол батлагдсанаар олон улсын байгууллагуудын үйл ажиллагаа энэ чиглэлээр тусгайлан, хамтран ажиллахаар төлөвлөгдөхөөр байна.

-Санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх гэдэгт олон нийт тайлантай танилцах, мэдээлэл авах, судалгаа хийхэд хялбар, энгийн, ойлгомжтой байхыг шаардах нь гарцаагүй. Энэ шаардлагыг хангах цахим систем ч юм уу арга замыг олон улсууд хэрхэн зөвлөж байна. Сайн туршлага нэрлэвэл?

-Олон улсын экспертүүд нь ашиглагдахуйц өгөгдөлтэй, судалгаа, дүн шинжилгээ, чадавх бэхжүүлэхэд тохиромжтой, өөрийн орны нөхцөл байдал, эрх зүйн орчны онцлогийг харгалзсан, дотоодын хууль тогтоомжид нийцсэн, олон улсын туршлагыг харгалзсан сонгуулийн зардлын хяналт хэрэгжүүлэх программ хангамжийг нэвтрүүлэхийг зөвлөдөг. Улс орнуудаас цөөн орон энэ төрлийн системийг нэвтрүүлж эхлээд байна. Манай улс энэ цөөн хэдэн орны нэг. Сайн туршлага гэдэг сайжруулж болох л туршлагыг хэлээд байгаа ч ихэвчлэн программ хангамжиндаа биш төрийн албан хаагчдын чадавхи, санаачлагаас хамаарч өөр өөр байна. Тиймээс бид цаашдаа олон улсын туршлагаас юу сурах ёстой вэ гэвэл бид өөрсдийгөө, төрийн албан хаагчдыг, улс төрийн намуудыг, дата аналистууд, судлаачдыг бэлтгэх, дагнаж мэргэшүүлэх нь илүү оновчтой. Жишээ нь Эстонид сайн хэрэгжсэн туршлага заавал манайд бас сайн жишээ болох нь ховор. Дотоодын онцлогоо, хөгжлийн үе шатаа тооцоолсон өөрсдийн туршлагатай болох нь бидэнд л хэрэгтэй.

-Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд манай улсын хувьд нам эвсэл болон төр, иргэний нийгмийн байгууллага, тэдгээрийн хүний нөөц бэлэн болов уу?

-Холбогдох сургалтыг үе шаттай явуулахаар төлөвлөгөөнд тусгасан. Бүх талыг чадавхжуулах, программ ашиглахад шаардлагатай мэдээлэл, сургалтыг олгох, ялангуяа улс төрийн намуудад мэдээлэл оруулах, мэдээллээ засах, нэмэх, хавсаргах, мэдээлэл авах зэргээр шаардлагатай чадавхыг олгох тусгайлсан сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулах шаардлагатай.

-Манай улс энэ тогтоолыг батлуулахад зохиогчоор багагүй үүрэг хүлээсэн. Хэрэгжилтийг сайн хангаснаар олон улсын өмнө зохиогчийн байр сууриа хадгалах, авлигын индексээр байр урагшлах ч юм уу ач холбогдолтой биз?

-Авлигын төсөөллийн индексийн төрөлжсөн олон эх сурвалжийн заримаар улс төрийн цэвэр байдал, нам, нэр дэвшигчдийн санхүүжилтийн ил тод байдал, хариуцлага зэрэг үзүүлэлтүүд үнэлэгддэг. Жишээ нь Ардчиллын индексээр үнэлнэ. Гэхдээ дан ганц улс төрийн нам, сонгуулийн санхүүжилтийг ил тод болгосноор индексэд шууд нөлөө үзүүлэхгүй ч дам байдлаар нийгэмд авлигыг бууруулахад ихээхэн дэмтэй. Төрөөс авлигын эрсдэлийг оновчтой онилж, эрсдэлийг хөгжөөдөг бусад асуудлыг зэрэг шийдэж чадвал индексэд эерэг нөлөө үзүүлнэ.

“МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ: АРДЧИЛСАН СОНГУУЛЬ”

СЭДЭВТ ШИЛДЭГ ИТГЭЛИЙН УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 34 жилийн ой, “Үндсэн хуулийн өдөр”-ийг тохиолдуулан Монгол Улсын төр нийгмийн зүтгэлтэн, Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит 17 дахь удаагийн шилдэг илтгэлийн уралдааныг Үндсэн хуулийн цэц, Сонгуулийн ерөнхий хороо, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, “Чимид сан” ТББ зохион байгууллаа.

Энэ удаагийн уралдааныг “Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал: Ардчилсан сонгууль” сэдвийн хүрээнд зохион байгуулсан бөгөөд 50 гаруй бүтээл ирүүлснээс I шатанд шалгарсан ангилал тус бүрийн таван илтгэлийг II шатанд хэлэлцүүлэв.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүгч Ц.Цогт, Үндсэн хуулийн цэцийн гишүүн асан, Монгол Улсын гавьяат багш Д.Солонго, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, “Чимид сан” ТББ-ын тэргүүн Ч.Сайнсанаа нар уралдааны II шатны илтгэлүүдийг шүүж дараах бүтээлүүдийг шалгаруулав.

ОЮУТНЫ АНГИЛАЛ

Оюутны ангилалд тэргүүн байрын шалгуур хангах илтгэл хэлэлцүүлсэнгүй гэж шүүгчид үзлээ.

2 дугаар байр: МУИС-ийн Хууль зүйн сургуулийн гуравдугаар түвшний оюутан Г.Ганбилэг “Намын жагсаалт бүхий сонгуулийн тогтолцоонд улс төрийн намын дотоод ардчилал”

3 дугаар байр: ДХИС-ийн 542 дугаар дамжааны сонгогч Г.Хулан “Сонгуулийн зардлын ил тод байдал ба хяналт”

Тусгай байр:

- МУИС-ийн оюутан Л.Азаяа “Сонгогчдын боловсрол ба төрийн үүрэг”
- МУИС-ийн оюутан Б.Алтан “Үндсэн хуулийн үзэл баримтлал: Ардчилсан сонгууль ба абсентизм”

СЭЗДС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан Д.Ууганзаяа, Д.Даваажаргал “Монгол Улсын Үндсэн хуулийн ардчилсан сонгуулийн зарчим ба Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны шинэтгэлийн үр нөлөө, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга зам: Холимог тогтолцооны эрх зүй, улс төрийн харьцуулсан судалгааны жишээн дээр”

СУДЛААЧИЙН АНГИЛАЛ

1 дүгээр байр: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн Судалгааны хэлтсийн судлаач Б.Сарантуяа “Үндсэн хуульд ёс ба ардчилсан институцийн хөгжил: Сонгуулийн төв байгууллагын бүтэц-чиг үүргийн бие даасан байдалд өгөх санал”

2 дугаар байр: Шихихутаг их сургуулийн Судалгааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Т.Түвшинжаргал “Үндсэн хуулийн удиртгал Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрийн үндэслэл болох нь (сонгуулийн эрхийн маргааны хувьд)”

3 дугаар байр: Хуульч М.Амина “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн параллель холимог тогтолцоо дахь намын жагсаалтаар хувь тэнцүүлэх тогтолцооны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь”

Шилдэг илтгэлүүдийг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн “Үндсэн хууль ба эрх зүйт ёс” эмхэтгэл болон Сонгуулийн ерөнхий хорооны “Сонгуулийн боловсрол” онол, арга зүйн сэтгүүлд нийтэлнэ.

Уралдааны зохион байгуулалтад Хүний эрхийн үндэсний комисс, Шүүхийн ерөнхий зөвлөл, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн, Удирдлагын академи, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Шүүхийн академи, Монголын хуульчдын холбоо, Эрх зүйт ёс сан хамтран оролцов.





**Хүний эрхийн үндэсний
комиссын дарга
Д.СҮНЖИД**

“Б.Чимид багшийн нэрэмжит 17 дахь удаагийн уралдаанаар оюутан, судлаачид ардчилсан сонгууль гэж юу гэдгийг тойрсон илтгэлүүдийг хэлэлцүүллээ. Судлаачдын бичсэн судалгаа, танин мэдсэн зүйлийг оюутнууд сурах, дадах хэрэгжүүлэх ач холбогдолтой юм. Эрх бүхий байгууллагын албан хаагчид асуудлыг мэдрэх, ойлгох хэрэгцээг хангах ач холбогдолтой юм. Өнгөрсөн хугацаанд зохион байгуулсан сонгуулийн сургамж юу байв, юунд анхаарах вэ гэдгийг тойрч хэлэлцлээ. Үндсэн хуульд суурилсан, практик шийдэлтэй байх ёстойг эрдэмтэн, судлаачид, оюутнууд тал талаас хөндөж

байна. Эрэл хайгуул хийсэн байна, олон шинэлэг санаа гарч байна. Оролцогчид харьцуулсан судалгаа хийж байгааг олзуурхлаа.

Бид сонгуулийн үр дүнд илүү анхаарал хандуулах биш сонгуулийн явц, зохион байгуулалт, мөн иргэдийн улс төрийн ойлголт, мэдлэгт илүү анхаарах ёстой. Иргэдээс засгийн эрх үүсдэг бол иргэд улс төрийн ойлголт, мэдлэгтэй байх нь зүй ёсны хэрэг. Тиймээс сонгуулийн боловсролд анхаарахаас өөр аргагүй. Сонгуулийн боловсролыг дээшлүүлэхэд сонгуулийн эрх зүйн хөгжил маш чухал байр суурьтай.



**Сонгуулийн ерөнхий
хорооны Тамгын газрын
дарга Д.БАТ-ЭРДЭНЭ**

“Сонгуулийн эрх зүй, сонгуулийн процессын эрх зүйн судлаачдыг нэмэгдүүлэх, судалгааны бүтээлийг олшруулах, эргэлтэд оруулах нь Сонгуулийн ерөнхий хорооны гол зорилт. Энэ ч агуулгаараа Б.Чимид багшийн нэрэмжит илтгэлийн уралдааныг Үндсэн хуулийн цэц, Сонгуулийн ерөнхий хороо, “Чимид сан” хамтран зохион байгууллаа.

Энэ удаагийн илтгэлийн уралдаанаар сонгуулийн процессыг ярихаас эхлээд Үндсэн хуульд үзэл баримтлалын хувьд юу гэж тусгасныг тодруулж харуулах зорилготой байлаа.

Оролцогчдын хувьд оюутны ангилалд маш олон бүтээл ирсэн нь сонгуулийн эрх зүйн салбарт судалгаа, шинжилгээний маш их орон зай байгааг илтгэн харуулж байна.



**Үндсэн хуулийн Цэцийн
зөвлөх, Монгол Улсын
гавьяат багш, Хууль зүйн
ухааны доктор профессор
Д.СОЛОНГО**

“Б.Чимид багшийн нэрэмжит эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийг сонсож, судлаач оюутнуудаа байр эзлүүлж шагнах нь тун сайхан номын хуримын арга хэмжээ юм юм.

Түүхэндээ 1924, 1940, 1960, 1992 онд дөрвөн Үндсэн хууль баталж, мөрдөж

ирсэн. Ухаан орсон жаахан хүүхдээс эхлээд өтөл насны бүх хүн Үндсэн хууль бол миний амьдралд чухал, хэрэгтэй, амьдралын нэгэн баталгаа болох зүйл гэдгийг 1992 оны Үндсэн хуулиас хойш ойлгож, жилээс жилд улам бүр мэдэрч эрхэмлэн дээдэлдэг болсон нь ажиглагддаг.

Б.САРАНТУЯА:

СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГА ХАРААТ БУС АЖИЛЛАХ ХУУЛЬ ЗҮЙН БОЛОМЖ БИЙ БОЛОВЧ БҮРЭЛДЭХҮҮН, ИНСТИТУЦИЙН ДОТООД БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАХ ЗОХИЦУУЛАЛТ ДУТМАГ



Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн Судалгааны хэлтсийн судлаач Б.Сарантуяатай ярилцлаа. Тэрбээр Ардчилсан шинэ Үндсэн хуулийн эхийг баригч Б.Чимидийн нэрэмжит 17 дахь удаагийн эрдэм шинжилгээний өгүүллийн уралдаанд “Үндсэн хуульт ёс ба ардчилсан институцийн хөгжил: Сонгуулийн төв байгууллагын бүтэц-чиг үүргийн бие даасан байдалд өгөх санал” бүтээлээрээ тэргүүн байр эзэлсэн юм.

-Ардчилсан шинэ Үндсэн хуулийн эхийг баригч Б.Чимидийн нэрэмжит 17 дахь удаагийн эрдэм шинжилгээний бүтээлийн уралдаанд тэргүүн байр эзэлсэнд баяр хүргэе. Таны судалгааны зорилгоос ярилцлагаа эхэлье.

-Баярлалаа, Сонгуулийн төв байгууллагын бүтэц-чиг үүргийн бие даасан байдалд өгөх санал судалгаагаараа Ардчилсан шинэ Үндсэн хуулийн эхийг баригч Б.Чимидийн нэрэмжит эрдэм шинжилгээний уралдаанд тэргүүн байр эзэлсэндээ баяртай байна.

Миний судалгаа 2 үндсэн зорилготой, хэд хэдэн асуултад хариулт олох үүднээс хийгдсэн. Ардчилсан Монгол Улсад зохион байгуулагдсан 9 удаагийн УИХ-ын, 8 удаагийн

Ерөнхийлөгчийн сонгууль, мөн орон нутгийн сонгуулийг Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ) амжилттай зохион байгуулж, төрийн эрх мэдлийг тайван замаар шилжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж ирсэн. Тийм ч учраас сонгуулийн төв байгууллагын бүтэц, чиг үүргийг харьцуулан судлах нь нэгдүгээрт, сонгуулийн удирдлагын байгууллагын шударга, үр нөлөөтэй загварыг тодорхойлох, хоёрдугаарт, СЕХ-ны хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх оновчтой санал дэвшүүлэх үндсэн зорилготой байсан. Үүний тулд, судалгааны хүрээнд СЕХ бүтэц, чиг үүргийн хувьд хэр бие даасан бэ?; Бие даасан байдлыг хангах эрх зүйн ба практик баталгаанууд хэр ажиллаж байна вэ?; Ямар чиглэлд шинэчлэл, сайжруулалт шаардлагатай вэ? гэдэгт хариулт өгөхийг хичээсэн.

-Олон улсад сонгуулийн төв байгууллагын чиг үүрэг, бүтцийг хэрхэн тодорхойлсон байна вэ?

-Олон улсын түвшинд сонгуулийн төв байгууллагыг сонгуулийг шударга, ил тод, хараат бусаар зохион байгуулах үндсэн үүрэгтэй бие даасан институт гэж тодорхойлох нь түгээмэл байдаг. Онолын үүднээс тайлбарлавал, бүтцийн хараат бус байдал гэдэг нь сонгуулийн төв байгууллагууд Засгийн газрын салбар, ялангуяа гүйцэтгэх засаглалаас хараат бус, бие даасан байхыг ойлгоно. Чиг үүргийн хараат бус байдал гэдэгт чиг үүргээ гадны нөлөөлөл, дарамт шахалтгүйгээр гүйцэтгэх чадварыг ойлгоно. Бүтэц-чиг үүргийн үүднээс хамтад нь судлахад 1) эрх хэмжээний бие даасан байдал; 2) бүтцийн бие даасан байдал; 3) нөөцийн бие даасан байдал; 4) чиг үүргийн бие даасан байдал тухайн институтэд бий эсэх асуудал хөндөгддөг. Үүнээс чиг үүргийн бие даасан байдал нь сонгуулийн төв байгууллага 1) Бие даасан, 2) Засгийн газрын 3) Холимог гэсэн загварын алинд нь хамаарах талаар судалдаг. Эдгээрийг тус бүрд нь товч танилцуулбал, Засгийн газрын загвартай улсын сонгуулийн төв байгууллага нь гүйцэтгэх засаглалыг хэрэгжүүлэгч яам эсвэл орон нутгийн эрх бүхий байгууллагын удирдлага дор байх бөгөөд сонгуультай холбоотой бодлого тодорхойлж, хяналт хэрэгжүүлдэг. Холимог загвартай улсын хувьд сонгуулийн төв байгууллага эсхүл хяналт хэрэгжүүлэгч субъектийн аль нэг нь Засгийн газрын удирдлагад харьяалагддаг. Өөрөөр хэлбэл, сонгуультай холбоотой бодлого тодорхойлох нэгж засгийн бүтцэд хамаарч, хяналт хэрэгжүүлэх нэгж бие даасан байгууллагад хамаарах жишиг бий. Харин бие даасан загвартай улсын хувьд Засгийн газраас хараат бусаар байгуулагдаж, зохион байгуулагддагаараа онцлог бөгөөд Засгийн газрын өмнө хариуцлага хүлээдэггүй. Бүтэц-чиг үүргийн хувьд дэлхийн ихэнх улс (138 улс) Засгийн газраас хараат бус тогтвортой бүрэлдэхүүнтэй бие даасан загварыг хэрэглэдэг.

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БҮС НУТАГТАА ХАРЬЦАНГУЙ ТОГТВОРТОЙ, ИНСТИТУЦИЙН ЧАДАВХТАЙ ЖИШИГТ ТООЦОГДДОГ

-Манай улсын сонгуулийн төв байгууллагын чиг үүрэг, бүрэлдэхүүн аль улстай төстэй, онцлог, ялгаа нь юу байв гэдгийг судлахад ямар дүгнэлтэд хүрсэн бол?

-Судалгаагаар Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо нь бие даасан загварт хамаарах үндсэн шинжүүдийг хангадаг буюу байнгын ажиллагаатай, гүйцэтгэх эрх мэдлийн өмнө хариуцлага хүлээдэггүй, үйл ажиллагааны хэрэгжилтийг өөрөө бүрэн хариуцдаг, эрх мэдлийн хувьд бие даасан, Төсвийн хувьд бие даасан байна. Харин үндсэн шинжүүдээс (1) бүрэлдэхүүний бие даасан байдал хангагдсан эсэх, (2) бүрэн эрхийн хугацаа хуульчлагдсан эсэхэд холбогдох зохицуулалт сул, эргэлзээтэй, шинэчлэл шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Дэлхий дээр сонгуулийн удирдлагын байгууллагатай, сонгууль зохион байгуулдаг 210 гаруй улс байна гэж АСДОУХ-



ээс нээлттэй өгөгдөлдөө мэдээлсэн байдаг. Үүнээс Монгол Улстай ижилхэн бие даасан загварт хамаардаг 138 (64.79%) улс байдаг. Тэдгээрээс би судалгааныхаа хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Эстони Улсыг хамруулан авч үзсэн. Харьцуулсан судалгаагаар судалсан хоёр улсын хувьд үндсэн чиг үүрэг, зохион байгуулалтын хэлбэр нь төстэй. Ялгаатай тал нь бүрэлдэхүүнийг сонгох, томилох, бүрэн эрхийн хугацаанд холбогдох зохицуулалт байсан. Тухайлбал, Бүгд Найрамдах Эстони Улсын хувьд сонгуулийг хороог бүрдүүлэхдээ Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс анхан болон давж заалдах шатны 2 шүүгчийг, Хууль зүйн сайдаас 1, Ерөнхий Аудитороос 1, Улсын ерөнхий прокуророос 1, Төрийн нарийн бичгийн даргаас 1, Эстонийн Аудиторуудын холбооны удирдлагын зөвлөлөөс 1 орон тоог санал болгох замаар олон талт төлөөллийг оруулж томилгоог хийдэг онцлогтой бөгөөд бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байдаг. Бүгд Найрамдах Солонгос улсын хувьд Үндэсний сонгуулийн хороо нь 9 комиссараас бүрдэх ба гурвыг нь Ерөнхийлөгч, гурвыг нь Үндэсний ассамблей, гурвыг нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч санал болгож ба Үндэсний ассамблейд нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулдаг. Хорооны гишүүд дундаасаа даргаа сонгох бөгөөд хэн нэгэн субъект даргыг томилдоггүй зохицуулалттай байдаг. Үүнээс үзэхэд Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо нь чиг үүрэг, зохион байгуулалтын хувьд бие даасан загварт хамаарч байгаа ч бүрэлдэхүүнийг нэр дэвшүүлэх, томилох механизм, бүрэн эрхийн хугацааны эрх зүйн зохицуулалтын хувьд харьцуулан судалсан улсуудтай харьцуулахад илүү тодорхой, олон талт төлөөллийг хангах шинэчлэл хийх шаардлагатай байна.

-Бүрэлдэхүүний бүтэц, ажиллах хугацаан дээр та санал дэвшүүлсэн. Энэ талаар дэлгэрэнгүй яриач.

-Бүрэлдэхүүний бие даасан байдалтай холбогдуулан судлахад, Венецийн комиссоос бие даасан байгууллагыг бүрдүүлэхэд баримтлах зарчмыг "бие даан ажиллах хамтын удирдлага бүхий байгууллагын томилгоо нь улс төржилтийг сааруулж хийгдэх ёстой" хэмээсэн байдагт үндэслэн саналаа боловсруулсан. Өөрөөр хэлбэл, Сонгуулийн ерөнхий



хорооны бүрэлдэхүүнд Ерөнхийлөгчийн зүгээс санал болгодог хоёр гишүүний бүрэн эрхэд холбогдох хуулийн шинэчлэлийг хийхдээ бие даасан хараат бус байдлыг хангах үүднээс мэргэжлийн этгээдийн оруулах зохицуулалт хийх (их сургуулийн багш, өмгөөлөгч, хуульч, иргэний нийгмийн төлөөлөл гэх мэт), нээлттэй нэр дэвших боломжийг бий болгох, нэр дэвшигч бүр дээр томилгооны сонгол хийж УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн хоёрны гурваар буюу олонх, цөөнхөд хүлээн зөвшөөрүүлж томилох зохицуулалтыг хуульчлах санал гаргасан.

Мөн “Нийтийн ашиг сонирхолд холбогдох шийдвэрийг гаргадаг байгууллагын даргын томилгоог гаднаас хийх ёсгүй”. Тиймд, даргыг гишүүд дотроосоо сонгодог байх нь хорооны бие даасан байдлын нэг баталгаа болно. Хорооны гишүүд даргаа өөрөө сонгодог байх нь хороо нэг гишүүн эсвэл даргын явцуу ашиг сонирхолд хөтлөгдөх хандлагаас зайлсхийж, тэнцвэртэй ажиллахад тусална” гэж Венецийн комиссын зөвлөмжид үндэслэн:

- Институцийн бие даасан, хараат бус байдлыг хангахын тулд Хорооны удирдлагыг гишүүд дотроосоо санал болгож, гишүүдийн олонхын саналаар тодорхой хугацаатайгаар томилох зохицуулалтыг хуульд оруулах;
- Бүрэлдэхүүний хараат бус байдлыг хангах үүднээс бүрэлдэхүүний гишүүнд тавигдах шаардлагыг хуулиар тодорхойлон заах;
- Сонгуулийн төв байгууллагын хараат бус, бие даасан байдлыг хангах үүднээс: Улсын дээд шүүх, Хүний эрхийн үндэсний комисс, Их сургуулиуд, Хуульчдын Холбоо, Улс төрийн нам зэрэг байгууллагуудаас нээлттэй сонголын үндсэн дээр УИХ-аас зургаан жилийн хугацаагаар томилохоор өөрчлөх нь хараат бус, бие даасан байдлыг хангаж улмаар чиг үүргээ хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй болно.

Бүрэн эрхийн хугацаанд холбогдуулан гаргасан саналын хувьд:

Нэгдүгээрт, хорооны бүрэлдэхүүний бүрэн эрхийн хугацааг томилж буй этгээдийн бүрэн эрхийн хугацаанаас

зөрөх ёстой байдлаар хуульчлах нь зохимжтой. Энэ нь томилгоог хийсэн этгээдээс хараат бус ажиллах, үйл ажиллагааг тогтвортой, залгамжтай байхад тустай олон улсын сайн туршлага болно.

Хоёрдугаарт, бүрэн эрхийн хугацаатай холбоотойгоор тодорхойгүй байдал үүсгэж буй “Хорооны гишүүний бүрэн эрх нь түүнийг томилсон тухай Улсын Их Хурлын шийдвэр гарснаар эхэлж, дараагийн гишүүн томилогдсоноор дуусгавар болно” гэх заалтыг хасах, хороо зургаан жилийн хугацаагаар томилох зохицуулалтыг хадгалсан тохиолдолд улиран сонгогдохгүй байх, бүрэн эрхийн хугацаа дууссан үед нөхөх томилгооны нөхцөлийг нарийвчлан хуульчлах шаардлагатай байна.

Нөгөөтээгүүр 2006 онд батлагдсан 5 удаа нэмэлт, өөрчлөлт орсон Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ шаардлага үүссэн хэмээн судлаачийн хувьд үзэж байна.

-Томилгооны тухайд?

Бүрэлдэхүүнийг томилох зохицуулалтад шинэчлэл хийхдээ АСДҮОУХ-ийн боловсруулсан бие даасан сонгуулийн төв байгууллагын бүрэлдэхүүний загвар болох 1) олон намын төлөөллөөс бүрдсэн сонгуулийн төв байгууллагын загвар, 2) мэргэжлийн экспертүүдээс бүрдсэн сонгуулийн төв байгууллагын загвар, 3) намын төлөөлөл болон мэргэжлийн экспертүүдээс бүрдсэн холимог бүрэлдэхүүнтэй сонгуулийн төв байгууллагын загваруудыг тус тус харгалзан үзэх; Сонгуулийн төв байгууллагын бүрэлдэхүүнд олон намын төлөөллөөс оруулах зохицуулалт хийхдээ томилогдох гишүүн намынхаа эрх ашгийг хамгаалах, сонгуулийг төв байгууллагаас гаргаж буй шийдвэрүүдийг харилцан хянах, зөвшилцөх зэрэг нөхцөлийг харгалзан хууль тогтоох байгууллагад суудалтай намын төлөөллөөс бүрдэх, эсхүл олонх болон сөрөг хүчнээс бүрдүүлэх байдлаар зохицуулалтыг хуулиар тогтоохыг санал болгосон.

-Сонгуулийн төв байгууллага улс төр, нам эвслээс хараат бус байх шаардлагатай. Судлаачийн хувьд дүгнэхэд Монгол Улсад ийм боломж хууль тогтоомжийн түвшинд болон томилгооны хүрээнд хангагдаж чадаж байна уу?

-Судлаачийн хувьд, Монгол Улсад сонгуулийн төв байгууллагын хараат бус байдлыг хангах эрх зүйн суурь зохицуулалт хууль тогтоомжийн түвшинд бий гэж үздэг. Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд СЕХ-г бие даасан, хараат бус байгууллага хэмээн тодорхойлох үндэс бий, мөн бүрэн эрхийн хугацааг зургаан жилээр тогтоосон нь олон улсын жишигт нийцсэн зохицуулалт юм. Гэвч томилгооны бодит механизмын хувьд авч үзвэл, улс төрийн нөлөөллийг саармагжуулах баталгаанууд хангалттай түвшинд хэрэгжиж чадахгүй байна гэж үзэж байна. Ялангуяа бүрэлдэхүүнийг бүрдүүлэхэд улс төрийн институцуд давамгайлж, мэргэжлийн, хараат бус этгээдийн оролцоо хязгаарлагдмал байгаа нь СЕХ-ны бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэхэд сорилт болно. Өөрөөр хэлбэл, Монгол

Улсад сонгуулийн төв байгууллага улс төрөөс хараат бус ажиллах хууль зүйн боломж бий боловч, уг боломжийг бодитой хэрэгжүүлэх томилгооны бүтэц, нээлттэй сонголт, тэнцвэртэй бүрэлдэхүүн, институцийн дотоод бие даасан байдлыг хангах зохицуулалт дутмаг байна. Энэ бол хууль тогтоогчийн бүрэн эрхийн асуудал. Тиймээс цаашид сонгуулийн төв байгууллагын хараат бус, бие даасан байдлыг бодитоор хангах, бэхжүүлэхийн тулд олон улсын сайн туршлагад нийцсэн, улс төржилтийг сааруулах томилгооны механизм бүхий эрх зүйн шинэчлэл зайлшгүй шаардлагатай гэж дүгнэж байна.

-Та олон улсын сонгуулийн байгууллагатай харьцуулж судалсан. Ер нь манай улсын сонгууль зохион байгуулах үйл ажиллагаа, сонгуулийн төв байгууллага аль түвшинд байна вэ. Олон улсад хэр үнэлэгддэг бол?

-Харьцуулсан судалгааны үүднээс авч үзвэл, Монгол Улсын сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагаа, Сонгуулийн ерөнхий хороо нь бүс нутагтаа харьцангуй тогтвортой, институцийн чадавхтай жишигт тооцогддог. Ялангуяа ардчилалд шилжсэнээс хойш сонгуулийг тогтмол хугацаанд, тайван замаар зохион байгуулж, төрийн эрх мэдлийг шилжүүлэх үйл явцыг тасралтгүй хангаж ирсэн нь олон улсын байгууллагуудын зүгээс эергээр үнэлэгддэг. НҮБ, АСДОУХ зэрэг олон улсын ажиглагч байгууллагын дүгнэлтүүдэд Монгол Улсын сонгуулийн ерөнхий үйл явц нь олон улсын стандартад нийцсэн, санал хураалт, тооллогын зохион байгуулалт харьцангуй ил тод явагддаг улс хэмээдэг.

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛЫГ ТАСРАЛТГҮЙ, ИНСТИТУЦЧИЛСЭН БАЙДЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ

-Сонгуулийн төв байгууллага сонгууль зохион байгуулахаас гадна сонгогчдын сонгуулийн боловсролыг дээшлүүлэх чиг үүрэгтэй. Ихэнх улс орнуудын сонгуулийн төв байгууллага дэргэдээ сонгуулийн боловсрол олгох байгууллага, тусдаа бүтэцтэй байдаг. Манай улсын тухайд ямар боломж байна вэ?

-Сонгуулийн боловсролыг дээшлүүлэх нь сонгогч санал өгөх үйл явц, журам, тогтолцоог зөв ойлгож, сонгуулийн үр дүнг хууль ёсны, итгэлтэй гэж хүлээн зөвшөөрөхөд чухал ач холбогдолтой. Олон улсын туршлагаас харахад сонгуулийн төв байгууллагын дэргэд сонгуулийн боловсрол, мэдээлэл, сургалт хариуцсан тусдаа нэгж, эсхүл бие даасан бүтэц ажиллуулах нь түгээмэл байдаг. Энэ нь сонгогчдод сонгуулийн эрх, үүрэг, санал өгөх журам, сонгуулийн тогтолцооны талаарх ойлголтыг тогтмол, системтэйгээр хүргэх боломжийг бүрдүүлдэг. Манай улсын хувьд Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн боловсролын чиглэлээр тодорхой ажлуудыг хийж ирсэн ч эдгээр нь ихэвчлэн сонгуулийн жилд төвлөрч, богино хугацааны шинжтэй байсан гэж судлаачийн хувьд дүгнэдэг. Харин сүүлийн жилүүдэд иргэдийн сонгуулийн боловсролыг

нэмэгдүүлэх чиглэлд илүү идэвхтэй, тогтвортой ажиллаж эхэлсэн нь сайшаалтай. Тухайлбал, цахим хуудсаараа дамжуулан улс төрийн намуудын мэдээлэл, хандив, тайлан зэргийг нээлттэй эх сурвалж хэлбэрээр байршуулж, сонгогчийн гарын авлага, "Сонгуулийн боловсрол" сэтгүүл, эмхэтгэл, товхимол зэрэг мэдээллийн материалыг олон нийтэд хүртээмжтэй болгосон. Энэ нь сонгогчдын боловсролыг дэмжихэд цахим эх сурвалжийг үр ашигтай ашиглаж буй жишиг гэж үзэж болно, нөгөөтээгүүр Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд хийгдэх ажлууд бий. Цаашид сонгуулийн боловсролыг тасралтгүй, институцчилсан байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ийм тогтолцоо бүрдсэнээр зөвхөн сонгогчдод төдийгүй сонгуулийн зохион байгуулагчид, улс төрийн нам, нэр дэвшигчдэд чиглэсэн сургалт, мэдээллийг тогтмол хүргэх боломжтой болж, улмаар сонгуулийн маргаан, зөрчлийг бууруулах, сонгуулийн соёлыг төлөвшүүлэхэд чухал хувь нэмэр оруулна.

-Сонгуулийн эрх зүйг хөгжүүлэх, судлаачдыг бэлтгэхэд төр, их дээд сургууль, иргэний нийгмийн байгууллага, улс төрийн намын үүрэг, оролцоо ямар түвшинд байх ёстой бол?

-Сонгуулийн эрх зүй, сонгуулийн институцийн хөгжлийг зөвхөн Сонгуулийн ерөнхий хорооны хүрээнд авч үзэх боломжгүй. Энэ бол олон талт оролцоонд суурилсан, хамтын ажиллагаа байх болов уу. Тухайлбал, төрийн байгууллагын хувьд эрх зүйн тогтвортой орчныг бүрдүүлэх, судалгаа, сургалтыг бодлогоор дэмжих үндсэн үүрэгтэй. Харин Сонгуулийн ерөнхий хороо энэ хүрээнд мэргэжлийн судалгаа, сургалтын санаачлагч, зохицуулагчийн үүрэг гүйцэтгэх нь зүйтэй бөгөөд сүүлийн жилүүдэд энэ чиглэлд анхаарч тогтмол үйл ажиллагаа явуулж буй нь сайшаалтай. Их, дээд сургуулиудын хувьд сонгуулийн эрх зүй, ардчилсан институцийн судалгааг академик түвшинд хөгжүүлэх, мэргэшсэн судлаач, шинжээч бэлтгэхэд голлох үүрэгтэй. Үүний тулд сонгуулийн эрх зүй, сонгуулийн институцийн хөгжилтэй холбоотой хичээлийн хөтөлбөрийг сургалтын төлөвлөгөөнд тусгах нь оюутнуудыг энэ чиглэлээр гүнзгийрүүлэн мэргэшиж судлах боломжийг нэмэгдүүлнэ. Иргэний нийгмийн байгууллагуудын хувьд сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, судалгааны үр дүнг бодит практикт ойртуулах, олон нийтэд таниулахад чухал үүрэг гүйцэтгэх ёстой. Энэ чиглэлээр ажиллаж буй төрийн бус байгууллагууд харьцангуй цөөн байгаа тул тэдний хүрээлэл өргөжих, харилцан уялдаа холбоотой хамтран ажиллах орчин бүрдэх нь чухал гэж үзэж байна. Харин улс төрийн намуудын оролцооны хувьд сонгуулийн эрх зүйг зөвхөн өөрийн ашиг сонирхлын үүднээс бус, ардчиллын тогтвортой хөгжлийн суурь институт хэмээн ухамсарлаж, шударга өрсөлдөөн, дотоод ардчиллыг дэмжих байр сууринаас оролцох шаардлагатай. Эдгээр субъектүүдийн уялдаа холбоо, харилцан тэнцвэртэй оролцоо хангагдсан нөхцөлд сонгуулийн эрх зүй тогтвортой хөгжиж, мэргэшсэн судлаачдын орчин бүрдэнэ гэж дүгнэж байна.

СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭДЭХ СУРГАЛТ, СУДАЛГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА БА МОНГОЛ УЛС

Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн ахлах референт **Б.НЯМСҮРЭН**

ТОВЧЛОЛ:

Ардчилсан нийгэмд сонгуулийн байгууллага нь зөвхөн сонгууль зохион байгуулах чиг үүрэгтэй бус, иргэд, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, сонгуулийн үйл явцыг судлах, үнэлэх чухал үүргийг гүйцэтгэдэг. Иймээс олон улс оронд сонгуулийн удирдлагын байгууллагын дэргэд сургалт, судалгааны чиг үүрэг бүхий тусгай нэгж, төв байгуулагдан, сонгогчийн боловсрол, судалгаа, бодлогын дүн шинжилгээг системтэй хэрэгжүүлж байна.

Энэхүү өгүүлэл нь сонгуулийн байгууллагын дэргэдэх сургалт, судалгааны байгууллагын олон улсын туршлагыг судалж, Монгол Улсын нөхцөл байдалтай харьцуулан шинжлэхэд чиглэсэн болно. Австрали, БНЭУ, БНСУ зэрэг улсын сонгуулийн байгууллагын дэргэхэд сургалт судалгааны байгууллагын бүтэц, чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг харьцуулсан шинжилгээг хийлээ.

Сонгуулийн байгууллагын дэргэдэх сургалт судалгааны байгууллагууд нь сонгогчдын боловсролыг тасралтгүй хөгжүүлж, судалгаанд суурилсан бодлого боловсруулах, сонгуулийн ил тод байдал, олон нийтийн итгэлцлийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Монгол Улсад Сонгуулийн ерөнхий хорооноос сонгогчийн боловсрол, мэдээлэл, сургалт, судалгааны ажлыг хэрэгжүүлж байгаа боловч олон улсын жишигт нийцсэн, бие даасан, төвлөрсөн сургалт, судалгааны институтын тогтолцоо хараахан бүрэн төлөвшөөгүй байна. Иймд олон улсын туршлагад тулгуурлан Сонгуулийн ерөнхий хорооны дэргэд сургалт, судалгааны байгууллагыг хөгжүүлэх нь ардчиллыг бэхжүүлэх, хариуцлагатай сонгогчийг төлөвшүүлэх, сонгуулийн байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

ТҮЛХҮҮР ҮГС:

сонгуулийн удирдлагын байгууллага, сонгогчид, сонгуулийн боловсрол, сургалт

I. ОРШИЛ:

Ардчилсан засаглалын үзэл баримтлал нь иргэдийн эрх чөлөө, тэгш оролцоо, сонгох болон сонгогдох эрхийг баталгаажуулахад тулгуурладаг. Сонгууль нь ардчиллын амин сүнс бөгөөд энэхүү үйл явцыг ил тод, шударга, хуулийн дагуу зохион байгуулах нь улс орны тогтвортой байдал, иргэдийн төрд итгэх итгэлийг бэхжүүлэхэд чухал суурь болдог.

Сонгуулийн удирдлагын байгууллага нь сонгуулийг шударга, ил тод, чөлөөтэй, хуулийн хүрээнд зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй бие даасан институци юм. Хуульч, докторант Д.Бат-эрдэнэ “Үндсэн хуульт ардчиллыг хамгаалах чиг үүрэг” судалгааны бүтээлдээ сонгуулийн удирдлагын байгууллага нь сонгууль зохион байгуулах үндсэн чиг үүргээ хэнээс ч хараат бусаар хэрэгжүүлэх, сонгогчдод сонгуулийн болон ардчиллын боловсрол олгох эрх зүйн болон бусад хүчин нөхцөл бүрдсэн эсэх нь үйл ажиллагааны бие даасан байдал гэсэн ойлголтод хамаарах

талаар¹ дурдсан байна.

Сонгуулийн удирдлагын байгууллага нь сонгуулийн хууль тогтоомж, сонгуулийн агуулга, сонгуулийн мөн чанарын талаарх мэдээлэл, сургалт буюу сонгогчдод сонгуулийн боловсрол олгох үйл ажиллагааг өргөн хүрээнд, тогтмол явуулж чадаж байгаа эсэх нь бие даасан, хараат бус байдлын шалгуур болж байдаг. Энэхүү шалгуур нь харьцангуй институтын чадавхтай холбоотой юм.²

II. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:

Нэг. Ерөнхий хандлага

Сонгогчдод ардчилал болон иргэний боловсрол олгох, мэдээлэл өгөх өргөн хүрээтэй үйл ажиллагаа нь сонгуулийн удирдлагын байгууллагуудын (СУБ) чиг үүрэгт улам бүр

1 Бат-Эрдэнэ, Д. (2024). Үндсэн хуульт ардчиллыг хамгаалах чиг үүрэг, УБ, 13 дахь тал.

2 Бат-Эрдэнэ, Д. (2024). Үндсэн хуульт ардчиллыг хамгаалах чиг үүрэг, УБ, 47 дахь тал.

нэмэгдэж байна. Зарим улсын СУБ-ын хууль тогтоомжид сонгогчдын мэдээлэл, боловсрол ажлыг зохион байгуулах үүргийг тодорхой заасан байдаг. Үүнд Бутан, Камбож, Кени, Латви, Литва, Сингапур, Өмнөд Африк, Тайланд, Тонга зэрэг улсууд орно. Харин Швед зэрэг зарим улсын хувьд ийм үүрэг хуульчлан заагаагүй байдаг. Зарим СУБ-ууд ардчиллын үнэт зүйлсийг (Коста-Рика), ардчилсан үйл явцыг (Лесото), сонгуулийн зорилго, утга учрыг (Гана), идэвхтэй иргэншлийг (Коста-Рика) дэмжих илүү өргөн мандаттай байдаг. Сонгуулийн боловсрол олгох үйл ажиллагааг ихэвчлэн санал өгөх магадлал багатай, эсхүл сонгуульд оролцоход саад бэрхшээлтэй тулгардаг бүлгүүдэд чиглүүлдэг. Балба улсын СУБ Австралийн СУБ-ын боловсролын төвүүдийн загварыг үндэслэн сонгуулийн боловсролын төв байгуулсан байна³.

Дэлхийн улс орнуудын сонгуулийн удирдлагын байгууллагууд нь сонгуулийг шударга, хараат бус зохион байгуулах үндсэн чиг үүргээс гадна сонгогчдод сонгуулийн боловсрол олгох чиг үүргийг хэрэгжүүлэхдээ өөрийн байгууллагын дэргэдэх бие даасан нэгжээр дамжуулан зохион байгуулдаг байна. Энэхүү бие даасан байгууллагууд нь тухайн орныхоо хууль тогтоомжийн хүрээнд Сонгуулийн төв байгууллагын дэргэдэх статустайгаар байгуулагдсан байдаг.

Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгээс (IDEA) гаргасан дэлхийн сонгуулийн байгууллагуудын үйл ажиллагааны судалгаанаас⁴ үзэхэд 28 улсын 30 байгууллага нь өөрийн байгууллагуудын дэргэд сонгуулийн боловсрол олгох сургалт, судалгааны төвүүдийг байгуулж, хараат бус бие даасан байдлаар үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр байгууллагуудыг үйл ажиллагааны чиглэлээр нь дараах байдлаар ангилж үзэж болно. Үүнд:

1. **Иргэд, сонгогчдод сонгуулийн боловсрол олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг улс орнууд.** Австрали, Замби, Коста Рика, Эквадор, Фижи, Гватемал, Хонг Конг, Балба, Панам, Парагвай, Тайланд зэрэг улс орнуудын сонгуулийн сургалт, мэдээлэл, судалгааны төвүүд нь зөвхөн иргэд, сонгогчдод сонгуулийн боловсрол олгох, мэдээлэл түгээх үйл ажиллагаа явуулдаг.
2. **Сонгуулийн байгууллагын ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг улс орнууд.** Бангладеш, Гана, Ирак, Киргизстан, Малайз, Мексик, Молдав, Нигери, Пакистан, Перу, ОХУ зэрэг улс орнуудад байгуулагдсан төвүүд нь сонгууль зохион байгуулах ба удирдах үүрэг гүйцэтгэж буй сонгуулийн ажилтнуудын чадавхыг нэмэгдүүлэх, сонгуулийн байгууллагын стандартыг хангуулах зорилготой байдаг байна.
3. **Холимог хэлбэрээр буюу иргэд, сонгогчдод сонгуулийн боловсрол олгох, сонгуулийн байгууллагын ажилтны чадавхыг дээшлүүлэх,**

судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг улс орнууд. БНСУ, Энэтхэг, Доминиканы БНУ, Йордан, Мексик, Перу улсад иргэд сонгогчид болон сонгуулийн байгууллагын ажилтнуудад чиглэсэн хосолмол байдлаар үйл ажиллагаа явуулдаг бол Гүрж, Колумбын хувьд судалгааны чиглэлд төвлөрсөн үйл ажиллагаа явуулдаг байна.

Эдгээр улс орнуудаас иргэд сонгогчдод чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг Австрали, холимог хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг БНСУ, БНЭУ улс орнуудын туршлагыг онцлон судаллаа.

Хоёр: Зарим улсын жишээ:

АВСТРАЛИ УЛС:

Австралийн Үндэсний сонгуулийн боловсролын төв (National Electoral Education Centre)⁵ нь Австралийн Сонгуулийн Комиссын байгуулалтын хууль, (Commonwealth Electoral Act 1918-ийн 7-р зүйлийн 1 дэх хэсгийн с)-д заасны дагуу байгуулагдсан Австралийн Сонгуулийн Комиссын (Australian Electoral Commission-AEC) харьяа, сонгуулийн болон иргэний боловсролын чиглэлээр мэргэшсэн үндэсний төв юм. Тус төв нь ардчилал, сонгуулийн үйл явцын талаарх ойлголтыг олон нийтэд нэмэгдүүлэх, сонгогчдын оролцоо, идэвхийг дэмжих, сурагч, оюутнуудад зориулсан системтэй сонгуулийн боловсрол олгох, ирээдүйн сонгогчдыг эртнээс бэлтгэх замаар ардчиллын тогтвортой байдлыг хангах, ардчилал, сонгуулийн тогтолцооны талаарх мэдлэгтэй, ухамсартай сонгогч болгон төлөвшүүлэх зорилготойгоор үйл ажиллагаа явуулдаг.

Сургуулиуд Канберра дахь **Үндэсний Сонгуулийн Боловсролын Төв (NEEC)**-д очиж сонгуулийн боловсролын хөтөлбөрүүдэд хамрагдах боломжтой бөгөөд **AEC for Schools** вэбсайт нь сургуулийн сонгууль зохион байгуулах материалуудыг багтаасан үнэ төлбөргүй боловсролын нөөц, хөтөлбөрүүдийг санал болгодог. Багш нарт зориулсан мэргэжлийн хөгжлийн сургалтууд нь бага болон дунд сургуулиудад сонгуулийн боловсролыг идэвхжүүлэхэд чиглэдэг.

Гурван өөр сургалтын орчноор дамжуулан оролцогчдын сонгуулийн тогтолцооны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхийг зорьсон. Үүнд:

- сонгуулийн үйл явдлуудын түүхэн нөхцөлийг танилцуулах жижиг театр;
- сурагчид Австралийн өнөөгийн сонгуулийн үйл явцын талаар интерактив байдлаар суралцах өрөө;
- сонгуульд санал өгөх, тоолох үйл явцыг туршиж үзэх санал авах байр.

NEEC нь нийслэл хот дахь ижил төрлийн боловсролын байгууллагууд болон Үндэсний Нийслэлийн Боловсролын Төсөлтэй тогтмол уулзаж, зарим тохиолдолд хамтран ажилладаг. Эдгээр байгууллагад Австралийн Ардчиллын Музей болон Парламентын Боловсролын Алба багтана.

3 Catt, H., Ellis, A., Maley, M., Wall, A., & Wolf, P. (2014). Electoral Management Design: Revised Edition. Stockholm: International IDEA.p.82

4 <https://www.idea.int/news/training-education-and-research-electoral-administration-investing-excellence>

5 <https://education.aec.gov.au/m>



Нийслэлд зорчиж буй сурагчид “төлөөллийн ардчилал” зэрэг сэдвүүдэд төвлөрсөн, уялдаа бүхий аяллуудад хамрагддаг. Байгууллагууд хоорондоо хамтран ажилласнаар сургалтын хөтөлбөртэй уялдсан ойлголтуудыг нэг мөр ойлгогдсон байдалд хүргэх, мөн байгууллага бүрийн сургалтын загварын өнөөгийн ач холбогдлыг хадгалсан шилдэг үйлчилгээг үзүүлэхийг зорьдог байна.

Австрали улсын туршлагаас үзэхэд сонгогчдод сонгуулийн боловсрол олгох үйл ажиллагааг цахим болон танхимын сургалт, танилцах аялал, хэлэлцүүлэг гэх мэт олон арга хэмжээг дангаар болон боловсролын байгууллага, багш нартай хамтран ажилладаг байна.

Монгол Улсын хувьд Сонгуулийн ерөнхий хороо нь 2021 оноос Хариуцлагатай сонгогч хөтөлбөрийг хэрэгжүүлж, 21 аймаг, 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн 3000 гаран сурагчдад сонгуулийн боловсрол олгох ажлыг амжилттай зохион байгуулсан. Сонгогчдын боловсрол олгох үйл ажиллагааг боловсролын салбартай хамтран хэрэгжүүлэх нь маш үр дүнтэй байсан. Австрали улсын жишгээр сурагчдын хөтөлбөрүүд боловсруулах, танхимаар болон **Цахим сургалтын платформ** хөгжүүлж, сонгогчдод санал өгөх ач холбогдлыг ойлгуулах сургалт явуулах боломжтой.

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС:

Бүгд найрамдах Солонгос Улсын Үндэсний сонгуулийн комиссын дэргэд Сонгуулийн хорооны хуульд (Election Commission Act, Article 15-2) заасныг үндэслэн Ардчиллын төлөөх Солонгосын иргэний боловсролын хүрээлэн (Korean

Civic Education Institute for Democracy⁶-г анх 1996 онд байгуулжээ.

Хүрээлэн нь сонгогч, сонгуулийн ажилтан, улс төрийн намын ажилтан, бусад ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах, судалгааны үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Боловсрол төлөвлөлтийн газар, Иргэний боловсролын газар Улс төрийн тогтолцоо судалгааны газартай. Боловсрол төлөвлөлтийн газар нь хүрээлэнгийн үйл ажиллагаа, гадаад харилцаа, ажилтнуудын сургалт, сургалтын төлөвлөлтийг, Иргэний боловсролын газар нь сонгогч, сонгуулийн ажилтан, улс төрийн намын ажилтнуудад зориулсан сургалтын асуудал, Улс төрийн тогтолцоо судалгааны газар нь цахим боловсрол, судалгааны менежмент, сургалтын хөтөлбөр, сургалтын агуулгын судалгаа, бүтэн цагийн багш нарыг хариуцан ажилладаг байна. Хүрээлэн нь өөрийн зорилгыг “Дэвшилтэт Солонгос улсын ардчилсан үзэлтэй иргэдийг бэлтгэх”, зорилтоо “Иргэний боловсролыг дээшлүүлэх замаар ардчилсан үзэл бүхий иргэдийг бэлтгэх, шинэлэг орчныг бий болгоход манлайлах сонгуулийн удирдлагын шинжээчдийг бэлтгэх” гэж томьёолсон.

Хүрээлэн нь сургалт судалгааны ажлынхаа хүрээнд дараах хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: Сонгуулийн менежментийн хөтөлбөр, 10 жилийн сурагч, их сургуулийн оюутнуудад зориулсан хөтөлбөр, сургуулийн багш нарт зориулсан хөтөлбөр буюу сургуулийн хөтөлбөрийн хүрээнд иргэний боловсролын суурь мэдлэгийг олгох зорилготой бөгөөд иргэний боловсролын ажлын сургалт, ажил дээр явагдах лекц орох зэрэг төрлөөр хэрэгждэг бөгөөд сургалтын агуулгад хүүхдийн сэтгэлгээг

задлах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх дасгал орно. ТББ-ын ажилтнууд, сэтгүүлчдэд зориулсан хөтөлбөр хэрэгжүүлдэг. Мөн их сургуулийн оюутнуудад зориулсан иргэдийн хандлага, сэтгэлгээ, манлайллыг хөгжүүлэхээс гадна улс төрийн оролцооны тухай хөтөлбөрүүд багтана. Сургалтын төрлөөр нь ангилбал:

1. Сонгуулийн ажилтнууд буюу төрийн албан хаагчдад зориулсан сургалт

Сонгуулийн ажилтнуудын мэргэшлийн чадавх, ажлын гүйцэтгэл, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн уг сургалтыг системтэйгээр зохион байгуулахдаа ажлын байранд эсвэл сонгуулийн байранд зохион байгуулж байна.

Үндсэн сургалтад шинэ албан хаагчийн сургалт, шинэ удирдлагын сургалт, үндсэн чадвар хөгжүүлэх сургалт нь ажилтан, албан хаагчийн түвшинд явагддаг.

Мэргэжилтнүүдийн сургалтад гадаад оронд сонгууль зохион байгуулах сургалт, манлайлал, өрсөлдөх чадварын сургалт, өрсөлдөх чадварын үнэлгээний сургалт, сургагч багшийн сургалт зэрэг багтана.

2. Сонгогчдын сургалтыг олон чиглэлээр явуулдаг. Үүнд:

Иргэний боловсролыг дээшлүүлэхэд зориулсан сургалт нь нийгмийн бүхий л түвшний иргэдэд тухайлбал залуучууд, сонгогчид, улс төрийн намын ажилтнуудад чиглэгдэн зохион байгуулагддаг.

Сонгогчийн сургалт – илтгэлийн уралдаан, их сургуулийн оюутан, багш нарт, иргэний нийгмийн байгууллага, залуучуудад зориулсан сургалтууд орно.

Сонгуулийн болон улс төрийн намын ажилтны сургалт – улс төрийн намын ажилтнуудын боловсрол, нэр дэвшигчдийн сонгуулийн академи,

Мэргэжилтний сургалт - ардчилсан иргэдийн улс төрийн академи, иргэний боловсролын сургагч багшийн сургалт гэх мэт.

3. Гадаадын оршин суугчдад зориулсан сургалт

Төрийн албаны сонгуулийн тухай хуульд 2006 онд оруулсан өөрчлөлтийн дагуу БНСУ-д оршин суугаа гадаадын иргэд орон нутгийн сонгуульд оролцож санал өгөх эрхийг хуульчилжээ. Санал өгөх иргэд хэд хэдэн шаардлагыг хангасан байх ба тухайлбал, 19-с дээш насны, байнгын оршин суух зөвшөөрөлтэй, гадаад оршин суугчдын бүртгэлд бүртгэгдсэн байх, байнга оршин суух зөвшөөрөл өгснөөс хойш 2 жил өнгөрсөн байх зэрэг болно. Тэдгээр иргэдэд зориулсан сургалтаар БНСУ-ын сонгуулийн тогтолцоо, санал өгөх туршилтын хичээл, цэвэр, шударга сонгуулийн ач холбогдлын талаарх мэдээллийг олгодог.

БНСУ-ын туршлагаас үзэхэд сонгуулийн төв байгууллагын дэргэд бие даасан тусдаа байгууллага байгуулж, ардчилал, сонгуулийн боловсрол олгох үйл явцыг улс орон даяар өргөн хүрээнд явуулах боломж бүрддэг

байна.

Монголд: ирээдүйн сонгогчдод ардчилал, сонгуулийн талаарх мэдлэг түгээж, залуусын улс төрийн боловсролыг системтэй дэмжих боломжтой.

БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС:

Энэтхэгийн Сонгуулийн Комисс нь Энэтхэгийн Үндсэн хуулийн 324-р зүйлийг үндэслэн сонгуулийн байгууллагын ажилтнуудын мэргэжлийн чадавхыг сайжруулах, ард түмний оролцоог дэмжих, илүү бат бөх ардчилсан институтуудыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах болон Энэтхэгийн сонгуулийн комиссын эрх үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор Энэтхэгийн Олон Улсын Ардчилал болон Сонгуулийн Удирдлагын Институт (India International Institute of Democracy and Election Management, IIIDEM)⁷-ийг байгуулжээ.

Тус байгууллагын үндсэн үүрэг нь Сонгуулийн Комиссын удирдлага дор ажиллаж буй сонгуулийн байгууллагын ажилтнуудыг тасралтгүй сургаж, чадавхыг нь сайжруулах, сонгогчдыг сонгуулийн талаарх мэдээллээр хангах явдал юм.

Үйл ажиллагааны хувьд Ерөнхий захирал удирддаг бөгөөд дараах мэргэжлийн төвүүдийг байгуулан ажиллуулдаг байна.

1. **Сургалт ба Чадвар хөгжүүлэх төв** - Энэхүү төв нь сонгууль зохион байгуулалттай холбоотой сургалт, дахин сэргээх сургалт, сэдэвт хөтөлбөрүүдийг өргөн хүрээтэйгээр зохион байгуулах зорилготой. Дүүргийн сонгуулийн байгууллагын албан хаагчид, зохион байгуулагчид болон сонгуулийн байгууллагын албан хаагчдад чиглэсэн шатлалтай сургалтын арга барилыг хүргэх үндэсний түвшний ахлах сургалт зохион байгуулагчдын (NLMs) багийг хөгжүүлсэн.
2. **Олон улсын хамтын ажиллагаа ба чадавхыг бий болгох төв** - Энэхүү төв нь олон улсын хамтын ажиллагааг хариуцдаг бөгөөд гадаад дахь сургалтыг хөгжүүлэх, олон улсын сонгуулийн байгууллагуудтай хамтрах, бусад олон улсын семинаруудыг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулахад төвлөрдөг.
3. **Мэдээлэл технологи ба цахим сургалтын төв** - Энэ төв нь цахим сургалтын LMS-ийг хөгжүүлэх, мэргэжлийн чанарт хүрэхийн тулд ашиглагдаж буй модулиудыг сайжруулах үүрэгтэй. Мөн төв нь Энэтхэг болон дэлхийн бусад газруудын цахим сургалтын байгууллагуудтай /институцүүдтэй/ түншлэл байгуулдаг.
4. **Сонгогчдын боловсролын төв** - Энэ төв сонгогчдын боловсролын чадавхыг хөгжүүлэх, сонгогчдын боловсролд олон улсын шилдэг туршлагыг баримтжуулах болон энэ салбарт олон улсын

хамтын ажиллагааг албан ёсоор хэрэгжүүлэх зорилготой.

5. **Шинэчлэл, Судалгаа ба Баримтжуулалтын төв** - Энэ сонгуулийн мэдээллийн судалгаа хийх, шинэчлэлийг дэмжих, сонгуулийн төрөл бүрийн сэдвээр баримт бичиг бэлтгэх ажил гүйцэтгэнэ. Мөн төв нь сонгуулийн талаар хамтарсан төсөл, судлагдахуун боловсруулалтын үүднээс академик институтуудтай харилцана.

Энэтхэгийн сонгууль дэлхий даяар ихээхэн сонирхол татдаг бөгөөд ЕСИ нь гадаадын Сонгуулийн Менежментийн Байгууллагуудаас (ЕМВ) сургалт ба чадавхыг нэмэгдүүлэх талаар байнга хүсэлт авч байдаг бөгөөд ингэснээр тэдний сонгуулийн албан хаагчдыг тасралтгүй шинэчилсэн ур чадвар, чадамжтай байлгадаг. Олон улсын шилдэг туршлага солилцох, техникийн туслалцаа үзүүлэх зорилгоор хэд хэдэн улс орон болон төрийн хоорондын байгууллагуудтай ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, хамтран ажилладаг байна. 2011 оноос 2024 оны зургаадугаар сар хүртэл 141 орны 2819 олон улсын суралцагч IIIDEM-д сонгуулийн менежментийн сургалтад хамрагдсан байна.

Энэтхэг улсын туршлагаас үзэхэд сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, сонгуулийн байгууллагын ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх гэсэн хосолмол хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг нь манай улсын хувьд ижил төстэй юм. Үйл ажиллагаа нь өргөн хүрээнд явдаг учраас орон нутагт мэдээлэл түгээх, сургалт зохион байгуулах төвийг байгуулан ажиллуулдаг байна.

III. МОНГОЛ УЛСЫН ХУВЬД:

Монгол Улсын Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д зааснаар Сонгуулийн ерөнхий хороо нь ард нийтийн санал асуулгын болон сонгуулийн хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, энэ талаар сургалт, судалгаа явуулах болон сонгуулийн явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульчилсан.

Сонгогчдод тэр дундаа залуу сонгогчдод сонгуулийн боловсрол олгох, сонгуулийн үйл явцын талаарх үнэн зөв мэдээлэл олгох үйл ажиллагааг тогтмол, өргөн хүрээнд явуулах шаардлагатай байдаг. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т зааснаар Хороо өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд туслах Тамгын газартай байх бөгөөд түүний бүтэц, ажиллах журмыг Хороо батална гэж хуульчилсны дагуу Сонгуулийн ерөнхий хороо 2022 онд Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийг 12 орон тоотой ажиллахаар байгуулсан.

Тус төв нь хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд сонгогчдод сонгуулийн боловсрол олгох үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлсээр ирсэн боловч, байгууллагын төсвийн болон хүний нөөцөөс хамаарч ээлжит, ээлжит бус болон нөхөн сонгуулийн жилд харилцан адилгүй өрнөдөг. Сонгогчдод сонгуулийн хууль тогтоомж, сонгуулийн

мөн чанарыг таниулах, сонгуулийн боловсрол олгох үйл ажиллагааг тасралтгүй, өргөн хүрээнд, цогц байдлаар хүргэхэд төсвөөс хамаарсан хүндрэл үүсдэг. Иймээс гадаадын улс орнууд болон олон улсын байгууллагуудтай хамтран сонгогчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирлээ. Тухайлбал БНСУ-ын КОЙКА-н санхүүжилтээр НҮБ-тай хамтран хэрэгжүүлсэн "Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь" төслийн хүрээнд "Хариуцлагатай сонгогч" сургалтын хөтөлбөрийг 2021-2023 онуудад хэрэгжүүлэн 21 аймаг 9 дүүрэгт ерөнхий боловсролын сургуулийн 3000 гаран сурагчдад сонгуулийн боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн хүрээнд 100 гаран сургагч багш нарыг сонгуулийн сургагч багшаар бэлтгэсэн. Сургалтад хамрагдсан сурагчид сонгууль, сонгууль зохион байгуулалтын талаар маш их зүйл сурч мэдсэнээ илэрхийлж байсан. Төсөл хэрэгжиж дууссан санхүүжилт байхгүй болсон, улсын төсөвт зардал суугаагүйн улмаар хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна.

Олон улсын жишигтэй харьцуулахад сургалт, судалгааг төвлөрүүлсэн бие даасан байгууллагын түвшинд хэрэгжүүлэх тогтолцоо хараахан бүрдээгүй, судалгааны үр дүнг бодлого хууль тогтоомжийн шинэчлэлтэй уялдуулах боломж хязгаарлагдмал байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд дэлхийн улс орнуудын сонгуулийн байгууллага, ардчилалд дэмжлэг үзүүлэх олон улсын байгууллагуудтай Сонгуулийн ерөнхий хороо шууд харилцах эрх хэмжээтэй байдаг.

Эдгээр байгууллагууд нь сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллагатай шууд харилцахаас илүүтэй сонгуулийн боловсрол, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нэгжтэй харилцан туршлага солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх сонирхолтой байдаг.

IV. САНАЛ ДҮГНЭЛТ:

Дэлхийн улс орнуудын сонгуулийн удирдлагын байгууллагууд нь сонгогчдод сонгуулийн боловсрол олгох чиг үүргийг хэрэгжүүлэхдээ өөрийн байгууллагын дэргэдэх бие даасан нэгжээр дамжуулан зохион байгуулдаг байна. Энэхүү бие даасан байгууллагууд нь тухайн орныхоо хууль тогтоомжийн хүрээнд Сонгуулийн төв байгууллагын дэргэдэх статустайгаар байгуулагдсан байдаг. Ялангуяа БНСУ, БНЭУ-н сонгогчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр байгуулагдсан байгууллагууд нь сургалт, болон мэдээлэл өгөх үйл ажиллагааг өөрийн улс орондоо хэрэгжүүлэхээс гадна, гадаад улс орны байгууллагуудтай хамтран ажиллаж, харилцан туршлагаа солилцож байна.

Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээлэл, судалгаа, сургалтын төв нь бие даасан бүтцийн нэгжийн статустайгаар үйл ажиллагаа явуулах нь Монгол Улсын Үндсэн хуульд заагдсан иргэний эрхийг хангах, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ

хэрэгжүүлэхэд институцийн баталгаа болох юм. Ингэснээр сонгогчид, ялангуяа залуу үеийнхэнд ардчилал, сонгуулийн талаарх ойлголт, идэвхийг нэмэгдүүлэх, сонгуулийн ажилтнуудын ур чадварыг тогтмол дээшлүүлэх, олон улсын туршлага нэвтрүүлэх, бодлогын зөвлөмж гаргах, Олон улсын байгууллага, иргэний нийгэмтэй хамтран төсөв, нөөцийн хязгаарлалтыг даван туулах хэрэгцээ, шаардлагыг

хангана гэж үзэж байна.

Олон улсын туршлагыг нутагшуулан Монгол Улсад институцийн түвшинд хөгжүүлэх нь нэн чухал зорилт болж байна.

—оОо—

УЛС ОРНУУДЫН СОНГУУЛИЙН СУРГАЛТ, БОЛОВСРОЛ, СУДАЛГААНЫ ТӨВҮҮДИЙН ХУРААНГУЙ МЭДЭЭЛЭЛ

Хавсралт 1

№	Улсын нэр	Төвийн нэр (линк)	Институцийн харьяалал	Эрх зүйн байдал	Үндсэн чиглэл	Зорилтот бүлэг	Давуу тал	Үйл ажиллагааны төрөл
1	Австрали	National Electoral Education Centre	Australian Electoral Commission	Төрийн байгууллага	Иргэний боловсрол, сонгуулийн ойлголт	Сурагч, залуучууд	Практик дадлага	Иргэдэд
2	Энэтхэг	IIIDEM	Election Commission of India	Төрийн байгууллага	Мэргэжлийн сургалт, судалгаа	Сонгуулийн ажилтнууд, олон улсын	Олон улсын хамтын ажиллагаа	Хосолмол
3	БНСУ	Korean Civic Education Institute for Democracy	National Election Commission	Төрийн байгууллага (бие даасан)	Иргэний боловсрол	Иргэд, сурагчид, иргэний нийгэм	Иргэний ухамсар нэмэгдүүлдэг	Иргэдэд
4	Гүрж	Centre for Electoral Systems Development	Central Election Commission	Тусдаа нэгж	Судалгаа, шинэчлэл, сургалт	Сонгуулийн ажилтнууд, ИНБ, залуучууд	Бодлогын нөлөө	Судалгаа+ захиргаа
5	Замби	Voter Education Resource Centre	Electoral Commission of Zambia	Төрийн байгууллага	Иргэний боловсрол	Иргэд, сурагчид	Иргэдэд ойр	Иргэдэд
6	Бангладеш	Electoral Training Institute	Election Commission of Bangladesh	Төрийн байгууллага	Захиргааны сургалт	Сонгуулийн ажилтнууд	Захиргааны чадвар сайжирна	Захиргаанд
7	Колумб	Center for Studies in Democracy and Electoral Affairs	National Registry	Төрийн байгууллага	Судалгаа, ардчилал	Судлаачид, ажилтнууд	Судалгааны гүнзгий байдал	Судалгаанд
8	Коста Рика	Institute for Training and Studies in Democracy	Supreme Electoral Tribunal	Төрийн байгууллага	Иргэний боловсрол	Иргэд	Итгэл, оролцоо	Иргэдэд
9	Доминиканы БНУ	National School of Electoral and Civil State Training	Central Electoral Commission	Төрийн байгууллага	Иргэний ба бүртгэл	Захиргааны ажилтнууд	Захиргааны чадвар	Хосолмол
10	Эквадор	Institute of Democracy	National Electoral Council	Төрийн байгууллага	Иргэний боловсрол, судалгаа	Иргэд	Ардчиллын ойлголт	Иргэдэд
11	Фижи	Fijian Electoral Education Centre	Fijian Electoral Office	Төрийн байгууллага	Иргэний боловсрол	Иргэд	Хүртээмж	Иргэдэд

№	Улсын нэр	Төвийн нэр (линк)	Институцийн харьяалал	Эрх зүйн байдал	Үндсэн чиглэл	Зорилтот бүлэг	Давуу тал	Үйл ажиллагааны төрөл
12	Гана	Training School	Electoral Commission of Ghana	Төрийн байгууллага	Захиргааны сургалт	Сонгуулийн ажилтнууд	Ур чадвар сайжирна	Захиргаанд
13	Гватемал	Electoral Institute	Supreme Electoral Tribunal	Төрийн байгууллага	Иргэний оролцоо	Иргэд	Оролцоо нэмэгдсэн	Иргэдэд
14	Хонг Конг	Electoral Information Centre	Registration & Electoral Office	Төрийн байгууллага	Иргэний мэдээлэл	Иргэд	Мэдлэг сайжирна	Иргэдэд
15	Ирак	Institute of Electoral Education	Independent High Electoral Commission	Төрийн байгууллага	Захиргааны сургалт	Ажилтнууд	Итгэл нэмэгдсэн	Захиргаанд
16	Йордан	Jordan Electoral Training and Research Institute	Independent Electoral Commission	Бие даасан нэгж	Судалгаа + сургалт	Ажилтнууд	Орчин үеийн арга	Хосолмол
17	Киргизстан	Center for Training and Electoral Technologies	Central Election Commission	Төрийн байгууллага	Технологи	Ажилтнууд	Техникийн чадвар	Захиргаанд
18	Малайз	Election Academy	Election Commission of Malaysia	Төрийн байгууллага	Захиргааны сургалт	Ажилтнууд	Захиргааны ур чадвар	Захиргаанд
19	Мексик	School for Electoral Judicial Training	Electoral Tribunal	Төрийн байгууллага	Эрх зүй, шүүх	Шүүгчид	Маргаан шийдвэрлэх	Захиргаанд
20	Мексик	International Centre for Election Training & Research	National Electoral Institute	Төрийн байгууллага	Судалгаа + сургалт	Сонгуулийн ажилтнууд	Бүс нутагт тэргүүлэх	Хосолмол
21	Молдав	Center for Continuous Electoral Training	Central Election Commission	Төрийн байгууллага	Захиргааны сургалт	Ажилтнууд	Мэргэжлийн өсөлт	Захиргаанд
22	Балба	Electoral Education and Training Centre	Nepal Election Commission	Төрийн байгууллага	Иргэний боловсрол	Иргэд	Хүртээмж	Иргэдэд
23	Нигери	The Electoral Institute	Independent National Electoral Commission	Бие даасан	Олон улсын туршлага солилцох сургалт	Сонгуулийн ажилтнууд	Олон улсын хамтын ажиллагаа	Захиргаанд
24	Пакистан	Federal Election Academy	Election Commission of Pakistan	Төрийн байгууллага	Захиргааны сургалт	Ажилтнууд	Мэргэшлийн шинэ шат	Захиргаанд
25	Панам	Institute for Democratic Studies	Electoral Court	Төрийн байгууллага	Судалгаа	Иргэд	Ардчиллын ойлголт	Иргэдэд
26	Парагвай	Center for Information, Documentation & Electoral Education	Supreme Electoral Tribunal	Төрийн байгууллага	Иргэний боловсрол	Иргэд	Мэдлэг сайжирна	Иргэдэд
27	Перу	Electoral and Governance School	National Jury of Elections	Төрийн байгууллага	Иргэний боловсрол	Иргэд	Итгэл нэмэгдсэн	Хосолмол

№	Улсын нэр	Төвийн нэр (линк)	Институцийн харьяалал	Эрх зүйн байдал	Үндсэн чиглэл	Зорилтот бүлэг	Давуу тал	Үйл ажиллагааны төрөл
28	Перу	Registration School	National Registry	Төрийн байгууллага	Бүртгэл	Бүртгэлийн ажилтнууд	Уялдаа сайжирсан	Захиргаанд
29	ОХУ	Electoral Technologies Training Centre	Central Election Commission	Төрийн байгууллага	Технологи	Ажилтнууд	Техникийн чадвар	Захиргаанд
30	Тайланд	Democratic Education Center	Election Commission of Thailand	Төрийн байгууллага	Иргэний боловсрол	Иргэд	Оролцоо нэмэгдсэн	Иргэдэд

АВСТРАЛИ, ЭНЭТХЭГ, СОЛОНГОС УЛСУУДЫН СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭДЭХ СУРГАЛТ, СУДАЛГААНЫ БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

Хавсралт 2

	NEEC (Australia)	IIIDEM (India)	KOCEI (Солонгос)
Эрх зүйн үндэс	Commonwealth Electoral Act 1918-ийн 7-р зүйлийн 1 дэх хэсгийн (с) заалт	Энэтхэгийн Үндсэн хуулийн 324-р зүйл, ECI-ийн тушаал	Election Commission Act, Article 15-2 – NEC-ийн харьяа ардчилсан иргэний боловсролын төв байгуулах эрх
Байгуулагдсан он	1993	2011	1996
Төрөл / чиглэл	Иргэд, ялангуяа залуу үеийнхэнд чиглэсэн сонгуулийн боловсролын төв	Сонгуулийн ажилтнуудын мэргэжлийн сургалт, судалгааны институт	Ардчилсан иргэний боловсролын төв
Үндсэн зорилго	Иргэдийг сонгуулийн мэдлэгтэй, идэвхтэй оролцогч болгох	Сонгуулийн ажилтнуудыг мэргэжлийн түвшинд сургах, судалгаа хийх	Иргэдэд ардчилсан иргэний боловсрол олгох, сонгуулийн мэдлэгийг нэмэгдүүлэх
Харьяа байгууллага	Австралийн Сонгуулийн Комисс (AEC)	Энэтхэгийн Сонгуулийн Комисс (ECI)	Үндэсний Сонгуулийн Комисс (NEC)
Хамрах хүрээ	Иргэд, сурагчид, залуус, боловсролын байгууллагууд	Сонгуулийн ажилтнууд, төрийн албан хаагчид, судлаачид	Сонгогчид, сонгуулийн ажилтнууд, улс төрийн оролцогчид
Үйл ажиллагаа / арга	- Туршлагын төв (interactive) - Виртуал сонгуулийн туршлага - Сургалт, хөтөлбөр, семинар - Ардчилал, санал өгөх эрхийн мэдлэг	- Сургалт, семинар, дадлагын хөтөлбөр - Судалгаа, шилдэг туршлага - Олон улсын сургалт, зөвлөгөө - Сонгуулийн менежментийн чадавхийг хөгжүүлэх	Иргэдэд боловсрол олгох хөтөлбөр, судалгаа, сургалтын материал боловсруулах
Онцлог	Иргэдийн сонгуулийн боловсрол, ардчилсан ойлголтыг сурталчлах төв	Сонгуулийн ажилтнуудын мэргэжлийн чадавхижуулалт, судалгаа төв	Иргэний боловсрол, сонгогчдын идэвхижүүлэлтэд чиглэсэн төв

Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 34 жилийн ой, "Үндсэн хуулийн өдөр"-ийг тохиолдуулан Монгол Улсын төр нийгмийн зүтгэлтэн, Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит "Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал: Ардчилсан сонгууль" сэдэвт 17 дахь удаагийн шилдэг илтгэлийн уралдааны Оюутны ангилалд хоёрдугаар байрт шалгарсан илтгэлийг хүргэж байна.

НАМЫН ЖАГСААЛТ БҮХИЙ СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНД УЛС ТӨРИЙН НАМЫН ДОТООД АРДЧИЛАЛ

Ганхүүгийн ГАНБИЛЭГ /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан/



I. Оршил

II. Монгол Улсын сонгуулийн систем

III. Улс төрийн нам нь ард түмнээс тусдаа байгууллага биш болох нь

IV. Дотоод ардчиллыг заавал дагаж мөрдөх хэм хэмжээ болгоход хязгаарлалттай байдагт хариулт өгөх нь

V. Дотоод ардчиллын тухай дотоодод болон бусад улсад хэрхэн тодорхойлсон байдаг тухай

VI. Дүгнэлт, санал

ТОВЧ УТГА

Монгол Улс намын жагсаалт бүхий сонгуулийн системийг хэрэглэж буйн хувьд намын дотоод ардчилал анхаарал татсан асуудал байна. Дотоод ардчилал намд төлөвшсөн эсэхээс хамаарах үр дагавар тогтолцооны хэмжээнд яригдах боломжтой. Иймд уг ойлголтыг тодорхой судалж, хэрхэн зохицуулах тухай зохист шийдлийг эрэлхийлэх чухал. Энэ илтгэлээр намын жагсаалт бүхий

сонгуулийн системийн хүрээнд намын дотоод ардчиллын тухай авч үзэх ба заавал мөрдөх хэм хэмжээ болгох шаардлагатай юу гэдэгт хариулт өгөхийг зорьсон.

Илтгэл дараах бүтэцтэй байна. Хоёрдугаар хэсгээс эхлэн Монгол Улсад сонгуулийн систем хэрхэн хөгжиж ирсэн, өдгөө хэрэглэж буй системийн тухай, мөн сонгууль яагаад намын дотоод ардчилалтай холбогддог болохыг тайлбарлана. Үргэлжлүүлэн дотоод ардчилалтай байна гэдэгт юуг ойлгох, нам доторх босоо болон хөндлөн хяналт, намын дотоод ардчилал төрийн тогтвортой байдалд нөлөөлөх талаар авч үзэв. Мөн намын шинэчлэлийн асуудлыг дотоод ардчиллыг хэрхэн төлөвшүүлэхтэй холбож хөндсөн. Гуравдугаарт, улс төрийн нам нь ард түмнээс тусдаа байгууллага биш болохыг тайлбарлана. Илтгэлээр дэвшүүлсэн асуултын хариулт, ард түмэн ба нам мөн чанарын хувьд хэрхэн холбогддогтой салшгүй хамааралтай байна. Энэ хэсэгт ард түмэн ба нам, нам ба ардчилал, эдгээрийн хоорондын уялдааг харуулж, ардчилсан улс төрийн дэглэм бүхий тогтолцоонд намын гүйцэтгэх үүргийн талаар авч үзсэн. Дөрөв дэх хэсэгт дотоод ардчиллын хяналт, зөвтгөх үндэслэлүүдэд анхаарал хандуулна. Тавдугаарт, Монгол Улсад намын дотоод ардчилалтай холбоотой тогтсон зохицуулалтууд болон бусад улсад хэрхэн тусгагдсан байдгийг авч үзэх ба харьцуулж дүгнэнэ. Энэ хэсгээр заавал дагаж мөрдөх хэм хэмжээ болгох нь намын дотоод ардчиллыг сайжруулах хамаарал байдаг эсэхэд хариулт өгөхийг зорьсон. Мөн ойлголтыг нэг мөр болгох үүднээс намын дотоод болон гадаад ардчиллын тухай дурдсан болно.

I. ОРШИЛ

Улс төрийн намын дотоод ардчилал¹ (Дотоод ардчилал) нийгэмд маргаантай асуудлын нэг. Дотоод ардчилал төлөвшсөн эсэхээс шалтгаалах үр дагавар нийгэм төрийн байгууллын түвшинд яригдах боломжтой юм. Энэ илтгэлээр

Дотоод ардчиллыг заавал дагаж мөрдөх хэм хэмжээ болгох шаардлагатай юу гэдэгт хариулт өгч Дотоод ардчилалтай холбоотой анхаарах зүйлүүдийг илтгэлийн агуулгад багтаан гаргаж ирнэ. Цогц байдлаар дүн шинжилгээ хийх үүднээс онол, дотоодын болон бусад улсын хууль тогтоомж, эрдэм шинжилгээний эх сурвалжийг ашиглаж, байх ёстой зүйлийн хүрээнд сэдвийг авч үзсэн. Өмнө нь хийгдсэн ажлуудад нэр дэвшүүлэх үйл явц, Дотоод ардчиллын шалгуур үзүүлэлтүүдэд анхаарал хандуулсан бол тус илтгэлээр Дотоод ардчиллыг заавал мөрдөх хэм хэмжээ болгох уу

¹ Намын дотоод ардчилал буюу "internal democracy within political party", нам доторх ардчилал буюу "intra-party democracy" хэмээх ойлголт нь намын шийдвэр гаргах бүхий л түвшинд гишүүд, дэмжигчдийг оролцуулах тухай өргөн хүрээний ойлголт юм (Дефакто институт, 2020).

гэдэгт хариулт өгч энэ цаг үед анхаарах зүйлүүд юу байгааг гаргаж ирэхийг зорьсноор онцлог.

Дотоод ардчиллыг намын жагсаалт бүхий сонгуулийн тогтолцооны хүрээнд авч үзэх ба дараах бүтэцтэй байна: (1) Монгол Улсын сонгуулийн систем – Дотоод ардчилал сонгуулийн системд яагаад чухал болох; (2) Улс төрийн нам нь ард түмнээс тусдаа байгууллага биш болох нь – Дотоод ардчиллыг чухалчлан авч үзэх шаардлага; (3) Дотоод ардчиллын хяналт, зөвтгөх үндэслэл; (4) Дотоод ардчиллыг Монгол Улсад төдийгүй бусад улсад хэрхэн зохицуулдаг тухай – хуульчлан тогтоосноор Дотоод ардчилал сайжирдаг эсэх.

II. МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН СИСТЕМ

Сонгууль гэдэг улс төр, сонгууль гэдэг ардчилал, ардчилал гэдэг ард түмний засаг, ард түмний засаг гэдэг улсаа эзэгнэн захирах ёс.² Үүнийг улс төрийн хариуцлага тооцох үндсэн механизм ч гэж үзэх нь бий.³

Ардчилсан зарчим нь ард түмэн⁴ төлөөллийн байгууллагаараа дамжуулж улсыг удирдах үйл хэрэгт шууд оролцох хэлбэр хэмээн ойлгох нь түгээмэл. Гэвч энэ нь үндсэн хуульт ёс тогтсон улсад нийгмийн аль ч бүлэг дотор биелэгдэх, өргөн хүрээнд авч үзэх ойлголт юм. Ялангуяа засаг төрийн эрх мэдлийн төлөөх өрсөлдөөний тогтолцооны нэг хэсэг болох сонгуулийн системд сонгууль эхлэхээс эцэслэх хүртэл шат дараалал бүрд хэрэгжих нь зүйн хэрэг. Сонгуулийн ямар системийг сонгосноос хамаарч сонгогчид улс төрийн намд саналаа өгөх, эсвэл нэр дэвшигчид саналаа өгөх, сонгогчдын саналыг ямар аргачлалаар парламентын суудалд хуваарилах, сонгуулийн тойргийг хэрхэн тогтоох, тойрог бүрээс хэдэн төлөөлөгч сонгох гээд олон асуудал тодорхой болж ирдэг.⁵

Сонгуулийн тогтолцоо 1992 оноос хойш хэд хэдэн удаа өөрчлөгдсөн бөгөөд олонхын тогтолцоог 2012 он хүртэл ашиглаж ирсэн.⁶ 2011 онд анх хувь тэнцүүлэх системийг нэвтрүүлсэн ба өнөөдрийн байдлаар олонхын болон хувь тэнцүүлэх системийг хослуулсан буюу холимог тогтолцоог сонгоод байна. Хувь тэнцүүлэх системийг нэвтрүүлэх тухай ард түмний дунд багагүй хэлэлцүүлэг өрнөж, мөн шүүмжлэл дагуулж байв. Үндсэн хуулийн цэц хүртэл Үндсэн хуулиар тус системийг хүлээн зөвшөөрсөн эсэхэд ялгавартай шийдвэрүүдийг гаргаж байсан. Тухайлбал уг системийг Монгол Улсад туршиж үзсэн ч хувь тэнцүүлэх тогтолцоог Үндсэн хуулиар зөвшөөрөөгүй гэж үзээд холбогдох хуулийн

залалтыг хүчингүй болгосон байдаг.⁷ Судлаачид мөн байр сууриа илэрхийлж үндэслэл бүхий шүүмжлэл, зөвлөмжийг⁸ гаргаж байв. Эцэст нь хувь тэнцүүлэх систем өдгөө сонгуулийн хамгийн дэвшилтэт арга юм гэдэг дээр тогтож, тус системийг Үндсэн хуулийн түвшинд хүлээн зөвшөөрсөн.

Монгол Улсад хувь тэнцүүлэх систем дотроо намын жагсаалт бүхий хувь тэнцүүлэх системийг хэрэглэж байна. Олонхын системээр нэр дэвшигчийг, хувь тэнцүүлэх системээр намыг сонгодог. Энд нэр дэвшигч сонгогчийн хооронд “хоосон орон зай” үүсэх буюу жагсаалтын урдуур бичигдсэн бол баталгаатай сонгогдох магадлал өндөр болдог тул нэр дэвшигчдэд сонгогчдын дэмжлэг гэхээс илүү жагсаалтын хаана бичигдэх чухал байж болох юм. Энэ сул талыг Дотоод ардчилал нөхөх боломжтой гэж үзсэн учир хувь тэнцүүлэх системийг, тэр дундаа намын жагсаалт бүхий гэдгийг илтгэлээр онцолсон.

Хувь тэнцүүлэх систем нь улс төрийн намын жагсаалтуудаас сонгуулийн эрх бүхий иргэн сонголт хийх зарчмаар хэрэгждэг бөгөөд шууд сонгох эрхийг хангадаг гэдэгт нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг ба шударга ёсны зарчим хэрэгждэг гэж үздэг. Гэвч энэ нь сонгуулийн үйл явцын нэгээхэн хэсэг билээ. Жагсаалтыг намууд гаргаж өгдгийн хувьд тухайн үйл явцад ямар зарчим баримталж байна гэдэг чухал бөгөөд Дотоод ардчилалтай шууд холбогдоно. 2024 оны сонгуулиар намын гишүүдийг жагсаалтад оруулахад хуулиар шаарддаг шалгуур үзүүлэлтийг шалгуур болгосон, процессын хувьд шударга явагдсан эсэхэд олон нийт шүүмжлэлтэй хандаж байсан. Жагсаалтыг гаргахдаа ардчилсан зарчмыг дагаж мөрдөх эсэх нь сайн дурын шинжтэй бол намын удирдлага, цөөнхийн хүсэл сонирхол давамгайлсан нэр дэвшүүлэх үйл ажиллагаа явагдах нь нээлттэй болж ирэх юм. Улс төрийн нам Дотоод ардчилалгүй бол эрх мэдэл бүхий намын дарга, Ерөнхий сайд, Засгийн газраа өөрөө томилж чөлөөлдөг болж энэ их эрх мэдлийг дагасан бүлэглэл бий болно.⁹

Дотоод хариуцлагын тогтолцоотой байвал намыг Дотоод ардчилалтай байна гэж үздэг. Өөрөөр хэлбэл, гишүүд намын удирдлагын талаар мэдээлэлтэй бөгөөд огцруулах боломжтой байх юм. Удирдагчид нь гишүүддээ хариу өгч буй гэдгээрээ энэ нь босоо хэлбэрийн хариуцлага байна. Хариуцлагын тогтолцоо нь мөн хөндлөн хэлбэртэй байж болдог. Нам олон төвт байгууллага бөгөөд өөрийн хяналт тэнцлийн системтэй байна. Намын доторх өөр, өөр институтууд засгийн газрыг хянана. Удирдлагын хөндлөн ба босоо хяналт хоёул хангагдсан цагт намыг Дотоод ардчилалтай гэж үзнэ.¹⁰

2 Б.Чимид, *Сонгуульд суралцахуй: Тогтолцоо, үйл явц, эрх зүй* (УБ, 2008), 39.

3 Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа, сургалтын төв, “Сонгогчийн боловсрол, зан төлөвийн судалгаа,” *Сонгуулийн боловсрол: Онол, арга зүйн сэтгүүл* 13, № 4 (2025): 34.

4 “Ард түмэн” гэдэг нь Public буюу народ гэсэн англи, орос үгтэй дүйдэг, улсынхаа бүх харьяатыг бөөнтүүлэн тэмдэглэдэг хам нэр томьёо гэж Б.Чимидийн Сонгуульд суралцахуй номд тодорхойлсноор хэрэглэв.

5 Д.Гангабаатар, *Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал* (УБ, 2019), 206.

6 Ч.Энхбаатар нар., *Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ* (НҮБХХ, 2016), 136.

7 Д.Гангабаатар, *Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал*, 214.

8 О.Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хуулиар сонгуулийн холимог тогтолцоог хориглоогүй,” *Эрх зүй* 34, № 2 (2016).

9 Д.Хаянхярваа, “УИХ-ын ээлжит чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны тэмдэглэл,” 2019.11.13, 25, <https://www.parliament.mn/nn/9594/>.

10 José María Maravall, “The Political Consequences of Internal Party Democracy,” in *Controlling Governments: Voters, Institutions, and Accountability* (Cambridge University Press, 2007), 159.

Дотоод ардчилал улс төрийн намын хөгжил төлөвшилд нөлөөлдөг бөгөөд эл асуудлаа шийдвэрлээгүй нам гүйцэтгэх засаглалын түвшинд ажиллах, эвсэж юм уу хамтарч байгаа тохиолдолд төр тогтворгүй болох үндсэн шалтгаан болдог.¹¹ Дотоод ардчиллын хэрэгжилт сайн бол эрх барьж буй намаар дамжуулж засгийн газарт хяналт тавих боломжийг намын гишүүдэд олгодог байна. Улс төрийн намыг зөв төлөвшүүлснээр сонгуулийн үр дүнгээр засгийн эрх авсан намууд улс төр, нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, төрийн алба мэргэшсэн, чадварлаг, тогтвортой байх боломж бүрддэг.¹²

Улс төрийн нам бол ардчилсан институтүүдийн нэг, бие даасан систем бөгөөд аливаа улс орны хөгжил цэцэглэл, амар тайван, тогтвортой байдал улс төр, эдийн засгийн суурь институтууд хүртээмжтэй байхаас ихээхэн хамаардаг.¹³ Институтчилал гэдэг бүтэц, зохион байгуулалт, эсвэл үйл ажиллагааны хувьд тогтвортой болж, хүлээн зөвшөөрөгдөх үйл явц.¹⁴

Цаашид бид бүс нутагтаа ардчилал, хүний эрх, эрх чөлөөгөөрөө түүчээлэгч орон байх эсэх нь олон намын тогтолцоо төлөвшиж, бэхжихээс ихээхэн шалтгаалах юм. Нийтээрээ олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрсөн цагаас эхлээд бид намуудыг шинэчлэх, төлөвшүүлэх талаар хэлэлцэж ярилцсаар ирсэн.¹⁵

Шинэчлэл шаардлагатай гэдгийг мэддэг боловч юуг шинэчлэх вэ гэдгээ оновчтой тодорхойлж чадахгүй бол хаана хүрэхээ мэдэхгүй урагшлах тухай ярьж байна гэсэн үг юм. Монгол Улсад улс төрийн намын шинэчлэл хийх оролдлогууд хийгддэг ч дорвитой үр дүнд хүрээгүй. Өөрөөр хэлбэл, шинэчлэл бүрэн хийгдэж дуусаагүй, үйл явцад ахиц дэвшил гаралгүй өдий хүржээ. Намын шинэчлэл нь Дотоод ардчиллыг төлөвшүүлэх боломжийг нээх нэгэн хүчин зүйл байна.

III. УЛС ТӨРИЙН НАМ НЬ АРД ТҮМНЭЭС ТУСДАА БАЙГУУЛЛАГА БИШ БОЛОХ НЬ

Ард түмэн улсаа удирдах үйл хэрэгт оролцох арга хэлбэр нь намын зохион байгуулалт юм. Тиймээс нам бий болох үндэс нь төрийг удирдах үйл ажиллагаанд ард түмэн оролцох байна. Өөрөөр хэлбэл, засаг төрийн эх булаг нь Монголын ард түмний хүсэл зориг юм.¹⁶ Нам нь хэсэг бүлэг хүмүүсийн ашиг сонирхол төвлөрсөн, тэдгээрийн сонирхлыг гүйцэлдүүлэх зорилготой байгууллага биш гэдэг нь эндээс харагдана. Нэг хүний, эсвэл тодорхой компанийн нам байна

гэсэн шүүмжлэл иргэдийн дунд гардаг.¹⁷

Нам нь хуулийн этгээдийн¹⁸ нэг төрөл боловч арилжаа эрхлэгч шиг хувийн ашиг сонирхлын төлөө явдаггүй, төрийн эрх мэдэлд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагуудаас мөн ялгаатай бөгөөд ард түмэн засгаа удирдах боломжийг нээж өгдөг зохион байгуулалтын хэлбэр байна. Ардчилсан тогтолцоонд улс төрийн намууд нь иргэд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж улс төрийн хүсэл зориг, үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн эрх мэдэлд хүрэх, засаглалд оролцох гүүр болдог.¹⁹ Энэ утгаараа нам нь улс төрийн байгууллага байна.

Нам засаг төрийг бүхэлд нь булаан эзэлж, ажил үүргийг нь орлон хийж, бүрэн эрхийг төлөөлөн хэрэгжүүлдэггүй. Иргэд хэсэг бүлгээрээ улс, түүний нэгжийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагыг өөрсдөө байгуулж өөрсдийн төлөө ажиллуулахын тулд намд нэгдэн хамтын хүсэл зоригоо илэрхийлэн хууль ёсоор өрсөлддөг.²⁰

Ардчилалгүйгээр нам орших боломжтой юу, намгүйгээр ардчилал байх боломжтой юу гэдэг нь нам ба ард түмний хоорондын уялдааг тодорхойлоход зүй ёсоор тавигдах асуулт. Үүнд ардчилал, улс төрийн нам судлаач профессор Йигал Мерсель ийнхүү хариулжээ:

Эхний асуултын хувьд ардчилалгүйгээр нам оршин тогтнох боломжгүй гэдгийг түүх харуулдаг. Ардчилсан бус дэглэм нь эвлэлдэн нэгдэхийг хориглох хандлагатай байдаг ба улс төрийн чөлөөт нэгдэл бий болсноор ардчилал бүрэлдэн тогтох суурь тавигддагтай холбож тайлбарладаг. Улс төрийн намгүйгээр ардчилал хэрэгжих боломжтой юу гэдэгт түүхэн хариулт нь магадгүй "тийм". Бүх иргэд засаглалд оролцдог шууд ардчиллын хувьд улс төрийн намаас хамаарахгүй байж болох юм. ... Гэвч хувь этгээд засгийн газарт нөлөөлөх эсэх нь зохион байгуулалт бүхий бүлгийн хамтын үйл ажиллагаанаас хамаардаг.²¹

Монгол Улс хоёр том авторитар дэглэмтэй улсуудын голд ардчилсан дэглэмд амжилттай шилжиж чадсан нь онцгой тохиолдол бөгөөд энэхүү шилжилтийг амжилттай явуулахад улс төрийн намууд чухал үүрэг гүйцэтгэснийг монголын ардчиллын талаарх судалгаа шинжилгээнүүдэд онцолсоор ирсэн.²²

11 Г.Туяагэрэл, "Ил, тод, нээлттэй, хүн нэг бүр идэвх оролцоотой, мэргэшсэн байх зарчим намын түвшинд хангагдах ёстой," *Сонгуулийн боловсрол: Онол, арга зүйн сэтгүүл* 13, № 4 (2025): 13.

12 Н.Лувсанжав, Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар, *Үндсэн хуулиудад оруулсан нэмэлт, өөрчлөлт: Үйл явц, дүгнэлт, сургаж* (УБ, 2025), 131.

13 Дефакто институт, *Монголын намын системийн инстүүчлэл* (УБ, 2020), 7.

14 Мөн тэнд., 14.

15 Мөн тэнд., 7.

16 Б.Чимид, *Сонгуульд суралцахуй: Тогтолцоо, үйл явц, эрх зүй*, 40.

17 О.Мөнхсайхан, "УИХ-ын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл," 2019.06.14, 84, <https://www.parliament.mn/nn/7567/>.

18 Улс төрийн намын тухай хууль (2023)-ийн 6.7, 13.7.

19 Д.Энхцэцэг, "Намын дотоод ардчилал, нэр дэвшүүлэх процесс," *Бодлогын асуудал* 41 (2024): 1.

20 Б.Чимид, *Сонгуульд суралцахуй: Тогтолцоо, үйл явц, эрх зүй*, 118.

21 Yigal Mersel, "The Dissolution of Political Parties: The Problem of Internal Democracy," *International Journal of Constitutional Law* 4, no. 1 (2006): 88–89.

22 Дефакто институт, *Монголын намын системийн инстүүчлэл*, 8.

Ардчилсан дэглэм намыг бий болгох урьдач нөхцөл болдог учир нам нь ардчилсан зарчмыг дээдлэх учиртай ард түмнээс тусдаа бүтэц биш байна.

IV. ДОТООД АРДЧИЛЛЫГ ЗААВАЛ ДАГАЖ МӨРДӨХ ХЭМ ХЭМЖЭЭ БОЛГОХОД ХЯЗГААРЛАЛТАЙ БАЙДАГТ ХАРИУЛТ ӨГӨХ НЬ

Америкийн уламжлалт улс төрийн шинжлэх ухаанд ардчилал нь "түүхэн тохиолдол" гэх таамаглалд суурилдаг (нэг удирдагч, эсхүл бүлэг нийгмийг дагуулах чадваргүй).²³ Өөрөөр хэлбэл, албаар бус аяндаа бий болдог шинж чанартай гэж үздэг. Нам нь бий болгож буй системийнхээ нэг хэсэг тул ардчилсан удирдлагын системтэй байх нь гарцаагүй гэж энгийн ухамсрын түвшинд ойлгогдож болох ч Олигархын төмөр хууль үүнийг зэрэглээ төдий зүйл болгодог тул ардчилсан дэглэмтэй улсын урьтал нөхцөл Дотоод ардчилал байна.²⁴ Йигал Мерсель Дотоод ардчиллыг зөвтгөх үндэслэлийг ийнхүү тайлбарлажээ:

(1) Хэрэв хувь этгээд ардчилалд тэгш эрх, эрх чөлөө эдлэх эрхтэй бол тэднийг ардчилалд оролцох боломжийг олгож буй нэгдэлд мөн адил эрх эдэлнэ. Олон тооны гишүүн бүхий бүлгийг төлөөлдөг учир ардчилсан зарчим намын зайлшгүй шинж болно; (2) Ардчилалд ардчилсан бус улс төрийн намыг хүлээн зөвшөөрдөггүй гэдгээс ардчилалд Дотоод ардчилалгүй нам байх орон зай үгүй гэсэн дүгнэлт гарна; (3) Роберто Микельсийн тодорхойлсон Олигархын төмөр хуультай холбогдоно. Намын удирдлагын хэтэрсэн эрх мэдлээс болгоомжлох тухай ойлголт бөгөөд энэ нь аажимдаа гишүүдээ төдийгүй олон нийтийг дарангуйлахад хүргэдэг; (4) Улс төрд мэдэгдэхүйц нөлөөллийг хувь этгээд зөвхөн зохион байгуулалт бүхий хамтын үйл хөдлөлөөр үзүүлэх боломжтой учир орчин үед Дотоод ардчиллыг зайлшгүй шаардлага гэж үзнэ.²⁵

Эрх мэдэл төвлөрөл намаас үүсэлтэй гэдэг нь ардчилал аяндаа бий болдог гэх таамаглалын эсрэг тавигддаг. Энэ нь тодорхой хяналт шаардагдахыг нөгөөтээгүүр хэлж байна. Ардчилсан зарчимтай нам хэрхэн холбогддог болох, анх бий болсон үндэслэл зэргийг үзвэл Дотоод ардчилал нь заавал байх намын шалгуур үзүүлэлт ажээ.

Нэр дэвшүүлэх үйл явц ардчилсан зарчмын дагуу хэрэгжиж байна уу гэдэг нь эвлэлдэн нэгдэх эрхтэй холбогддог ч үндэслэл бүхий шалтгаан бий бол тохирсон

хэмжээнд буюу тэнцвэрийн зарчимд²⁶ нийцүүлэн үндсэн эрхийг хязгаарлаж болдог. Өөрөөр хэлбэл, үндэслэл бүхий шалтгаан байсаар байтал тохирсон арга хэмжээ авахгүй бол хэм хэмжээний зохист харьцаа алдагдана гэж үзнэ. Эвлэлдэн нэгдэх эрхийн тухай Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад "Хүн бүр бусадтай эвлэлдэн нэгдэх, түүний дотор өөрийн эрх ашгийг хамгаалах үүднээс үйлдвэрчний эвлэл байгуулах буюу түүнд элсэх эрхтэй. Энэ эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуульд зааснаас өөр хязгаарлалт хийж болохгүй"²⁷ гэж заасан. Эдгээр үндэслэл бий болсон нөхцөлд хуулийн дагуу хязгаарлаж болно гэдгийг тус заалт илэрхийлж байна.

Төрийн эрх мэдэл төвлөрөл, дур зоргоос сэргийлэх нь эрх зүй, хууль бий болох эх үндэс юм. Үүнд аюул учруулж болох аливаа үйл ажиллагаа, тогтолцоонд хяналт хэрэгжүүлэх нь системийн хувьд тэргүүн эгнээнд авч үзэх асуудал. Хэдийгээр Венецийн комиссоос гаргасан Улс төрийн намын тухай хууль тогтоомжийг боловсруулах удирдамжид тус хуульд намын дотоод асуудалд хэт гүнзгий оролцсон зохицуулалт байх нь зохимжгүй гэж заасан²⁸ ч лавшруулж үзэх хэрэгтэй юм. Сонгууль, улс төрийн үйл явцын зохион байгуулалт, менежментийг бусдаас хуулах биш, Монгол орны бүх талын нөхцөлд суурилуулан шинэчилж сайжруулах шаардлагатай.²⁹

Өнөөдрийн байдлаар тус асуудалд хяналт тавих субъект гэвэл төрийн үйл ажиллагаанд шийдвэрлэх гэж болох хяналт хэрэгжүүлдэг (онолын талаасаа ч) дөрөв дэх засаг буюу хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийг хэлж болно. Нам эвслээс нэр дэвших үйл явц зөвхөн нам, эвслийн асуудал биш, бас сонгогчдод маш их хамаатай тул сонгогчдод хандаж "нам эвслээс нэр дэвшүүлэх үйл явцыг сайтар анхаарч ажиглаж бай. Хэдийгээр нам, эвсэл нэр дэвшигчийг тодруулж байгаа энгийн үйл явц мэт боловч 'хар нүднээс хөмсөг далдуур' гэж хандаж болохгүй, харин 'нүдийг нь олох учиртай' амин чухал үйл явц" гэж хэлсэн байдаг.³⁰ Шинжээчдийн дунд хийсэн судалгааны үр дүнг харвал, таны бодлоор манайд олон түмний улс төрийн оролцоо ямар түвшинд байна вэ гэсэн асуултад төдийлөн хангалттай бус гэж 67.5% нь хариулсан бол хангалтгүй түвшинд гэж 20%, хангалттай түвшинд байна гэж 12.5% нь хариулжээ.³¹ Иргэдийн улс төрийн оролцоог сайжруулах шаардлагатай нь эндээс харагдаж байна.

Иргэний нийгмийн хяналт үр нөлөөтэй байхын тулд сонгогчдын сонгуулийн боловсрол өндөр түвшинд байхыг шаардана. Монгол Улсад сонгуулийн төв байгууллага

23 Geoffrey Wood and Pauline Dibben, "Broadening Internal Democracy with a Diverse Workforce: Challenges and Opportunities," in *Trade Unions and Democracy: Cosatu Workers' Political Attitudes in South Africa* (HSRC Press, 2006), 45.

24 Jan Teorell, "A Deliberative Defence of Intra-Party Democracy," *Party Politics* 5, no. 3 (1999): 363.

25 Mersel, "The Dissolution of Political Parties: The Problem of Internal Democracy," 96–98.

26 Үндсэн эрхэд тавих хязгаарлалт нь хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгод хүрэхэд тохирсон (зайлшгүй) байх (О.Мөнхсайхан, 2023).

27 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966)-ын 22.

28 Д.Энхцэцэг, "Намын дотоод ардчилал, нэр дэвшүүлэх процесс," 3.

29 Б.Чимид, *Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?!* (УБ, 2011), 55.

30 Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, *Бяраагийн Чимидийн уншлага: Сонгуульд суралцахуй* (МУҮХЦТГ, 2025), 104.

31 У.Батцэрэн, "Иргэдийн улс төрийн оролцоо ба түүнд нөлөөлж буй улс төрийн хүчин зүйлс," *Политологи* 15 (2017): 128.

холбогдох судалгааг хийж, боловсруулах чиг үүрэгтэй ажиллаж байна. Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа, сургалтын төвөөс сонгогчдын боловсрол, зан төлөвийн судалгаа хийхэд нийт судалгаанд хамрагдсан 11,700 иргэдээс дээд боловсролтой иргэд 70%, үүнээс 74% нь улс төрийн оролцооны ойлголт сайн гэсэн үр дүн гарчээ.³²

Олон намын тогтолцоотой улсад намууд Дотоод ардчиллыг аль сайн бүрэлдүүлж, сахиж байгаагаараа өрсөлдөж, нийт намуудын дунд Дотоод ардчилал сайжирна гэдэг нь онолын үндэстэй байж болох ч хувь тэнцүүлэх сонгуулийн систем хэрэглэдэг улсуудад ихэвчлэн хоёр нам улс төрд өндөр нөлөөтэй болж үлддэг. Мөн улс төрийн намын өнөөгийн хөгжлийн чиг хандлага картель³³ бүтэц рүү шилжиж буй талаар бичигдсэн судалгааны ажлууд цөөнгүй.³⁴ Тиймээс өрсөлдөөнд даатгах бус үр нөлөө бүхий хяналтын системийг бий болгох чухал.

Улс төрийн нам, эвслийн сонгуульд оролцох үйл ажиллагааг луйвар, дур зоргын хандлагаас цэвэрлэн хууль дээдлэх, ёс суртахууны өндөр түвшинд иргэний хатуу хяналттай, тэр дундаа шүүхийн хяналтад ажиллуулахыг³⁵ Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Бяраагийн Чимид сонгуулийг шударгажуулах цогц арга хэмжээнд багтаан дурдсан байдаг. Хянах байгууллагаар засгийн газар байх нь өрсөлдөгч намаас Дотоод ардчилал гэх нэрийдлээр давуу бус байдал үүсгэх, намын амжилтад нөлөөлөх эрсдэлтэй учраас хараат бус төвийг сахисан улс төрийн тоглогч байх зүйтэй гэж үздэг ба тэр нь ихэвчлэн шүүх байдаг.³⁶ ХБНГУ-ын Үндсэн хуульд улс төрийн нам үндсэн хуулийн бус үйл ажиллагаа явуулахтай холбоотой хяналтыг Холбооны Үндсэн хуулийн шүүх хэрэгжүүлнэ гэжээ.³⁷ Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас Улс төрийн намын тухай хуульд өгсөн санал зөвлөмжид улс төрийн намыг татан буулгах тухай СЕХ-ны шийдвэрээс үл хамааран Улсын дээд шүүх нь тус хуулийн зүйл заалт болон холбогдох нотлох баримтуудыг хянан шийдвэрлэх бүрэн эрхтэйг тус хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид тусгах гэсэн байна.³⁸

Дотоод ардчиллыг мөрдүүлэх гэдэг нь намын бүх дотоод асуудалд оролцох гэж ойлгогдож болох юм. Үр дүн нь нийгэм төрийн байгуулалд нөлөө үзүүлэхүйц үйл явцад, зарчмын хэрэгжилтийг хянах тухай ярьж байгааг дурдах нь зүйтэй. Тухайлбал намын жагсаалтыг гаргах үйл явц үүнд

хамаарна. Ямар төр байна вэ гэдэг төрийн албан хаагчдын үйл хөдлөлөөр дамжин илэрдэг. Тиймээс тэднийг сонгох, томилох үйл явц тодорхой шалгуур, зарчимд нийцсэн байхыг шаардана. Хуулиар зөвшөөрснөөс бусдыг хориглох үндсэн зарчим төрийн үйл ажиллагаанд үйлчилдэг учир холбогдох харилцааг хууль тогтоомжид тусгасан тохиолдолд хянах боломж бий болох юм.

V. ДОТООД АРДЧИЛЛЫН ТУХАЙ ДОТООДОД БОЛОН БУСАД УЛСАД ХЭРХЭН ТОДОРХОЙЛСОН БАЙДАГ ТУХАЙ

Энэ хэсэгт харьцуулах улсуудыг хувь тэнцүүлэх системийг хэрэглэдэг гэдгийг шалгуур болгож сонгосон ба Дотоод ардчиллын тухай зохицуулалтад, үйл ажиллагааг ардчилсан зарчимд нийцүүлэх ерөнхий заалт, тухайлсан үйл явцыг нийцүүлэх тусгайлсан заалтын аль алиныг багтаан үзсэн. Дотоод ардчиллын талаар дараах гол зохицуулалтууд тусгагдсан байх шаардлагатай бөгөөд үүнд Дотоод ардчиллын тухай, хяналт, хариуцлага зэрэг байна. Энэ хүрээнд холбогдох зохицуулалтуудыг авч үзье.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19¹ дүгээр зүйлийн 19^{1.3}-т "Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно" гэж заасан. "Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн..." гэж Дотоод ардчилалтай холбоотой суурь зохицуулалтыг тусгасан байна.

Улс төрийн намын тухай хуулийн 10.1.6, 19.4, 19.5, 33.2, 34.6, 34.6.9, 34.9, 37.6; Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4.1, 7.3, 29.10, 30.3, 30.5 гэх заалтууд Дотоод ардчилалд хамаарах тусгайлсан зохицуулалтууд байна. УТНТХ-д санхүүжилт, дотооддоо баримтлах, нэр дэвшүүлэх зарчим, нэр дэвшүүлэх тусдаа байгууллагатай байж болох, нэр дэвшигчид тавих шаардлага, хяналт зэргийг тусгажээ. Удирдах дээд байгууллага, төлөөллийн болон гүйцэтгэх төв байгууллагыг бүрдүүлэх үйл ажиллагааг ардчилсан зарчимд нийцүүлэх,³⁹ гишүүдийг ялгаварлан гадуурхахгүй байх нь Дотоод ардчилалтай холбоотой гол тодотгож өгсөн заалтууд байна.

МУИХСтХ-д сонгуулийн болон нэр дэвшүүлэхэд баримтлах зарчим, нэр дэвшүүлэх аргачлал зэргийг тусгасан. Тус хуулийн 30.5-д намаас нэр дэвшүүлэх асуудлыг төлөөллийн төв байгууллагаар хуралдаж, санал хурааж шийдвэрлэнэ гэжээ. Монгол дахь Дотоод ардчиллын хуулийн шалгуур нь гишүүдийн санал хураалтад гэхээсээ илүүтэй намын их хурал, чуулганд суурилсан гэдгийг харж болно.⁴⁰ 2005 оны Улс төрийн намын тухай хуулийн холбогдох зохицуулалтыг⁴¹ хэвээр үлдээсэн ба нэр дэвшүүлэх үйл явцыг ардчилсан

32 Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа, сургалтын төв, "Сонгогчийн боловсрол, зан төлөвийн судалгаа," 36.

33 Картель загварын намууд нийгэмд шинэ үзэл баримтлал, шинэ бодлого санал болгохыг урьтал болгодоггүй, түүгээр ч зогсохгүй сонгуулийн өрсөлдөөнт зах зээлийн идэвхтэй тоглогч байх явдалд төдийлөн ач холбогдол өгдөггүй (Д.Баасансүрэн, 2017).

34 Richard S. Katz and Peter Mair, "Changing Models of Party Organization and Party Democracy: The Emergence of the Cartel Party," *Party Politics* 1, no. 1 (1995); Д.Баасансүрэн, "Улс төрийн намын хөгжлийн өнөөгийн чиг хандлага," *Политологи* 15 (2017).

35 Б.Чимид, *Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?!*, 55.

36 Mersel, "The Dissolution of Political Parties: The Problem of Internal Democracy," 106.

37 ХБНГУ-ын Үндсэн хууль (1949)-ийн 21.

38 "Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас Улс төрийн намын тухай хуульд өгсөн санал, зөвлөмж," *Сонгуулийн боловсрол: Онол, арга зүйн сэтгүүл* 13, № 4 (2025): 33.

39 УТНТХ-ийн 8.2.

40 Дефакто институт, *Монголын улс төрийн намын дотоод ардчиллын индекс* (УБ, 2020), 6.

41 Улс төрийн намын тухай хууль (2005)-ийн 13.

зарчимд нийцүүлэх талаар гишүүдийн оролцоог хангах талаас авч хэлэлцэх шаардлагатай нь эндээс харагдана. Монгол Улсад төлөөллийн байгууллагаар дамжуулж намын гишүүд, нэр дэвшигчийг сонгохоор зохицуулсан байна. Гэтэл шууд сонгох нь сонгуулийн системийн суурь зарчим гэдгийг энд авч үзэх хэрэгтэй юм.

Сонгуулийн төв байгууллага санхүүгийн тайлангаар дамжуулан улс төрийн намын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт⁴² хэрэгжүүлж байна. Улс төрийн намыг бүртгэх⁴³ асуудал Улсын дээд шүүхийн бүрэн эрхэд хамаарна. Өөрөөр хэлбэл, нам үүсгэн байгуулагдах үйл явц шүүхийн хяналтад байна.

Хариуцлагын тухайд нэр дэвших эрх олгохдоо шан харамж өгөхийг шаардах, нам үүсгэн байгуулах, хяналтын байгууллагын хараат бус байдал, намын орлого нэг данстай байх, бэлэн мөнгөөр хандив авах, хуульд зааснаас хэтрүүлэн хандив авах, хуулийн этгээдийн нэртэй холбогдох заалтууд Зөрчлийн тухай хуульд тусгагдсан. Гэвч Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас УТНТХ-д өгсөн зөвлөмжид хяналт хариуцлагын тухайд хуульд заасан бүх зөрчилд оногдуулах шийтгэлийг тодорхой зааж, зөрчлийн төрөл тус бүрд оногдуулах шийтгэлийг нарийвчлан тусгаж, улс төрийн намын санхүүжилттэй холбоотой зөрчилд оногдуулах шийтгэлийг пропорциональ, тууштай хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх гэжээ.⁴⁴

Хэдийгээр үйл ажиллагаандаа ардчилсан зарчмыг баримтална гэж хуульд заасан ч бодит байдалд хэрэгжилт хангалтгүй байгааг харж болно. Намын удирдлагууд жагсаалтад оруулсны төлөө шан харамж авдаг, төрийн улс төрийн албан тушаалыг наймаалцаж байна гэх мэт шүүмжлэлүүд байдаг. Монголчууд сонгуулийн пропорциональ тогтолцоог намын нэрийн ард нуугдаж, суудал хуваарилах боломж хэмээн харсаар байна.⁴⁵ Дефакто институтээс Дотоод ардчиллыг оролцоо, өрсөлдөөн, ил тод байдал, санхүүжилт гэсэн дөрвөн гол үзүүлэлт тус бүрд тодорхой арга зүйн дагуу оноо өгөн дүгнэхэд улс төрийн намуудын авсан онооны хооронд зөрөө их гараагүй, Дотоод ардчиллын түвшин тун ойролцоо буюу хангалтгүй түвшинд байна гэсэн үр дүн гарсан.⁴⁶ Тус судалгааг Дотоод ардчиллын тухай заалт Үндсэн хуульд тусгагдаад удаагүй хийсэн бөгөөд өнөөдрийн түвшнийг үнэлж, үр дүнг харьцуулах шаардлагатай. Гэвч Дотоод ардчиллын тухай зохицуулалт анх удаа нэвтэрсэн биш бөгөөд 2005 оны Улс төрийн намын тухай хуульд тусгагдсан⁴⁷ байсан юм.

Улсууд намын тухай бие даасан хуультай байх нь янз бүр байна. Тухайлбал ХБНГУ намын дотоод үйл ажиллагаандаа баримтлах зарчмыг Үндсэн хуульдаа тусгаж өгсөн. Тодруулбал Германы Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлд улс

төрийн намын дотоод байгууллага нь ардчилсан зарчмыг мөрдөнө, үндсэн хуулийн бус үйл ажиллагаа явуулбал төрийн санхүүжилтийг зогсооно гэж заасан. Мөн Улс төрийн намын тухай тусгайлсан хуульдаа намыг татан буулгах зохицуулалт оруулсан байна.⁴⁸ Харин Японд Дотоод ардчиллыг Үндсэн хуульдаа тусгаагүй ч эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулсан.⁴⁹ Тусгайлсан хууль үгүй ч холбогдох хуулиудаараа намын харилцааг зохицуулдаг байна. Хувь тэнцүүлэх системийн классик жишээнд Бельги болон Финланд улс багтдаг.⁵⁰ Финланд нь Дотоод ардчилалтай холбоотой зохицуулалт оруулаагүй ч Улс төрийн намын тухай хуульдаа⁵¹ заасан. Бельгийн Үндсэн хуульд эвлэлдэн нэгдэх эрхийн тухай заажээ.⁵² Европт улс төрийн намын тухай хуулийн тал гаруй нь намын бүтэц Дотоод ардчилалтай байх, эсхүл дотоод шийдвэр гаргах үйл явцад намын гишүүдийн шууд оролцоог хангасан байх заалтыг оруулсан байна.⁵³

Хувь тэнцүүлэх сонгуулийн тогтолцоотой улсууд Дотоод ардчиллын тухай хуульчилсан байдал харилцан адилгүй байна. Намын тусгайлсан хуультай бөгөөд уг хууль болон үндсэн хуульдаа аль алинд нь Дотоод ардчиллын тухай тусгасан хэсэг байхад, зарим нь тусгайлсан хуульгүй, зөвхөн үндсэн хуульдаа заасан, зарим нь огт зохицуулалтгүй байна. Тэгэхээр сонгуульд нэр дэвшүүлэх процесс ардчилсан зарчмын дагуу, шударга ёсонд нийцсэн байдлаар явагдах нь улс төрийн соёлоос хамаарах боломжтой гэж нэг талаас дүгнэж болох юм. Мөн хуульчилж тогтоосноор Дотоод ардчилал сайжирдаг, эсрэгээр дорддог биш байх нь. Учир нь хувь тэнцүүлэх систем сонгодог утгаар хэрэгждэг зарим улсад Дотоод ардчиллыг заавал дагах шинжтэйгээр тогтоогоогүй байна. Улсууд үндсэн хуульдаа чөлөөт ардчиллын суурийг тавьсан байдаг учир улс төрийн намын тухай дурдахгүй байх хандлага байдаг бөгөөд үндсэн хууль улс төрийн намын хуулийн эх сурвалж болдоггүй тал бий.⁵⁴ Хуульчлан тогтоох эсэх нь олон онолын үзэл баримтлал, тухайн улсын онцлог, түүх, уламжлал, улс төрийн соёл, ухамсар гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаална. Ялангуяа ганц намд бүхэлдээ захирагдмал (намаар төрийг орлуулсан) улс төрийн нэгэн эшт төвлөрсөн тогтолцоо⁵⁵ бүхий цаг үеийг туулсан манай улсын хувьд анхааралтай авч үзэх асуудал юм.

Намын хувь чанар, бие даасан байдал, тоталитар дэглэм тогтохоос болгоомжилдогтой холбоотой Дотоод ардчиллыг хуульчлахын эсрэг хүчтэй аргуудтай байдаг.⁵⁶ Намын дотоод үйл ажиллагаанд хуулийн хязгаарлалт тавих нь ардчиллын суурь зарчим, тухайлбал эвлэлдэн нэгдэх

42 Сонгуулийн төв байгууллагын тухай хууль (2006)-ийн 7.3.10, 7.6.9, 13.1.1.

43 Монгол Улсын шүүхийн тухай хууль (2021)-ийн 25.8.8.

44 "Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас Улс төрийн намын тухай хуульд өгсөн санал, зөвлөмж," 33.

45 Л.Энхдэлгэр, "Намын жагсаалт 'бялуу' биш," 2016, <https://eagle.mn/r/6523>.

46 Дефакто институт, Монголын улс төрийн намын дотоод ардчиллын индекс, 24.

47 УТНТХ-ийн 5.1.4.

48 ХБНГУ-ын Улс төрийн намын тухай хууль (1967)-ийн 7-р бүлэг.

49 Японы Үндсэн хууль (1946)-ийн 21.

50 Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, 208.

51 Финландын Улс төрийн намын тухай хууль (1969)-ийн 2.1.3.

52 Бельгийн Үндсэн хууль (1831)-ийн 27.

53 Ingrid van Biezen and Daniela Romée Piccio, "Shaping Intra-Party Democracy: On the Legal Regulation of Internal Party Organizations," in *The Challenges of Intra-Party Democracy* (Oxford University Press, 2013), 40.

54 Ibid., 29.

55 Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг асуудал, хүний эрх, шүүх эрх мэдэл, нутгийн удирдлага (Чимид сан, 2017), 53.

56 Mersel, "The Dissolution of Political Parties: The Problem of Internal Democracy," 88.

эрхийг зөрчихөд хүргэдэг.⁵⁷ Гэвч зарим судлаачид Дотоод ардчиллыг үндсэн хууль талаас байх ёстой зүйлийн түвшинд тайлбарлах боломжтой гэж үздэг. Энэ талаар өмнөх хэсэгт авч үзсэн. Хэдийгээр Венецийн комисс улс төрийн намууд хөндлөнгийн хэт оролцоогүйгээр үйл ажиллагаа явуулах эрх чөлөөтэй гэдэг ч ардчилсан дэглэмд ажиллахын тулд зарим дүрэм, журам хэрэгтэй гэсэн санааг хэлдэг.⁵⁸

Засаг төрийн эрхийг авахын төлөө өрсөлддөг бөгөөд нийгэм төрийн байгуулалд өндөр нөлөө үзүүлдэг, улс төрийн байгууллага учраас тусгайлан зохицуулалтаар намын үйл ажиллагааг зохих хэмжээнд хянадаг. Нам нэг талаас иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөө, нам байгуулах Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрхийн асуудал, нөгөө талаас ардчилсан нийгэмд олон намын тогтолцоог хөгжүүлэх нь чухал төдийгүй намын Дотоод ардчилал, гишүүдийн оролцоо, нам хоорондын шударга өрсөлдөөний зарчмыг хангах үүднээс тодорхой зохицуулалтыг хийх шаардлага зүй ёсоор тавигддаг байна.⁵⁹ Улс төрийн намын нарийвчилсан хуультай улсууд үүний илрэл юм. Зохицуулалт оруулах эсэхийг шийдэхдээ одоогийн нөхцөл байдлаа үнэлэхээс эхэлнэ. Хуульчлан тогтоосон эсэхээс үл хамаарч тухайн улсад Дотоод ардчилал төлөвшсөн үү гэдэг асуулт нэгдүгээрт тавигдана. Дефакто институтээс намын Дотоод ардчиллыг тодорхой оноо өгөн дүгнэхэд хангалтгүй түвшинд байгааг дээр дурдсан.

Улс төрийн намын ардчиллыг гадаад болон дотоод гэж ангилж байна. Намын уриа, мөрийн хөтөлбөр, зорилго, үйл ажиллагаа зэргийг гадаад ардчилалд хамааруулж үздэг. Гадаад ардчилалтай холбоотой намыг татан буулгадаг жишиг бий. Тухайлбал Европын холбооны шүүхээр хэлэлцэгдсэн Туркийн засгийн газар намыг татан буулгах тухай зургаан шийдвэр, Испанийн дээд шүүх, терроризмыг дэмжсэн үйл ажиллагаа явуулсантай холбоотой намыг татан буулгасан тохиолдол, ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн 2002 оны шийдвэр бүгд гадаад ардчилалтай холбоотой шийдвэрүүд юм.⁶⁰ Зөвхөн гадаад ардчиллаар намын ардчиллыг тодорхойлж, Дотоод ардчиллын асуудлыг орхигдуулах хандлага зарим улсад ажиглагддаг байжээ.

VI. ДҮГНЭЛТ, САНАЛ

Ардчилал, намын зохион байгуулалт харилцан нэгнээ нөхцөлдүүлдэг учир Дотоод ардчилал улс төрийн намд заавал байх ёстой шинж байна. Заавал байх ёстой гэдэг нь заавал хуульчлан тогтоох ёстой гэсэн үг биш. Энэ нь Дотоод ардчиллын хэрэгжилтийг хангах нэг арга хэрэгсэл бөгөөд үүнээс гадна намын дотоод асуудалд үлдээх хандлага байдаг. Дотоод ардчилал аяндаа бий болох шинжтэй гэж орхигдуулж болдоггүй үндэслэлийг авч үзсэн. Гэвч

энэ талаар зохицуулалт оруулаагүй улсууд байна. Эхний хандлагаар тухайн улсад ардчилсан зарчим хэрэгждэг бол түүний доторх иргэдийн нэгдэлд мөн хэрэгжих, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хамгаалах гэсэн хоёр ерөнхий үзэл санааны тэнцвэрийг олсон байдлаар эрх зүйн хэм хэмжээний актад тусгах боломжтой ч энэ нь тухайн улсын онцлогоос хамаарах юм. Эцсийн дүнд шударга ёсны зохицлыг олсон байдлаар ардчилсан зарчмыг дотоод үйл ажиллагаандаа хэвшүүлэх сэдлийг бий болгох шийдлийг олох нь асуудлын гол юм.

Монгол Улсын хувьд заавал дагах шинжтэйгээр хуульчилсан. Хэрэгжилт хангалтгүй байгааг төрийн бус байгууллагын судалгаа, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн шүүмжлэл харуулдаг. Мөн хараат бус байгууллагаас хариуцлагыг хэрхэн тодорхойлох талаар сайжруулах орон зай байна гэж дүгнэсэн. Хуульчлан тогтоох гэдэгт хэрэгжилтийг хангахад чиглэх буюу хариуцлага, хяналтын механизмыг оролцуулж цогц байдлаар авч үзэхийг ойлгоно. Дотоод ардчиллыг заавал биелүүлэх хэм хэмжээ болгох, зөрчвөл хариуцлага тодорхой байх нь ардчилсан дэглэмийг хамгаалахад чухал ач холбогдолтой гэж үздэг.

Анхаарах асуудал нь Дотоод ардчиллыг сайжруулах хэрэгцээ шаардлага бөгөөд шийдлийн хувьд, өдгөө хэрэгжүүлэх боломжтой шийдэл, судалгааны үндсэн дээр өөрийн орны нөхцөл байдалд тохируулж зохицуулалт оруулах эсэх гэсэн хоёр хэсэгт авч үзэж болно. Энэ хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна: (1) Нийтлэг байдлаар хүлээн зөвшөөрөгдсөн, үр нөлөөг нь даруй сайжруулах

57 Biezen and Piccio, "Shaping Intra-Party Democracy: On the Legal Regulation of Internal Party Organizations," 28.

58 Ibid., 28–29.

59 Н.Энхцэцэг, "Монгол Улсад улс төрийн нам үүсгэн байгуулах, бүртгэх, өөрчлөх, хориглох, татан буулгах эрх зүйн зохицуулалт," *Эрх зүй, тусгай дугаар* (2023): 82.

60 Mersel, "The Dissolution of Political Parties: The Problem of Internal Democracy," 84–85.



боломжтой арга болох иргэний нийгмийн оролцоо буюу иргэдийн намаар дамжсан улс төрийн оролцоог сайжруулах; (2) Дотоод ардчилал, үүнд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох судалгааг тогтмолжуулах; (3) Хариуцлагын тухай заалт оновчтой тусгагдсан эсэх, нэр дэвшүүлэх үйл явцад гишүүдийн оролцоог хангах зохицуулалтын үр нөлөөтэй байдалд дүн шинжилгээ, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх; (4) Хяналтын байгууллагаар шүүх байх эсэх үндэслэлийг авч хэлэлцэх, ажиллах хүрээг тодорхойлох.

НОМ ЗҮЙ

Монгол эх сурвалж:

- Б.Чимид. Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?! УБ, 2011.
- . Сонгуульд суралцахуй: Тогтолцоо, үйл явц, эрх зүй. УБ, 2008.
- . Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг асуудал, хүний эрх, шүүх эрх мэдэл, нутгийн удирдлага. Чимид сан, 2017.
- Г.Туяагэрэл. "Ил, тод, нээлттэй, хүн нэг бүр идэвх оролцоотой, мэргэшсэн байх зарчим намын түвшинд хангагдах ёстой." Сонгуулийн боловсрол: Онол, арга зүйн сэтгүүл 13, № 4 (2025).
- Д.Баасансүрэн. "Улс төрийн намын хөгжлийн өнөөгийн чиг хандлага." Политологи 15 (2017).
- Д.Гангабаатар. Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал. УБ, 2019.
- Дефакто институт. Монголын намын системийн инстүүчлэл. УБ, 2020.
- . Монголын улс төрийн намын дотоод ардчиллын индекс. УБ, 2020.
- Д.Хаянхярваа. "УИХ-ын ээлжит чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны тэмдэглэл." 2019.11.13. <https://www.parliament.mn/nn/9594/>.
- Д.Энхцэцэг. "Намын дотоод ардчилал, нэр дэвшүүлэх процесс." Бодлогын асуудал 41 (2024).
- "Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас Улс төрийн намын тухай хуульд өгсөн санал, зөвлөмж." Сонгуулийн боловсрол: Онол, арга зүйн сэтгүүл 13, № 4 (2025).
- Л.Энхдэлгэр. "Намын жагсаалт 'бялуу' биш." 2016. <https://eagle.mn/r/6523>.
- Н.Лувсанжав, Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар. Үндсэн хуулиудад оруулсан нэмэлт, өөрчлөлт: Үйл явц, дүгнэлт, сургамж. УБ, 2025.
- Н.Энхцэцэг. "Монгол Улсад улс төрийн нам үүсгэн байгуулах, бүртгэх, өөрчлөх, хориглох, татан буулгах эрх зүйн зохицуулалт." Эрх зүй, тусгай дугаар (2023).
- О.Мөнхсайхан. "Монгол Улсын Үндсэн хуулиар сонгуулийн холимог тогтолцоог хориглоогүй." Эрх зүй 34, № 2 (2016).
- . Өгүүлэл, илтгэл, санал: Хүний эрх. УБ, 2023.
- . "УИХ-ын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл." 2019.06.14. <https://www.parliament.mn/nn/7567/>.
- Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа, сургалтын төв. "Сонгогчийн боловсрол, зан төлөвийн судалгаа." Сонгуулийн боловсрол: Онол, арга зүйн сэтгүүл 13, № 4 (2025).
- У.Батцэрэн. "Иргэдийн улс төрийн оролцоо ба түүнд нөлөөлж буй улс төрийн хүчин зүйлс." Политологи 15 (2017).

- Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн. Бяраагийн Чимидийн уншлага: Сонгуульд суралцахуй. МУУХЦТГ, 2025.
- Ч.Энхбаатар, Том Гинсбург, П.Амаржаргал, М.Батчимэг, Ц.Даваадулам, О.Мөнхсайхан, Д.Солонго. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. НҮБХХ, 2016.

Гадаад эх сурвалж:

- Biezen, Ingrid van, and Daniela Romée Piccio. "Shaping Intra-Party Democracy: On the Legal Regulation of Internal Party Organizations." *In The Challenges of Intra-Party Democracy*. Oxford University Press, 2013.
- Katz, Richard S., and Peter Mair. "Changing Models of Party Organization and Party Democracy: The Emergence of the Cartel Party." *Party Politics* 1, no. 1 (1995): 5–28.
- Maravall, José María. "The Political Consequences of Internal Party Democracy." In *Controlling Governments: Voters, Institutions, and Accountability*. Cambridge University Press, 2007.
- Mersel, Yigal. "The Dissolution of Political Parties: The Problem of Internal Democracy." *International Journal of Constitutional Law* 4, no. 1 (2006): 84–113.
- Teorell, Jan. "A Deliberative Defence of Intra-Party Democracy." *Party Politics* 5, no. 3 (1999): 363–82.
- Wood, Geoffrey, and Pauline Dibben. "Broadening Internal Democracy with a Diverse Workforce: Challenges and Opportunities." In *Trade Unions and Democracy: Cosatu Workers' Political Attitudes in South Africa*. HSRC Press, 2006.

Эрх зүйн эх сурвалж:

- Монгол Улсын Үндсэн хууль (1992)
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966)
- Зөрчлийн тухай хууль (2017)
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2019)
- Монгол Улсын шүүхийн тухай хууль (2021)
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль (2006)
- Улс төрийн намын тухай хууль (2023)
- Улс төрийн намын тухай хууль (2005)
- Бельгийн Үндсэн хууль (1831)
- Финландын Улс төрийн намын тухай хууль (1969)
- ХБНГУ-ын Үндсэн хууль (1949)
- ХБНГУ-ын Улс төрийн намын тухай хууль (1967)
- Японы Үндсэн хууль (1946)

МОНГОЛ
СУДАЛГААНЫ САН

НИЙСЛЭЛ, ОРОН НУТГИЙН НОМЫН САНГИЙН АЖИЛТНУУДЫГ СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАГЧ БАГШААР БЭЛТГЭНЭ

Сонгуулийн ерөнхий хороо Үндэсний номын сан, Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран Үндэсний номын санд Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит “Сонгуулийн боловсрол, эрх зүйн уншлагын танхим” ажиллуулж байгаа. Хамтын ажиллагааны хүрээнд 21 аймгийн номын санд сонгуулийн боловсрол олгох, сонгуулийн эрх зүйг хөгжүүлэх танхим, боловсон хүчинтэй болох зорилт тавин ажиллаж байгаа юм.

Аймаг, нийслэлийн номын сангуудад сонгуулийн боловсрол олгох мэдээ мэдээлэл, ном товхимол, гарын авлага, сэтгүүл байршуулахаас гадна үйлчлүүлэгч, залуу сонгогчдоос судалгаа авах, судалгааны дүнд үндэслэн сонгуулийн боловсрол олгох арга зүйгээ тодорхойлох зэрэг ач холбогдолтой.



СОЁЛЫН БОЛОВСРОЛ ХӨТӨЛБӨРТ СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТ ОРУУЛАХ БОЛОМЖТОЙ

Өвөрхангай аймгийн төв номын сангийн арга зүйч **Д.Отгонболор:**

Аймгийн нийтийн номын сан сонгуулийн боловсролын булан, танхимтай нээх нь маш зөв эхлэл. Номын сангийн соёлын боловсрол хөтөлбөрт сонгогчдод сонгуулийн боловсрол олгох сургалт оруулах боломжтой. Залуучууд гэр-ажил, ажил-гэр гэж явсаар сонгох, сонгогдох

эрхээ төдийлөн анхаарч чаддаггүй нь анзаарагддаг. Сонгуулийн ерөнхий хороо бусад байгууллагатай хамтраад нийгмийн олон салбар, зорилтот бүлэгт чиглүүлсэн хөтөлбөр, сургалт хэрэгжүүлбэл ардчилсан сонгуулийн үр нөлөө дээшилнэ гэж үзэж байна.



Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний номын сантай хамтран энэ оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Хүүхдийн номын сан, 21 аймгийн номын сангийн захирал, мэргэжилтнүүдийг чадавхжуулах, арга зүйгээр хангах сургалт зохион байгууллаа.

Орон нутаг дахь номын сангаар дамжуулж сонгогчдод сонгууль, улс төрийн боловсрол олгохоор зорьж байгааг номын сангийн захирал, мэргэжилтнүүд дэмжиж байгаагаа хэллээ. Тухайлбал, Дархан-Уул аймгийн төв номын сангийн захирал Л.Мөнхбаатар “Ээлжит болон нөхөн сонгуулийн үеэр орон нутагт сонгуулийн үйл явдлын мэдээ түгээдэг. Сонгогчдын сонгуулийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаа байнгын байж хариуцлагатай, хэрсүү сонгогчийг бэлтгэнэ. Тиймээс нийслэл, 21 аймгийн номын сангийн мэргэжилтнүүдийг сонгуулийн боловсрол олгох сургагч багшаар бэлтгэх шаардлагатай” гэдэг саналаа хэлснийг сургалтад оролцогчид дэмжиж буйгаа илэрхийлсэн.

Нийслэл, орон нутгийн номын сангийн ажилтнуудыг сонгуулийн боловсрол олгох сургагч багшаар бэлтгэхээр санал нэгдэж, сургалтыг 2026 оны тавдугаар сараас эхлэхээр боллоо.



ОРОН НУТАГТ БАЙНГА СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ОРОН ТООНЫ МЭРГЭЖИЛТЭН ХЭРЭГТЭЙ

Хөвсгөл аймгийн нийтийн номын сангийн эрхлэгч **Н.Дашдаваа**



Орон нутагт сонгогчдын боловсрол сонгуулийн цаг үеийн мэдээлэл, сурталчилгаагаар л хязгаарлагддаг. Орон нутагт байнга сонгуулийн боловсрол олгох орон тооны мэргэжилтэн хэрэгтэй санагддаг. Ядаж номын сангийн ажилтнуудыг сонгуулийн боловсрол олгох сургагч багшаар бэлтгээд номын санд сонгуулийн

боловсрол олгох сургалт, арга хэмжээ зохион байгуулбал үр дүнтэй. Ийм ажлын эхлэл тавигдсанд баяртай байна. Төгсөх ангийн сурагчдад зориулсан практик сургалт явуулаад туршилтын сонгууль зохион байгуулбал тэдний сонирхлыг татаад зогсохгүй сонгох, сонгогдох эрхээ эдлэх, боловсролтой болгох ач холбогдолтой.

УИХМН
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛ УЛСЫН БҮХ НОМЫН САНД “СОНГОГЧИЙН БУЛАН” АЖИЛЛУУЛНА

Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Үндэсний номын сангийн захирлын хамтарсан тушаалаар нийслэл, есөн дүүрэг, 21 аймаг болон бүх сумын номын санд “Сонгогчийн булан” ажиллуулах заавар батлагдлаа.

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА,
МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН
ЗАХИРЛЫН ХАМТАРСАН ЗАХИРАМЖ, ТУШААЛ

2022.6 оны 02 дугаар сарын 12

Дугаар А/09, 02/05

Улаанбаатар хот

Номын санд сонгогчийн булан ажиллуулах заавар
батлах тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 7.1.6 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, 9.2 дахь хэсэг, Номын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Монгол Улсын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны А/422 дугаар тушаалаар баталсан “Монгол Улсын Үндэсний номын сангийн дүрэм”-ийн 2.1.5, 2.1.7, 3.5.4, 3.5.6 дахь дэд заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАН ТУШААХ нь:

Уншигчдыг сонгуулийн талаарх үнэн, зөв, тэнцвэртэй мэдээллээр хангах, иргэдийн сонгуулийн боловсрол, эрх зүйн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор сонгогчийн булан байгуулах, бэлтгэх, ашиглах, шинэчлэхтэй холбоотой “Номын санд сонгогчийн булан ажиллуулах заавар”-ыг хавсралтаар баталсугай.

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ
ХОРООНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.ДАВАА-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
НОМЫН САНГИЙН ЗАХИРАЛ

Б.ИЧИНХОРЛОО

Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Монгол Улсын Үндэсний номын сангийн захирлын 2026 оны 8 дугаар сарын 12-ний өдрийн 8/05 дугаар хамтарсан захирамж, тушаалын хавсралт.

НОМЫН САНД СОНГОГЧИЙН БУЛАН АЖИЛЛУУЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү заавар нь номын санд Сонгогчийн буланг зохион байгуулах, бэлтгэх, ашиглах, шинэчлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Сонгогчийн булангийн зорилго нь аймаг, нийслэл, сум, дүүргийн уншигчдыг сонгуулийн талаарх үнэн зөв, тэнцвэртэй мэдээллээр хангах, иргэдийн сонгуулийн боловсрол, эрх зүйн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, сонгуульд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хоёр. Сонгогчийн булангийн байршил

- 2.1. Номын сангийн уншигчид чөлөөтэй нэвтрэх, харагдахуйц, гэрэл сайтай, саадгүй хэсэгт байрлуулна.
- 2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлыг хангана.

Гурав. Тоног төхөөрөмж, хэрэгсэл

- 3.1. Заавал байх:
 - 3.1.1. Номын тавиур, мэдээллийн самбар
 - 3.1.2. Ширээ, сандал
- 3.2. Нэмэлт:
 - 3.2.1. Компьютер
 - 3.2.2. Интернэт

Дөрөв. Байршуулах мэдээлэл

- 4.1. Сонгогчийн буланд дараах мэдээллийг байршуулна. Үүнд:
 - 4.1.1. Сонгуулийн хууль, холбогдох эрх зүйн баримт бичиг;
 - 4.1.2. Сонгогчийн эрх, үүргийн талаарх танилцуулга;
 - 4.1.3. Сонгуулийн байгууллагын албан ёсны танилцуулга;
 - 4.1.4. Сонгуулийн түүх, ач холбогдлын талаарх материал;
 - 4.1.5. Иргэний боловсролын ном, гарын авлага;
 - 4.1.6. Залуучууд, ахмад настанд зориулсан танилцуулга, мэдээлэл;
 - 4.1.7. "Сонгуулийн боловсрол" сэтгүүл;
 - 4.1.8. Санал авах байр, санал тоолох төхөөрөмж болон улс төрийн намын ил тод байдлын талаарх зурагт хуудас.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Тав. Үйл ажиллагаа

- 5.1. Байршуулсан материалын үнэн зөв, шинэчлэлтийг хариуцах ажилтан томилно.
- 5.2. Уншигчдад тэгш, саадгүй үйлчлэх зарчмыг баримтална.
- 5.3. Сонгогчийн буланд сар, улирал, тэмдэглэлт өдрөөр эсвэл нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан сэдэвчилсэн хэлбэрээр ном, хэвлэмэл материалыг сонгон байршуулна.
- 5.4. Сонгогчийн буланг улирал бүр шинэчилнэ.
- 5.5. Сонгогчийн буланг илүүдэл чимэглэлээс зайлсхийж, өнгөний зохицлыг хангасан энгийн, цэгцтэй байдлаар зохион байгуулна.
- 5.6. Уншигчдын санал, сэтгэгдлийг авч тогтмол сайжруулна.
- 5.7. Ном, самбар, тоноглол нь унах эрсдэлгүй, аюулгүй байдлыг хангасан байна.
- 5.8. Улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийг сурталчилсан, нэг талыг барьсан аливаа материал байрлуулахыг хатуу хориглоно.

Зургаа. Бусад

- 6.1. Сонгуулийн ерөнхий хороо нь өөрийн эрхлэн гаргадаг ном, товхимол, "Сонгогчийн боловсрол" сэтгүүлээр тогтмол хангана.
- 6.2. Монгол Улсын Үндэсний номын сан мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, зааврын хэрэгжилтэд номын сангийн удирдлага хяналт тавина.

---ooOoo---

“БАРИМТААР БАТАЛГААЖУУЛЪЯ” ТӨСЛИЙГ АРДЧИЛСАН ОРНУУДЫН ХАМТЫН НИЙГЭМЛЭГТЭЙ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛНЭ

Мэдээлэл, судалгаа, сургалтын
төвийн ахлах мэргэжилтэн
С.МЭРГЭН

Сонгуулийн ерөнхий хороо өнгөрсөн оноос “Баримтаар баталгаажуулъя” төсөл хэрэгжүүлж байгаа. Уг төслийн зорилго, ач холбогдлын талаар “Сонгуулийн боловсрол” онол, арга зүйн сэтгүүлийн өмнөх дугаарт мэдээлсэн.

“Баримтаар баталгаажуулъя” төслийг хэрэгжүүлэх, өргөжүүлэхэд шаардлагатай төсөв санхүүгийн дэмжлэг үзүүлэх хүсэлтэй олон улсын донор байгууллагатай Харилцан ойлголцол, хамтын ажиллагааны санамж бичгийг байгууллаа. Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Нарийн бичгийн дарга нарын газар (АОХН-ийн НБДНГ)-тай 2026 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан Харилцан ойлголцол хамтын ажиллагааны санамж бичиг нь байгууллага хооронд хамтын ажиллагааны шугамаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хүрээг тодорхойлоход оршино.

Уг хамтын ажиллагааг Баримтад тулгуурласан мэдээллийн хяналт сэдвийн хүрээнд сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулахад санхүү болон бусад боломжит дэмжлэг үзүүлэх, мөн цаашид Монгол Улсад ардчилсан сонгуулийг бэхжүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэхээр тодорхойлсон. Цаашид Санамж бичгийн хүрээнд авч хэрэгжүүлэх ажлын талаар Талууд цахим уулзалт зохион байгуулж, санал солилцох замаар төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажлын талаар хэлэлцэхээр төлөвлөсөн.

Цахим мэдээллийн эрин үед иргэн бүр мэдээллийн урсгалын идэвхтэй хэрэглэгч, түгээгч болж, олон нийтийн сүлжээгээр дамжин тархах мэдээлэл нь нийгмийн өдөр тутмын шийдвэр гаргалтад төдийгүй улс төр, сонгуулийн үйл явцад бодит нөлөө үзүүлэх болсон.





ЦУВРАЛ 6 Домэйн хаяг үнэн үү, хуурамч уу?

Домэйн хаяг гэж юу вэ? Интернет орчинд вебсайт руу хандах хялбаршуулсан, хүний ойлгоход зориулагдсан цахим хаяг юм.

✓ **Үсэг, элементүүдийн зөрүүг шалга**

Танил домэйн хаягийг дуурайлгасан, нэг үсэг, элемент зөрсөн сайт байж болзошгүй.

Жишээ: facebook.com, google.mn - зэрэг нь хуурамч байж болно.

✓ **Домэйн өргөтгөлд анхаар**

Үл мэдэгдэх өргөтгөлтэй (жишээ нь: .xyz, .top) сайтуудад болгоомжтой ханд.

.com, .mn, .org гэх мэт өөрт танил өргөтгөлүүдийг илүүд үз.

✓ **WHOIS мэдээлэл шалга**

Хэзээ бүртгүүлсэн, хэн эзэмшдэг, ямар хугацаатай вэ гэдгийг <https://who.is> <https://lookup.icann.org> зэрэг сайтаар шалгаж болно.

<http://iykvl.gmn> Хуурамч линк дээр дарахаасаа өмнө домэйн нэрийг сайтар нягтлаарай!

Б АРИМТААР АТАЛГААНЧУЛ

Fact checking!

Сүүлийн жилүүдэд цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоо өсөхийн зэрэгцээ хуурамч мэдээлэл, мэдээллийн манипуляци нь иргэдийн итгэл үнэмшил, нийгмийн тогтвортой байдал, улмаар сонгуулийн шударга байдалд сөргөөр нөлөөлөх бодит эрсдэлийг дагуулж байна. Цахим орчны хяналт, зохицуулалт харьцангуй хязгаарлагдмал, гадаад платформуор дамжин мэдээлэл тархдаг өнөөгийн нөхцөлд иргэд өөрсдөө мэдээллийн үнэн бодит байдлыг ялган таних чадвартай байх нь чухал ач холбогдолтой болжээ.

Энэ нөхцөл байдлаас үүдэн иргэдийн мэдээллийн боловсрол, мэдээлэлд хандах хариуцлагатай хандлагыг төлөвшүүлэх, аливаа мэдээллийг хүлээн авах, түгээхээсээ өмнө эх сурвалжийг нягтлан шалгах дадлыг хэвшүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна. “Баримтаар баталгаажуул” төсөл нь энэхүү хэрэгцээ шаардлагад тулгуурлан цахим орчин дахь хуурамч мэдээлэл, төөрөгдүүлсэн агуулгын эрсдэлийг бууруулах, иргэдийн мэдээллийн дархлааг бэхжүүлэхэд чиглэсэн цогц санаачилга юм.

Төслийн хүрээнд мэдээллийн эх сурвалжийг нягтлах арга зүй, худал мэдээллийг таних суурь ойлголт, цахим аюулгүй байдлын зөв дадлыг олон нийтэд түгээх замаар иргэдийг мэдээллийн эрүүл экосистемийн идэвхтэй, хариуцлагатай оролцогч болгохыг зорьж байна. Энэ нь зөвхөн мэдээлэл түгээх нэг удаагийн ажил бус, урт хугацаанд баримтад суурилсан сэтгэхүй, хариуцлагатай сонгогчийг төлөвшүүлэхэд чиглэж байна.



CLICKBAIT - төөрөгдүүлсэн гарчиг

Clickbait гэдэг нь хэт дэгсдүүлсэн, төөрөгдүүлсэн гарчиг бөгөөд таны анхаарлыг татах замаар бодит бус мэдээлэлд хөтөлдөг.

“Шуугиан тарьсан энэ мэдээг заавал уншаарай!”

Энэ гарчиг бол clickbait - таны анхаарлыг татах, төөрөгдүүлэх зорилготой.

Төөрөгдүүлсэн гарчигт битгий хууртаарай

ЗӨВЛӨМЖ

Нэвтэрч орохоосоо өмнө...

- Энэ гарчиг **хэт анхаарал татахуйц** байна уу?
- Эх сурвалж** нь найдвартай юу?
- Гарчиг ба агуулга** хоёр нийцэж байна уу? гэдгийг сайтар шалгаарай.

Б АРИМТААР АТАЛГААНЧУЛ

Fact checking!

МАНАС АДОМЕНАС

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООГ БАЙГУУЛЛАГЫН ХУВЬД ИТГЭЛТЭЙ, ӨНДӨР УР ЧАДВАРТАЙ, ХАРИУЦЛАГАТАЙ ТҮНШ ГЭЖ ҮЗДЭГ

Сонгуулийн ерөнхий хорооны санаачилсан “Баримтаар баталгаажуулъя” төслийг дэмжихээр Санамж бичиг байгуулсан Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Ерөнхий нарийн бичгийн дарга доктор Мантас Адоменастай ярилцлаа.

Захиргаа, удирдлагын газрын
референт Б.УЯНГА



Photo credit: Jurijus Azanovas

-Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос санаачилсан “Баримтаар баталгаажуул” төслийг Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг хэрхэн үнэлж, дэмжих шийдвэрт хэрхэн хүрсэн бэ?

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны санаачилгыг дэмжих гол шалтгаан нь ардчиллыг бэхжүүлэх бидний хамтын нэгдмэл хариуцлага байсан юм. Энэхүү төсөл нь өнөөгийн ардчилсан улс орнуудад тулгараад буй гол сорилт, бэрхшээлийн нэг болох сонгуулийн шударга байдал, иргэдийн итгэлд сөргөөр нөлөөлж буй худал ташаа мэдээ, мэдээллийг түгээх, иргэдийн дунд төөрөгдөл үүсгэх (манипуляц) асуудлыг шийдвэрлэхээр зорьж байна.

Тиймээс бид энэхүү санаачилгыг цаг үеэ олсон, ач холбогдолтой гэж үнэлж байгаа бөгөөд ялангуяа Монгол Улс Ардчилсан улс орнуудын нийгэмлэгийн (CoD) гишүүн улсын хувьд тодорхой үүрэг гүйцэтгэж байгааг зэргийг харгалзан үзсэн. Энэхүү төсөл ардчилсан улс орнууд хооронд практикт суурилсан хамтын ажиллагааг дэмжих бидний эрхэм зорилгод ч мөн нийцэж байгаа юм.

-Төслийг эхлүүлэхийн өмнөх шатанд ямар зарчим, чиглэлийг чухалчлан харж байна вэ?

Сонгуульд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа тухайлбал

мэдээллийн манипуляци хийх, сонгуульд хөндлөнгөөс нөлөөлөх зэргийг холбогдох бүх талуудыг оролцуулан цогц байдлаар нийгмээрээ хамтран шийдвэрлэх ёстой байдаг.

Үүний тулд Сонгуулийн төв байгууллага болон холбогдох бусад байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх нь тухайн улсын нөхцөл байдалтай бүрэн нийцэж зохицсон үйл ажиллагааг явуулахад илүү дөхөм байдаг. Өөр нэгэн чухал зарчмын нэг бол хүний нөөц, чадавхтай холбоотой асуудал байдаг. Энэхүү төслийн хүрээнд эхнээсээ зөвхөн төлөвлөсөн үйл ажиллагаагаа хэрэгжүүлээд зогсохгүй байгууллага болоод иргэдийн мэдлэг, мэдээлэл, ур чадварыг бий болгоход зорих нь зүйтэй бөгөөд ялангуяа худал мэдээлэлтэй тэмцэхэд энэ нь онцгой чухал ач холбогдолтой юм.

-Төслийг хэрэгжүүлэх явцад Сонгуулийн ерөнхий хороо ямар үүрэг, манлайлал үзүүлнэ гэж Ардчилсан орнуудын нийгэмлэгээс хүлээж байна вэ?

Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн зүгээс Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороог байгууллагын хувьд итгэлтэй, өндөр ур чадвартай, хариуцлагатай түнш гэж үздэг. Мөн цаашид төслийн туршид холбогдох талуудтай харилцах, мэргэжлийн өндөр стандартыг хангасан, ардчилсан, үнэн зөв байдлыг баримтлах замаар төслийн

удирдлагын үүргээ үргэлжлүүлэн хариуцлагатай гүйцэтгэнэ гэсэн хүлээлттэй байгаа.

-Уг төсөл нь баримтад суурилсан, үнэн зөв мэдээлэл түгээх соёлыг төлөвшүүлэхэд ямар суурь үндэс болно гэж та үзэж байна вэ?

-Энэхүү төсөл нь шүүмжлэлт сэтгэлгээг бий болгох, иргэдийн мэдээлэлтэй харьцах боловсролыг дээшлүүлэх соёлыг бүрдүүлэх үндэс суурийг тавих юм. Иргэд, албан хаагчдад мэдээллийн үнэн зөв байдлыг хэрхэн нягтлах, баталгаат эх сурвалжийг нь тодорхойлох, мэдээллийг баримтжуулах, худал мэдээллийг таних арга зэрэг мэдлэгийг өгснөөр ялангуяа сонгуулийн үед мэдээлэлтэй холбоотой шийдвэр гаргах чадварыг олгох юм. Гэвч эдгээр соёлыг төлөвшүүлэх нь нэг шөнийн дотор бий болгочих ажил биш боловч урт хугацаанд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн ачаар ардчилсан үйл явцад, байгууллагад итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлж, манипуляцид биш харин баримтад үндэслэсэн мэдээллийг ашигладаг хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэх, дэмжих боломжтой.

-Хуурамч мэдээлэл дэлхийн улс орнууд, ардчилсан засаглал, тогтолцоонд ямар эрсдэл, хор хөнөөл учруулж байна гэж Та үзэж байна вэ?

-Хуурамч мэдээлэл нь ардчилсан засаглалд маш хортой нөлөөтэй. Учир нь байгууллагад итгэх итгэлийг сулруулж, нийгмийг талцуулан хувааж, сонгуулийн үйл явцыг гажуудуулах, нийгмийн эв нэгдлийг сулруулах зэрэг маш ноцтой байдлыг үүсгэдэг. Урт хугацаандаа тэдгээр хяналтгүй хуурамч мэдээлэл нь ардчилсан тогтолцооны үндсийг сулруулж, нийгмийг гадны нөлөөнд илүү эмзэг болгоход хүргэдэг.

Тиймээс сонгуулийн өмнө мэдээллийн манипуляцитай тэмцэхэд чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ болох иргэдийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэх, холбогдох байгууллагуудын бэлэн байдлыг хангах, сургалт зохион байгуулах нь чухал юм. Тэдгээр эрсдэлийг эрт илрүүлснээр Монгол улс болон бусад ардчилсан улс орнууд өөрсдийн ардчиллын дархлааг улам бэхжүүлэх, аливаа ардчилсан үйл явцын үнэн зөв байдлыг хамгаалах боломжтой болох юм.

ТАЙЛАНДЫН ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙГ АЖИГЛАЛАА

Тайланд улсад 2026 оны хоёрдугаар сарын 8-нд парламентын ээлжит бус сонгууль боллоо. Тайландын Сонгуулийн хорооны урилгаар Сонгуулийн ерөнхий хорооны зөвлөх Ч.Баттөмөр, Ахлах мэргэжилтэн Г.Ариунболд нар тус сонгуулийг ажиглалаа.

Сонгуулиар парламентын доод танхим болох 500 суудалтай Төлөөлөгчдийн танхимыг бүрдүүлсэн бөгөөд Засгийн газар байгуулахын тулд 251-ээс дээш суудал авах шаардлагатай байдаг. Урьдчилсан дүнгээр консерватив чиг баримжаатай Bhumjaithai нам 193 суудал авч хамгийн олон суудал авсан ч дангаараа Засгийн газар байгуулах боломж бүрдээгүй байна. Хоёрдугаарт People's Party нам 118 суудал авч, залуу сонгогчдын дэмжлэгийг илүүтэй авсан бол Pheu Thai нам 74 суудал авч гуравдугаарт бичигджээ.

Энэ удаагийн сонгуулийн нэг онцлог нь Үндсэн хуулийн шинэчлэлийн асуудал байв. Сонгуультай зэрэгцэн зохион байгуулсан бүх нийтийн санал асуулгаар 2017 онд батлагдсан Үндсэн хуулийг шинэчлэх үйл явцыг эхлүүлэхийг сонгогчдын дийлэнх нь буюу санал өгсөн сонгогчдын 65.4 хувь нь дэмжсэн байна.

Энэ удаагийн сонгуульд тойрогт нэр дэвшигч 3526, намын жагсаалтад 57 нам өрсөлдөв. Нийт 6500 гаруй санал авах байранд 97500 ажилтан ажилласан бөгөөд үүний 95 хувь нь сайн дурын ажилтнууд байлаа. Тайландын сонгогчдын нэрийн жагсаалтад 52 сая гаруй сонгогч бүртгэлтэй бөгөөд 34.6 сая сонгогч саналаа өгч, 65.4 хувийн ирцтэйгээр сонгууль өндөрлөв.



“АРДЧИЛАЛ, СОНГУУЛИЙН УДИРДЛАГЫН АСУУДАЛ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН БАГА ХУРАЛД ОРОЛЦЛОО

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Даваа-Очир тэргүүтэй төлөөлөгчид 2026 оны 1 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Энэтхэг улсын Шинэ Дели хотноо зохион байгуулагдсан “Ардчилал, сонгуулийн удирдлагын асуудал” сэдэвт олон улсын Бага хуралд оролцлоо.

Ардчилал, сонгуулийн төв байгууллагуудын өмнө тулгамдаж буй цаг үеийн асуудлуудаар Бага хуралд оролцсон төлөөлөгчид санал солилцож, өөр өөрийн улсын ололт амжилт, хуримтлуулсан туршлагаа хуваалцсанд энэхүү Бага хурлын ач холбогдол оршиж байв.

Бага хурлын үеэр Сонгуулийн ерөнхий хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Даваа-Очир Бүгд Найрамдах Энэтхэг улсын Сонгуулийн комиссын дарга Г.Кумартай хоёр талын уулзалт хийж, сонгуулийн төв байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг эрчимжүүлэх талаар санал солилцлоо. Сонгуулийн ерөнхий хорооны мэргэжилтэн, ажилтнуудыг сонгуулийн удирдлага, мэдээлэл-технологийн чиглэлээр Энэтхэгт богино хугацаагаар давтан сургах асуудлаар тодорхой ажил зохион байхаар тохиролцсон юм.

Энэхүү бага хуралд Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн гишүүн орнууд болон Ази, Номхон далайн орнууд, олон улсын байгууллагуудын төлөөлөл нийт 70 орчим орны төлөөлөгч, үүний дотор 42 орны сонгуулийн төв байгууллагын дарга, Шинэ Дели дэх 27 орны дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нар оролцлоо.



Ө.ЦЭРЭНДОРЖ:

СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА БАЙНГА Л ХАРДЛАГА, ШҮҮМЖЛЭЛ ДУНД АЖИЛЛАДАГ

Анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Улсаа тунхагласны түүхт 101 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Сонгуулийн ерөнхий хорооны ахмад ажилтан Өөдөөгийн Цэрэндоржид Монгол Улсын Гавьяат эдийн засагч цол хүртээсэн.

Гавьяат эдийн засагч Ө.Цэрэндоржтой цөөн хором ярилцлаа.

-Монгол Улсын Гавьяат эдийн засагч цол хүртсэнд тань баяр хүргэе. Таны төрж өссөн нутаг, сургууль соёл, ажил албаас яриагаа эхэлье.

-Баярлалаа. Би Завхан аймгийн Улаагчин сум, одоогийн Нөмрөг сумын нутагт малчны гэр бүлд төрж өссөн. Сумынхаа дунд сургуулийг дүүргээд Улаанбаатарт Эдийн засгийн дээд сургуулийн аж үйлдвэрийн инженер эдийн засгийн факультетад элсэн суралцсан. Тухайн үед (1967 он) Засгийн

газраас Хөдөө аж ахуйн нэгдлүүдийг эдийн засагчаар хангах арга хэмжээний тухай гаргасан тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эдийн засгийн дээд сургуульд өөр, өөр мэргэжлээр суралцаж байсан оюутнуудаас 56 хүнийг тэр үеийн Хөдөө аж ахуйн дээд сургуулийн инженер механикийн факультетын харьяанд түргэвчилсэн сургалтад хамруулж “Хөдөө аж ахуйн эдийн засагч” мэргэжил эзэмшүүлсэн хүний нэг нь би юм.

Сургуулиа төгсөөд Завхан аймгийн Хөдөө аж ахуйг удирдах газарт бүртгэлийн мэргэжилтэн, Тэс сумын "Дэлгэрэх", Тэлмэн сумын "Жаргалын зам" нэгдэлд эдийн засагч, Завхан Увс аймгийн намын хороо, МАН-ын Төв хороонд ажиллаж байв. Зах зээл эхэлсэн эхний жилүүдэд хувиараа бизнес эрхэлж байгаад 1994 онд Хөдөө Аж Ахуйн Яамны харьяанд шинээр байгуулсан "Сааль" концерний дэд захирал бөгөөд ерөнхий менежер, улмаар Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгийн ажлын албанд зөвлөх, Үнэт цаасны Хороо буюу одоогийн Санхүүгийн зохицуулах хороонд тасгийн дарга, Сонгуулийн ерөнхий хороонд ахлах референтээр ажиллаж байгаад гавьяаныхаа амралтад гарсан билээ.

-Сонгуулийн ерөнхий хороонд ажиллаж байсан түүх, дурсамжаасаа хуваалцаач.

-2002-2008 онд Сонгуулийн ерөнхий хороонд ажиллаж байсан түүхтэй. Тэр үед манайхан маш цомхон, бичээчээсээ эхлээд даргаа хүртэл зургаахан хүнтэй ажилладаг байлаа. Сонгуулийн байгууллагынхан маш ачаалалтай ажиллаж, сонгуулиудыг маш амжилттай зохион байгуулдаг. Гэхдээ ялагдсан нам, ялагдсан нэр дэвшигчийн зүгээс биднийг их хардаж, шүүмжилдэг байв. Гэвч хууль зөрчсөн нэг ч баримт олоогүй дээ. Ер нь сонгуулийн байгууллага байнга л хардлага, шүүмжлэл дунд ажилладаг юм. Ажлын газрын хажууд хэдэн зуун хүн ирээд туг лоозон барьж хашхирч орилсон, дайрч давшилсан нөхцөлд тайван сайхан суугаад ажиллана гэдэг хэцүү. Үүнийг сонгуулийн байгууллагад ажилласан хүн л ойлгох байх аа.

-Таныг цөөнгүй ном бичсэн уран бүтээлч гэдэг. Сонгуулийн байгууллагад ажиллаж байсан дурсамжаа буулгав уу?

-Би шүлэг яруу найраг, уран зохиол бичдэггүй. Дурсамжаа ч бичээгүй. Таны асуултад хариулахаар бодож байтал би бүүр 1973 оноос сонгуулийн ажилд оролцож эхэлсэн хүн юм байна лээ. 1973, 1975 онд Завхан аймгийн Тэс, Тэлмэн сумын нэгдэлд эдийн засагчаар ажиллаж байхдаа орон нутгийн сонгуулийн хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн даргаар, 1978 онд Завхан аймгийн сонгуулийн хорооны гишүүнээр, 1981 онд Увс аймгийн сонгуулийн хорооны даргаар ажиллаж орон нутагт Ардын их хурал, аймаг сумын Ардын хурлын сонгууль зохион байгуулах ажлыг удирдаж, удирдалцаж явлаа.

Тэр үед сонгуулийн нэг тойрогт нэг хүн нэр дэвшиж сонгогддог байсан тул хожмоо "томилолтын депутат" нэр зүүсэн хэрэг. Тэр нь одоо УИХ-ын гишүүдийн заримыг улс төрийн намуудаас гаргасан "нэрийн жагсаалт"-аар сонгодог болсонтой бараг адилхан юм шиг ээ. Мөн тэр үед дээрээс сонгогч нэг бүрийг сонгуульд заавал оролцуулах хатуу шаардлага тавьдаг байсан нь сонгууль зохион байгуулж байгаа тойрог хэсгийн хороонд ажиллагсдад том бэрхшээл учруулж байв. Жишээлбэл, 1981 онд АИХ-ыг сонгох сонгуулийн өдөр Тариалан сумын нэг малчин адуундаа яваад оройн 18 цаг хүртэл гэртээ ирэхгүй байгаа тухай мэдээлэл аваад тус сумынхан нийтээрээ хайсаар харанхуй болохын өмнөхөн мориноосоо унаж бэртээд хээр хэвтэж



байхад нь олж эмнэлэгт хүргээд саналыг нь авч байсан тохиолдол гарч байсан.

- Та эрхэлсэн ажил, мэргэжлийн сэдвээр ном товхимол, гарын авлага, хошуу нутгийнхаа түүх судалгааны холбогдолтой бүтээл 10 гаруйг туурвиж нийтийн хүртээл болгосон байна. "Ухуулагч" сэтгүүл, Завхан аймгийн "Туяа", Увс аймгийн "Тэргүүний малчин" сонин зэрэг төв орон нутгийн хэд хэдэн сонин сэтгүүлийн тэргүүн бичлэгийн шагналтан болж байсан юмаа даа ?

- Тийм ээ. Зөвхөн ажил мэргэжлийн холбогдолтой сэдвээр ухуулга сурталчилгааны шинжтэй цөөн товхимол бичиж хэвлүүлсэн. Харин сүүлийн үед аймаг хошууныхаа түүхийг сонирхох болж Улсын архив, Үндэсний төв номын сан, Түүхийн хүрээлэнгийн архив, Тагнуулын тусгай архив, Батлан хамгаалахын архив, Хилийн цэргийн архив, МАН-ын архив, Завхан аймгийн архив зэрэгт ажиллаж өөрийнхөө хошуу сумын түүхийн холбогдолтой баримт бичгүүдтэй танилцаж энэ сэдвээр хэд хэдэн ном бичсэн. Мөн түүхийн ач холбогдолтой хэд хэдэн баримт бичгийг монгол бичгээс кирилл бичигт буулгаж судалгааны эргэлтэд оруулсан.

Төгсгөлд нь Сонгуулийн ерөнхий хороонд ажилласан 6 жил гаруй хугацаанд эв найрамдалтай, бие биеэ ойлгосон, ажлаа мэддэг, өндөр боловсролтой, ажилсаг нямбай залуустай ажиллахад урамтай сайхан байсныг тэмдэглэх учиртай.

УЛС ТӨРИЙН НАМЫН 2025 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР УЛИРЛЫН ХАНДИВ

Улс төрийн намын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт нам иргэн, хуулийн этгээдээс хүлээн авсан хандивын мэдээллээ өөрийн цахим хуудсандаа хайлт хийх боломжтой нээлттэй өгөгдлийн санд улирал тутам байршуулж, Сонгуулийн төв байгууллагад ирүүлэхээр хуульчилсан.

Хуулийн дээрх зохицуулалтын дагуу Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй 37 намаас 2025 оны 4 дүгээр улирлын хандивын тайлангаа 29 нам Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлсэн бөгөөд үүнээс 14 нам хандив хүлээн авч, 15 нам хандив аваагүй гэж тайлагнасан байна. Мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэгт Сонгуулийн төв байгууллага энэ

хуулийн 34.1-д заасан мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор цахим хуудсандаа нийтэлж, ил тод, нээлттэй байлгана гэж заасны дагуу тус Хорооны цахим хуудас (m-election.mn)-нд улс төрийн намуудын хандивын мэдээллийг байршуулж, ил тод, нээлттэй мэдээлэн ажиллаж байна.

Хандивын мэдээлэлтэй
<https://m-election.mn/handiv>
холбоосоор орж, танилцах
боломжтой юм.



УЛС ТӨРИЙН НАМЫН 2025 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ХАНДИВЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

(төгрөгөөр)

№	Улс төрийн нам	Хандивын төрөл	Хандивлагчийн төрөл	Хандивын нэгтгэсэн хэмжээ
1	Монгол Ардын Нам	Мөнгөн	Иргэн	310,149,000
2	Ардчилсан Нам	Мөнгөн	Иргэн	204,165,800
3	Монголын Ногоон Нам	Мөнгөн	Иргэн	134,850,000
4	Иргэний Зориг Ногоон Нам	Мөнгөн	Иргэн	66,360,000
5	Монголын Уламжлалын Нэгдсэн Нам	Хандив аваагүй		
6	Монголын Либерал Ардчилсан Нам	Хандив аваагүй		
7	Эх орон нам	Хандив аваагүй		
8	Монголын Либерал Нам	Тайлан ирүүлээгүй		
9	Бүгд Найрамдах Нам	Тайлан ирүүлээгүй		
10	Монголын эмэгтэйчүүдийн үндэсний нэгдсэн нам	Тайлан ирүүлээгүй		
11	Монголын Социал Демократ Нам	Мөнгөн	Иргэн	4,902,000
12	Ард түмний нам	Хандив аваагүй		
13	Монгол Үндэсний Ардчилсан Нам	Мөнгөн	Иргэн	35,640,000
		Мөнгөн бус	Иргэн	7,993,000

№	Улс төрийн нам	Хандивын төрөл	Хандивлагчийн төрөл	Хандивын нэгтгэсэн хэмжээ
14	Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам	Мөнгөн	Иргэн	310,000
15	ИХ нам	Мөнгөн	Иргэн	21,500,000
		Мөнгөн бус	Иргэн	16,890,000
16	Хөгжлийн хөтөлбөр нам	Мөнгөн бус	Иргэн	700,000
17	Монголын Ардчилсан Хөдөлгөөний нам	Тайлан ирүүлээгүй		
18	Хамуг Монголын Хөдөлмөрийн Нам	Тайлан ирүүлээгүй		
19	ХҮН нам	Мөнгөн	Иргэн	114,708,000
		Мөнгөн	Хуулийн этгээд	139,960,000
		Мөнгөн бус	Хуулийн этгээд	27,500,000
20	Эх орончдын нэгдсэн нам	Хандив аваагүй		
21	Монгол Консерватив нам	Хандив аваагүй		
22	Тусгаар тогтнол, эв нэгдлийн нам	Мөнгөн	Иргэн	100,000
23	Ард Түмний Хүч Нам	Хандив аваагүй		
24	Монголын Хүний Төлөө Нам	Хандив аваагүй		
25	ҮНЭН БА ЗӨВ НАМ	Хандив аваагүй		
26	Эрх чөлөөний эвсэл нам	Хандив аваагүй		
27	Дэлхийн Монголчууд Нам	Хандив аваагүй		
28	Ард Түмний Олонхийн Засаглал Нам	Мөнгөн	Иргэн	5,200,000
		Мөнгөн бус	Иргэн	1,300,000
29	Их эв нам	Хандив аваагүй		
30	Гэр Хороолол Хөгжлийн Нам	Хандив аваагүй		
31	Миний Монгол Нам	Хандив аваагүй		
32	Монгол Шинэчлэлт нам	Тайлан ирүүлээгүй		
33	ШИНЭ Нам	Мөнгөн	Иргэн	128,000,000
		Мөнгөн бус	Иргэн	6,500,000
34	Зүй Ёс Нам	Тайлан ирүүлээгүй		
35	Ардчилал Шинэчлэлийн Нам	Тайлан ирүүлээгүй		
36	Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам	Мөнгөн	Иргэн	558,000
37	Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн нам	Хандив аваагүй		

УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ОЛОН УЛСАД ЯМАР ТҮВШИНД БАЙНА ВЭ?

Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал нь дэлхий дахинд ардчиллын чанарыг хэмжих нэгэн чухал шалгуур үзүүлэлт юм. Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (International IDEA)-ийн улс төрийн санхүүжилтийн мэдээллийн санд дурдсанаар, дэлхийн 181 улсаас 143 улсад улс төрийн намууд санхүүгээ тогтмол тайлагнах хууль эрх зүйн зохицуулалттай. Үүнээс 116 улсад тайлагнасан мэдээллийг олон нийтэд нээлттэй байхаар зохицуулсан байдаг.

Монгол Улс 2023 онд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаар улс төрийн намуудын санхүүгийн тайлагнал, ил тод байдлыг эрх зүйн хүрээнд анх удаа тогтвортой, системтэйгээр нийтэд нээлттэй болох эхлэл тавигдаад байна.

МОНГОЛ УЛСАД УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ХЭРХЭН ЗОХИЦУУЛАГДСАН БЭ?

Сонгуулийн төв байгууллагын тухай хууль (2006)-ийн 2023 оны нэмэлт өөрчлөлтөөр Сонгуулийн ерөнхий хороо нь улс

төрийн намуудын санхүүгийн тайланд хяналт тавих эрхийг хэрэгжүүлэх болж, 2023 онд батлагдсан Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу Сонгуулийн ерөнхий хороо нь намуудын санхүүгийн тайланг хянаж, дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлэх болсон. Сонгуулийн ерөнхий хороо нь жил бүрийн 05 дугаар сард багтаан өөрийн цахим хуудсанд намын санхүүгийн тайлан, үйл ажиллагааны товч тайланг нийтэлнэ.

Мөн улс төрийн нам өөрийн санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайлан, гишүүн, хандивын мэдээлэл зэргийг ил тод, нээлттэй байлгаж, цахим хуудсандаа тухай бүр шинэчлэн нийтлэх үүрэгтэй. Түүнчлэн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчид сонгуулийн хандив, сонгуулийн зардлын тайлангаа Үндэсний аудитын газарт тайлагнах үүрэгтэй. Үүнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль (2020), Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль (2019), Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль (2020)-д тус тус зааж өгсөн. Үндэсний аудитын газар нь тайланг хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг ил тод мэдээлэх үүрэгтэй.



Тунгаахуй

"УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ИЛ ТОД БАЙДАЛ" ӨГӨГДЛИЙН ДҮРСЛЭЛИЙН ҮЗЭСГЭЛЭН
"TRANSPARENCY OF POLITICAL PARTY FINANCING" data visualization exhibition

УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ БАЙДАГ УУ?
IS INFORMATION ON POLITICAL FINANCING PUBLICLY ACCESSIBLE?



Эх сурвалж: Улс төрийн санхүүжилтийн мэдээллийн сан (<https://www.idea.int/>), 2025 оны 6-р сарын байдлаар, Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (International IDEA)
Source: Political Finance Database (<https://www.idea.int/>), as of June 2025, International IDEA
Өгөгдлийн дүрслэлийг Тунгаахуй өгөгдлийн урланд бүтээв.
Data visualization was created by Tungaahui Data Studio

Тайлбар: Ашиглах нөхцөл: © Тунгаахуй өгөгдлийн урлан ХХК 2025 | CC BY-ND 4.0

Өгөгдлийн дүрслэлийг бүтнээр нь, зохиогчийг дурдах нөхцөлтэйгөөр чөлөөтэй ашиглах, нийтлэх, түгээх боломжтой. Өөрчлөлт оруулах, хувиргах, хэсэгчлэн ашиглах, тухайн бүтээлд үндэслэн үүсмэл бүтээл үүсгэхийг хориглоно. Өгөгдлийн дүрслэлд орсон бүх байгууллагын лого нь зөвхөн таних зориулалттай бөгөөд зохиогчийн эрх болон лицензийн хамгаалалтад хамаарахгүй.

ГАДААД ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛИАС...



Япон Улс

81 дүгээр зүйл.

Дээд шүүх нь хууль, тогтоол, журам болон бусад албан шийдвэрийг Үндсэн хуульд нийцсэн эсэх талаар эцсийн шийдвэр гаргана.

79 дүгээр зүйл.

Дээд шүүх нь Ерөнхий шүүгч болон хуульд заасан тооны бусад шүүгчдээс бүрдэх бөгөөд Ерөнхий шүүгчээс бусад шүүгч нарыг Засгийн газар томилно.

Дээд шүүхийн шүүгчдийн талаар томилогдсоноос нь хойш болсон анхны Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн сонгуулийн үеэр ард иргэдийн хэлэлцүүлэг явуулах ба арван жилийн хугацаа өнгөрөхөд мөн Төлөөлөгчдийн танхимын сонгогчдын гишүүдийн ерөнхий сонгуулийн дараа дахин хэлэлцүүлэг явуулах ба энэ ажиллагааг арван жил тутам явуулна.

Дээр дурдсан ажиллагааны үеэр сонгогчдын олонхийн саналаар шүүгчийг ажлаас чөлөөлөх талаар санал гаргасан тохиолдолд түүнийг огцруулна. Хэлэлцүүлэг явуулахтай холбогдсон асуудлыг хуулиар зохицуулна.

Дээд шүүхийн шүүгчийн тэтгэвэрт гарах насыг хуулиар тогтооно. Шүүгч нар тогтмол тогтоосон хугацаанд урамшуулал авах ба түүний хэмжээг түүний бүрэн эрхийн хугацаанд бууруулахгүй.

82 дугаар зүйл.

Шүүн таслах ажиллагаа болон шийдвэр нь олон нийтэд нээлттэй байна. Шүүн таслах үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй хийх нь нийгмийн дэг журам, зан суртахуунд аюултай гэж шүүхээс үзвэл хаалттай явуулж болно. Улс төрийн гэмт хэрэг, хэвлэл мэдээлэл, эсхүл Үндсэн хуулийн 3 дугаар бүлэгт баталгаажуулсан хүний эрхтэй холбоотой шүүн таслах ажиллагааг заавал нээлттэй явуулна.



МОНГОЛ УЛСЫН
ҮНДСЭН ХУУЛЬ

Тавьдугаар зүйл.

2.Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ.

Тавин нэгдүгээр зүйл.

1.Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.
2.Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.

3.Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно.

4.Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно.

Тавин дөрөвдүгээр зүйл.

Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэнэ.



Бүгд Найрамдах Финланд Улс

100 дугаар зүйл.

Улсын Дээд шүүх болон Захиргааны хэргийн дээд шүүхийн бүрэлдэхүүн

Улсын Дээд шүүх болон Захиргааны хэргийн дээд шүүх нь шүүхийн ерөнхийлөгч болон шаардлагатай тооны шүүгчдээс бүрдэнэ.

Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Дээд шүүх болон Захиргааны хэргийн дээд шүүх хэргийг таван шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэнэ.

102 дугаар зүйл. Шүүгчийг томилох

Хуульд Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч томилохоор заасан шүүгчдийг хуульд заасан холбогдох журмын дагуу томилно. Бусад шүүгчийг томилох асуудлыг хуулийн дагуу зохицуулна.

99 дүгээр зүйл.

Улсын дээд шүүх болон Захиргааны хэргийн дээд шүүхийн чиг үүрэг

Иргэн, арилжааны болон эрүүгийн хэрэг, маргааныг Улсын дээд шүүх эцэслэн шийдвэрлэнэ. Захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх хэрэг, маргааныг Захиргааны хэргийн дээд шүүх эцэслэн шийдвэрлэнэ.

Дээд шүүхүүд нь тус тусын харьяалан шийдвэрлэх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэдэг бусад шүүхийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

104 дүгээр зүйл. Прокурор

Прокурорын байгууллагыг хамгийн дээд шатны прокурор болох Ерөнхий прокурор удирдана. Ерөнхий прокурорыг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн томилно. Прокурорын албатай холбоотой бусад асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулна.



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Тавин нэгдүгээр зүйл.

1.Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.

Тавин нэгдүгээр зүйл.

2.Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.

Тавьдугаар зүйл.

2.Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ.

Тавин зургадугаар зүйл.

1.Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.

2.Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.

3.Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

UIN.MN
СҮДАЛГААНЫ САН



Бүгд Найрамдах Итали Улс

102 дугаар зүйл.

Ердийн шүүгчийн шүүн таслах ажиллагаа явуулах эрхийг шүүх үйл ажиллагаанд хамаарах заалтаар зохицуулна.

Онцгой болон тусгай шүүх байгуулахгүй. Энгийн шүүхийн хэсэг дотор зөвхөн тодорхой зүйлээр мэргэшсэн тусгай хэсгийг байгуулж болох ба эдгээр хэсэгт шүүхийн гишүүн бус мэргэшсэн иргэнийг оролцуулж болно.

Шүүн таслах ажиллагаанд оролцох иргэний шууд оролцооны хэлбэр, тохиолдлыг хуулиар зохицуулна.

105 дугаар зүйл.

Шүүхийн Дээд Зөвлөл нь шүүхийн үйл ажиллагааны журамд заасны дагуу шүүгчийг ажилд авах, шилжүүлэх, өөрчлөх, урамшуулах болон шүүгчид сахилгын арга хэмжээ авна.

106 дугаар зүйл.

Шүүгчийг сонгон шалгаруулалтаар томилно.

Шүүхийн үйл ажиллагааны журмын тухай хуульд заасны дагуу сонгууль явуулж, хүндэт шүүгчийн бүх чиг үүргийг гүйцэтгэх нэг шүүгчийг томилно. Шүүхийн Дээд Зөвлөлөөс санал болгосноор, их сургуулийн профессор, хуульч мэргэжлээр 15-аас доошгүй жил ажиллаж буй хуульч, дээд шүүхийн тусгай мэргэжлийн албанд бүртгэгдсэн болон ололт амжилт бүхий Кассацийн зөвлөх дундаас томилно.



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Дөчин долдугаар зүйл.

1. Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.

Дөчин долдугаар зүйл.

2. Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно.

3. Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна.

Дөчин есдүгээр зүйл.

1. Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.

Тавин нэгдүгээр зүйл.

2. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Дөчин наймдугаар зүйл.

1. Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.

Дөчин есдүгээр зүйл.

6. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.

Тавин нэгдүгээр зүйл.

2. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.



Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

92 дугаар зүйл.

Шүүх эрх мэдлийг шүүгчид хариуцан хэрэгжүүлнэ.

Холбооны улсын Үндсэн хуулийн шүүх энэхүү Үндсэн хуульд заасан Холбооны улсын шүүх болон мужийн шүүх шүүх эрх мэдлийг хэрэгжүүлнэ.

101 дүгээр зүйл.

(1) Хуулиас гадуур шүүх байгуулахгүй. Хэний ч хууль ёсны шүүхэд хандах эрхийг хаан боогдуулж болохгүй.

(2) Тусгай хэргээр дагнасан шүүхийг гагцхүү хуулиар байгуулж болно.

97 дугаар зүйл.

Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.

98 дугаар зүйл

(4) Мужийн шүүгч томилох асуудлыг Хууль зүйн сайд шүүгчдийг шалгаруулах хороотой хамтран шийдвэрлэх талаар муж хуульчлан тогтоож болно.

2026 ОНД ДЭЛХИЙН УЛС ОРНУУДАД БОЛОХ БҮХ НИЙТИЙН СОНГУУЛЬ

Захиргаа, удирдлагын газрын референт Б.УЯНГА

Эх сурвалж: Сонгуулийн тогтолцооны олон улсын хүрээлэн(IFES)



БАРБАДОС

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-02-11

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2022-01-19

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
255,833



БАНГЛАДЕШ

Сонгуулийн төрөл: Бүх
нийтийн санал асуулга

Огноо: 2026-02-12

Товлон баталгаажсан эсэх:
Тийм



БАНГЛАДЕШ


Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-02-12

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2024-01-07

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
119,691,633



ЛАОС

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-02-22

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2021-02-21

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
4,280,000



НЕПАЛ

Сонгуулийн төрөл:
Парламент – Төлөөлөгчдийн
танхим

Огноо: 2026-03-05

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2022-05-13

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
17,988,570



ШВЕЙЦАРЬ

Сонгуулийн төрөл: Бүх
нийтийн санал асуулга

Огноо: 2026-03-08

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2025-11-30

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
5,620,065



КОЛУМБ

Сонгуулийн төрөл:
Парламент – Сенатын
танхим

Огноо: 2026-03-08

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2022-03-13

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
38,819,901



КОЛУМБ

Сонгуулийн төрөл:
Парламент – Төлөөлөгчдийн
танхим

Огноо: 2026-03-08

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2022-03-13

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
38,819,901

**ВЬЕТНАМ**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-03-15

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2021-05-23

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
69,523,133

**КОНГО**


Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгч

Огноо: 2026-03-22

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2021-03-21

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
2,645,283

**СЛОВЕНИ**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-03-22

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2022-04-24

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
1,695,771

**ИТАЛИ**

Сонгуулийн төрөл: Бүх
нийтийн санал асуулга

Огноо: 2026-03-22

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2025-06-08

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
45,997,941

**УНГАР**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-04-12

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2022-04-03

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
8,215,304

**ПЕРУ**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-04-12

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2021-04-11

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
25,287,954

**ПЕРУ**

Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгч

Огноо: 2026-04-12

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2021-04-11

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
25,287,954

**БЕНИН**

Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгч

Огноо: 2026-04-12

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2021-04-11

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
4,802,303

**НИУЭ**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-04-30

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2023-04-29

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
1,167

**КАБО ВЭРДЭ**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-04-30

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2021-04-18

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
392,899

**ЖИБУТИ**

Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгч

Огноо: 2026-04-30

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2021-04-09

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
215,687

**ШОТЛАНД (ИБУИНХУ)**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-05-07

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2021-05-06

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
4,280,785

**ВЭЙЛЬС (ИБУИНХУ)**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-05-07

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2021-05-06

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
2,389,879

**КИПР**

Сонгуулийн төрөл: Парламент
– Төлөөлөгчдийн танхим

Огноо: 2026-05-31

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2021-05-30

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
557,836

**КОЛУМБ**

Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгч

Огноо: 2026-05-31

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2022-06-19

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
39,002,239

**ЛЭБАНОН**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-05-31

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2022-05-15

**СОМАЛИЛАНД**

Сонгуулийн төрөл:
Парламент – Төлөөлөгчдийн
танхим

Огноо: 2026-05-31

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2019-11-30

**ЭТИОП**

Сонгуулийн төрөл:
Парламент – Төлөөлөгчдийн
танхим

Огноо: 2026-06-01

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2021-06-21

**АРМЕНИ**


Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-06-07

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2021-06-20

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
2,595,334

**ШВЕЙЦАРЬ**

Сонгуулийн төрөл: Бүх
нийтийн санал асуулга

Огноо: 2026-06-14

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2026-03-08

**АЛЖИР**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-06-30

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2021-06-12

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
24,425,187

**АРМЕНИ**

Сонгуулийн төрөл: Бүх
нийтийн санал асуулга

Огноо: 2026-06-30

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2020-04-05

**ЗАМБИА**

Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгч

Огноо: 2026-08-13

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2021-08-12

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
7,023,499

**ЗАМБИА**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-08-13

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2021-08-01

**ГАЙТИ**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-08-30

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2015-10-25

**ГАЙТИ**

Сонгуулийн төрөл:
Парламент – Сенатын
танхим

Огноо: 2026-08-30

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2015-10-25

**ГАЙТИ**

Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгч

Огноо: 2026-08-30

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2016-11-20

**ШВЕД**


Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-09-13

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2022-09-11

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
7,775,390

**ШВЕЙЦАРЬ**

Сонгуулийн төрөл: Бүх
нийтийн санал асуулга

Огноо: 2026-09-27

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2026-06-14

**МОРОККО**

Сонгуулийн төрөл:
Парламент – Төлөөлөгчдийн
танхим

Огноо: 2026-09-30

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2021-09-08

**ОРОС**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-09-30

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2021-09-19

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
109,204,662

**САО ТОМЭ ПРИНСИПИ**

Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгч

Огноо: 2026-09-30

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2021-09-05

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
123,301

**САО ТОМЭ ПРИНСИПИ**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-09-30

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2022-09-25

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
123,302

**БАХАМА**


Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-09-30

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2021-09-16

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
194,525

**ЧЕХ**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-09-30

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2024-09-27

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
2,239,246

**ЛАТВИ**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-10-03

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2022-10-01

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
1,542,407

**ЛАТВИ**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-10-03

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2022-10-01

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
1,542,407

**БРАЗИЛ**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-10-04

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2022-10-02

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
155,557,422

**БРАЗИЛ**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-10-04

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2022-10-02

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
155,557,422

**БРАЗИЛ**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-10-04

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2022-10-30

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
156,453,354

**ИЗРАИЛЬ**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-10-27

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2022-11-01

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
6,788,804

**БОСНИА ГЕРЦЕГОВИНА**


Сонгуулийн төрөл:
Парламент – Төлөөлөгчдийн танхим

Огноо: 2026-10-31

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2022-10-02

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
3,368,666

**ДАНИ**

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-10-31

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2022-11-01

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
4,269,048

**КАБО ВЭРДЭ**

Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгч

Огноо: 2026-10-31

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2021-10-17

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
398,865

**БОСНИА ГЕРЦЕГОВИНА**

Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгч

Огноо: 2026-10-31

Товлон баталгаажсан эсэх:
Үгүй

Сүүлд явагдсан сонгууль:
2022-10-02

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
3,368,666

**ГУАМ АРАЛ**


Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2026-11-03

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2024-11-05

Бүртгэлтэй сонгогчийн тоо:
62,098


**АНУ**

Сонгуулийн төрөл:
Парламент – Сенатын танхим

Огноо: 2026-11-03

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2024-11-05

**АНУ**

Сонгуулийн төрөл:
Парламент – Төлөөлөгчдийн танхим


Огноо: 2026-11-03

Товлон баталгаажсан эсэх:
Тийм

Сүүлд явагдсан сонгууль:
2024-11-05

**УМАРД МАРИАНЫН АРАЛ**

Сонгуулийн төрөл: Захирагч

Огноо: 2026-11-03Товлон баталгаажсан эсэх:
ТиймСүүлд явагдсан сонгууль:
2022-11-25Бүртгэлтэй сонгогчийн тоо:
19,275**УМАРД МАРИАНЫН АРАЛ**Сонгуулийн төрөл:
Парламент – Төлөөлөгчдийн
танхим**Огноо: 2026-11-03**Товлон баталгаажсан эсэх:
ТиймСүүлд явагдсан сонгууль:
2024-11-05Бүртгэлтэй сонгогчийн тоо:
18,401**УМАРД МАРИАНЫН АРАЛ**Сонгуулийн төрөл:
Парламент – Сенатын
танхим**Огноо: 2026-11-03**Товлон баталгаажсан эсэх:
ТиймСүүлд явагдсан сонгууль:
2024-11-05Бүртгэлтэй сонгогчийн тоо:
18,401**ШИНЭ ЗЕЛАНД**Сонгуулийн төрөл:
Парламент – Төлөөлөгчдийн
танхим**Огноо: 2026-11-07**Товлон баталгаажсан эсэх:
ТиймСүүлд явагдсан сонгууль:
2023-10-14Бүртгэлтэй сонгогчийн тоо:
3,480,698**ШВЕЙЦАРЬ**Сонгуулийн төрөл: Бүх
нийтийн санал асуулга**Огноо: 2026-11-29**Товлон баталгаажсан
эсэх: ҮгүйСүүлд явагдсан
сонгууль: 2026-09-27**БОЛГАР**Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгч**Огноо: 2026-11-30**Товлон баталгаажсан
эсэх: ҮгүйСүүлд явагдсан
сонгууль: 2021-11-21
Бүртгэлтэй
сонгогчийн тоо:
6,672,935**БАХРАИН**Сонгуулийн төрөл:
Парламент –
Төлөөлөгчдийн танхим**Огноо: 2026-11-30**Товлон баталгаажсан
эсэх: ҮгүйСүүлд явагдсан
сонгууль: 2022-11-12**ГАМБИЯ**Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгч**Огноо: 2026-12-05**Товлон баталгаажсан
эсэх: ТиймСүүлд явагдсан
сонгууль: 2021-12-04Бүртгэлтэй
сонгогчийн тоо:
962,157**УМАРД СУДАН**Сонгуулийн төрөл:
Парламент**Огноо: 2026-12-22**Товлон баталгаажсан
эсэх: Үгүй**УМАРД СУДАН**Сонгуулийн төрөл:
Парламент**Огноо: 2026-12-22**Товлон баталгаажсан
эсэх: Үгүй**УМАРД СУДАН**Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгч**Огноо: 2026-12-22**Товлон баталгаажсан
эсэх: Үгүй**ФАРОЕ АРАЛ**Сонгуулийн төрөл:
Парламент**Огноо: 2026-12-31**Товлон баталгаажсан
эсэх: ҮгүйСүүлд явагдсан
сонгууль: 2022-12-08
Бүртгэлтэй сонгогчийн
тоо: 39,020**СОМАЛИ**Сонгуулийн төрөл:
Парламент –
Төлөөлөгчдийн
танхим**Огноо: 2026-12-31**Товлон баталгаажсан
эсэх: Үгүй**СОМАЛИ**Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгч**Огноо: 2026-12-31**Товлон баталгаажсан
эсэх: Үгүй



Засгийн газрын 11 дүгээр байр
Ж.Самбуугийн гудамж,
Улаанбаатар – 15141, Монгол Улс

Санал хүсэлт хүлээн авах хаяг:
gescm@m-election.mn
(976) -51 262127

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ISSN 3106-4078

